




**ERDENE**  
RESOURCE DEVELOPMENT

0000001

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-03

БҮРТГЭВ-03



# НЭМЖ ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН  
TSX:ERD | MSE:ERDN

АНДЕРРАЙТЕР:



*Сервис*

2021 оны 08 дугаар сар



МХБ-ийн Гашуун  
Андеррайтер  
Г. Доржиев



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



## САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Зах зээлд арилжигдаж буй энгийн хувьцааны тоо ширхэг	274,404,183 (2021.07.31-ний байдлаар)
Арилжигдаж буй бирж	<ul style="list-style-type: none"> <li>Монголын хөрөнгийн бирж (МХБ) MSE:ERDN</li> <li>Торонтогийн хөрөнгийн бирж (ТХБ) TSX: ERD</li> </ul>
Санал болгож буй хувьцааны үнэ	<p>Үнэт цаас гаргагч нь Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг <b>ҮНЭ ТОГТОХ ӨДРӨӨР</b> тасалбар болгон Монголын хөрөнгийн бирж дэх өмнөх 10 өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10 хувийн хөнгөлөлттэй үнээр тогтооно.</p> <p>ТХБ/МХБ дээрх хувьцааны ханшийн хэлбэлзлээс хамаарч дээрх нөхцөл хангагдах боломжгүй болсон тохиолдолд СЗХ-ны шийдвэр гарахаас 3-с доошгүй өдрийн өмнө үнийг шинэчлэн тогтооно.</p>
МХБ-ийн ангилал	2-р ангилал
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгө	14,250,000,000 төгрөг буюу 5 сая ам.доллартай дүйцэх санхүүжилт
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Баян Хөндий төслийн бүтээн байгуулалт, хайгуул, ерөнхий удирдлагын зардал.
Анхдагч зах зээлд санал болгох хэлбэр	Нийтэд санал болгож буй хувьцааг тогтоосон үнийн аргаар 75 хүртэл хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх хувийг нийтэд хуваарилан анхдагч зах зээлд санал болгоно.

*Б.Серие*

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



20210827



ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN



### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Бирж бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

### УРЬДЧИЛСАН ТААМАГЛАЛ

Уг танилцуулга нь урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь дараах үгсээр тодорхойлогдоно. Үүнд: “урьдчилан сэрэмжлүүлэх”, “төлөвлөх”, “зорилго”, “итгэх”, “төсөвлөх”, “үнэлэх”, “тооцоолох”, “стратегий”, “ирээдүй”, “боломжит байдал”, “таамаглах”, (байх) зэрэг ирээдүй цагт хамааралтай үгсээр илэрхийлэгдэнэ.

Уг урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн Компанийн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан өнөөгийн үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү урьдчилсан таамаглалд тодорхой эрсдэлүүд болон тодорхойгүй байдлууд орох бөгөөд эдгээр эрсдэл, тодорхойгүй байдлуудын талаар Эрсдэлийн тухай хэсэгт танилцуулсан.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер БиДиСЕК ҮЦК ХК-д хандаж тодруулна уу.

2021.08.27

*Бүрмисе*

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА





ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ТОВЧ ХУРААНГУЙ

### Агуулга Хураангуй



**Эрдэнэ Ресурс  
Девелопмент  
Корпорейшн**  
/1.1, 1.5/

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн (“Эрдэнэ Ресурс” эсхүл “Үнэт цаас гаргагч” эсхүл “Компани”) нь Монгол Улсад өндөр агуулга бүхий суурь болон үнэт металлын хайгуул, олборлолт, худалдан авалт болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй уул уурхайн компани.

2000 онд үүсгэн байгуулагдаж, 2005 онд TSX үндсэн самбарт хувьцаагаа нээлттэй арилжиж эхэлсэн. 2018 оны 6 сард Монголын хөрөнгийн биржид үнэт цаасыг давхар бүртгүүлж, Монгол Улсын давхар бүртгэлтэй анхны компани болсон.



**Алсын хараа**  
/1.5.1/

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэх болон дэлхийн хязгаарлагдмал судлагдсан бүсэд өндөр агуулга бүхий үнэт болон суурь металлын нарийвчилсан хайгуулын хөтөлбөрүүд хэрэгжүүлэн дүүргийн хэмжээний боломжийг тодорхойлох хоёр стратегийн зорилтын хүрээнд ажилладаг.



**Тусгай зөвшөөрөл**  
/1.5.4/

Компани нь Баянхонгор аймгийн Шинэжинст ба Баян-Өндөр сумын нутагт орших Хөндий Алтны Дүүрэгт 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг 100% эзэмшдэг.



**Хүний нөөц**  
/1.3.4-1.3.6/

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг нь геологи, санхүү, уул уурхайн салбарт олон жил ажилласан туршлагатай хамт олон. Удирдлагын баг, ТУЗ нь компанийн хувьцааны ойролцоогоор 8 хувийг эзэмшдэг.



**Давхар бүртгэгдсэн нээлттэй компани**  
/1.4.1, 1.4.2/

Компани Монголын хөрөнгийн биржид /MSE:ERDN/, Торонтогийн хөрөнгийн биржид /TSX:ERD/ давхар бүртгэлтэй хувьцаат компани. Биржүүдийн хооронд хувьцааг хөрвүүлэн арилжих боломжтой.



**Төвлөрч буй төслүүд**  
/1.5.4/

Монгол Улсын Баянхонгор аймагт Хөндий алтны дүүрэгт алт, алт - полиметалл болон молибден-зэсийн төслүүдийг хөгжүүлж байна. Хөндий алтны дүүрэг нь дэлхийн томоохон алт-зэсийн ордуудыг агуулдаг Төв Азийн Орогенийн бүсийн хязгаарлагдмал судлагдсан хэсэгт байрладаг.

Хөндий алтны дүүрэгт байрлаж буй төслүүдийн хүдрийн биетүүдийн байрлалаас хамааран томоохон хэмжээний алтны бүлэг ордууд байх боломжтой гэж компани үздэг.

Гурван орд болон хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлсэн.

- Баян Хөндий алтны үндсэн орд;
- Алтан Нар алт-полиметаллын үндсэн орд;
- Зуун Мод молибден зэсийн порфирийн орд;

2021.10.27

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Берина*





ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



- Хар Морь алтны хэтийн төлөв бүхий хайгуулын талбай;
- Алтан Сум алтны хэтийн төлөв бүхий хайгуулын талбай;
- Хөвийн Хар зэс-мөнгөний хэтийн төлөв бүхий хайгуулын талбай;
- Улаан алт, зэс порфирийн хэтийн төлөв бүхий хайгуулын талбай;
- Хойд Хөндий ;
- Бусад анхан шатны хайгуулын төслүүд

#### Баян Хөндий

- Алтны нөөц: 409,000 (12.72 тн) унц (Батлагдсан & Магадалсан нөөц)
- Нөөцийн дундаж агуулга: 3.73 гр/тн алт
- Ил уурхайн аргаар олборлох боломжтой
- Төслийн хугацаа: 8 жил (Олборлолт 6 жил)
- Уламжлалт аргаар боловсруулах боломжтой, дундаж алт авалт: 93%
- Унц алтны нийт нэгжийн өртөг (AISC): 733 ам.дол/унц
- Капиталжуулах зардал: 63.8 сая ам.доллар, бүтээн байгуулалтын анхан шатны хөрөнгө оруулалт 59.2 сая ам.доллар (Нарийвчилсан ТЭЗҮ, 2020)
- Нарийвчилсан ТЭЗҮ дэх алтны үнийн төсөөлөл: 1,400 унц/ам.дол
- Ашиглалтын хугацаанд татварын дараах дотоод өгөөжийн түвшин (IRR): 42.4%, өнөөгийн үнэ цэн (5% хорогдуулалт бүхий; NPV) 100 сая ам.доллар
- Нэмэлт хайгуулаар нөөцийг тэлэх боломжтой.



Ашиглалтын шатанд хөгжүүлэхээр төлөвлөж буй төсөл /1.5.5, 2.6.1/

#### Алтан Нар

- 2015 онд нээн илрүүлсэн полиметаллын томоохон орд
- Геологийн нөөцийг тодорхойлохдоо алттай дүйцэх (AuEq) нэгжээр бодитой нөөц: 2.8 гр/тн AuEq агуулга бүхий 453,000 унц (14.09 тн), боломжтой нөөц: 2.5 гр/тн AuEq агуулга бүхий 277,100 мянган унц (8.63 тн) хэмээн тооцоолсон.
- Судалгаа хязгаарлагдмал хийгдсэн бөгөөд нийт 18 хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.
- Нэмэлт хайгуулын хөтөлбөрөөр нөөцийг тэлэх боломжтой.

#### Хар Морь

- Өрөмдлөгийн цооногийн ихэнх нь алтны эрдэсжилт огтолсон ба алтны өндөр агуулга бүхий цөөнгүй өрөмдлөгийн үр дүн гарсан.
- Хязгаарлагдмал судалгаа хийгдсэн ба нарийвчилсан өрөмдлөг хайгуул гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

#### Алтан Сум

- 2021 он хүртэл нийт 21 цооног (2,605 тууш метр) өрөмдсөнөөс 77% нь аномаль алт огтолсон.
- Энэхүү талбайн өрөмдлөгийн судалгаа нь талбайн гол структурын өндөр агуулгыг огтолсон өмнөд бүсэд төвлөрсөн, үүнд: 39 гр/тн алтны агуулга бүхий 1м интервал, 70 гр/тн алтны агуулга бүхий 2м интервал огтлогдсон.



Хэтийн төлөв бүхий талбай /1.5.6/

#### Улаан

- Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км x 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирийн төрлийн алт, зэсийн ордын хэтийн төлөвтэй хэмээн ойлгогддог.

2021:0827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Бсерица





- 2021 оны 8-р сард Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдсөн хэд хэдэн цооногт эрдэсжилт огтолсноор алтны шинэ нээлт хийв:
  - UDH-10 цооногийн 92 метрт 0.98 г/т алтны агуулга бүхий 258 метр интервал огтолсон нь 3.77 г/т алтны агуулга бүхий 40 метрийн интервал агуулж байна.
  - UDH-10 цооногоос урд зүгт 50 метрт өрөмдсөн UDH-07 цооногийн 85 метрээс эхлэн 0.63 г/т алтны агуулга бүхий 100 метрийн интервал огтолсон.



**Нийгмийн хариуцлага**  
/1.5.7/

Компани нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, орон нутгийн хамтын ажиллагааны чиглэлд төвлөрөн ажилладаг.

Байгаль орчны менежментийн хувьд Компани байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тогтмол гүйцэтгэн, хянаж, тухайн ашигт малтмалын төслийн хэрэгжилтийн хугацаанд шинэчлэн ажилладаг.

Компани нь өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдад төвлөрөн ажиллаж байгаа тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, амьжиргааг дэмжих, ажлын байр бий болгох зэргээр нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсээр ирсэн. Төсөл амжилттай хэрэгжсэнээр томоохон бүтээн байгуулалтыг эхлүүлэн ажлыг байр бий болох, орон нутгийн төсөвт татвар төвлөрүүлэх зэрэг ач холбогдолтой.



**Санхүүгийн мэдээлэл**  
/1.6/

KPMG нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн-ийн 2019, 2020 оны 12 сарын 31-ны байдлаарх нэгтгэсэн санхүүгийн нөхцөл байдал, нэгдсэн дэлгэрэнгүй алдагдлын тайлан, тухай жилд үүссэн өмчийн болон мөнгөн урсгалын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлого болон бусад тайлбарт мэдээллийн хураангуй бүхий тайлбараас бүрдсэн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийсэн.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн-ийн 2019, 2020 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн нэгдсэн тайлангуудад санхүүгийн нэгдсэн гүйцэтгэл, мөнгөний урсгал нь тухайн жилүүдэд Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудын дагуу үнэн зөв танилцуулж, Канад улсын зохих стандартын дагуу гүйцэтгэсэн тухайг тайландаа дурдсан.



**Эрсдэл**  
/3-р бүлэг/

Компанийн бизнесийн шинж чанар, хөгжлийн өнөөгийн түвшингээс хамааран тус Компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх нь эрсдэлтэй байх магадлалтай. Компанийн үнэт цаасыг худалдан авахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

- Хайгуул, ашиглалтын салбарын тодорхойгүй байдлын эрсдэл
- Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл
- Металлын үнийн хэлбэлзэл, түүнээс үүсэх эрсдэл
- Хууль эрх, зүйн орчны тогтворгүй байдлын эрсдэл
- Тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийн эрсдэл
- Валютын эрсдэл гэх мэт

L 2021:0827





ЭРДЭНЭ РЕСУРС ДИВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Андеррайтер:

**БИДИСЕК ҮЦК ХК**



Хаяг: БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр, Залуучуудын өргөн чөлөө

27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

Утас: (976) 11 313108

Вэбсайт: [www.bdsec.mn](http://www.bdsec.mn)

Хуулийн зөвлөх:

**ӨМГӨӨЛЛИЙН СНОУ ХИЛЛ КОНСАЛТАНСИ ХХН**



Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчилалын өргөө 6 давхар

Утас: (976) 77118193

Вэбсайт: [www.snowhill.mn](http://www.snowhill.mn)

Хараат бус хөндлөнгийн шинжээч:

**РОМА ОЙЛ МАЙНИНГ АССОШИЭЙТС ЛИМИТЕД**



Хаяг: 22/F., China Overseas Building, 139 Hennessy Road, Wan Chai, Hong Kong

Утас: +852 2529 6878 (ХонгКонг)

Вэбсайт: [www.romagroup.com](http://www.romagroup.com)

20210827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Всервис*





## Агуулга

<b>САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>2</b>
<b>ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ТОВЧ ХУРААНГУЙ</b> .....	<b>4</b>
<b>ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД</b> .....	<b>7</b>
<b>Андеррайтер:</b> .....	<b>7</b>
Хавсралт материалын жагсаалт .....	10
Хүснэгтийн жагсаалт .....	11
Зургийн жагсаалт .....	12
Схемийн жагсаалт .....	12
Графикийн жагсаалт .....	13
Товчилсон үгс, Мэргэжлийн нэр томъёо .....	14
<b>НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ</b> .....	<b>16</b>
Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл .....	16
Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл .....	16
1.3. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт .....	17
1.3.1. Холбоотой этгээд .....	17
1.3.2. Бүтэц зохион байгуулалт .....	18
1.3.3. Хөрөнгийн бүтэц .....	18
1.3.4. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл .....	19
1.3.5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт .....	20
1.3.6. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл .....	22
1.4. Гэрээ болон хамтын ажиллагаа .....	27
1.5. Хувьцааны мэдээлэл .....	29
1.5.1. Өмнө гаргасан хувьцааны мэдээлэл .....	29
1.5.2. Хувьцааны арилжааны мэдээлэл .....	30
1.5.3. Ногдол ашиг .....	32
1.6. Үндсэн үйл ажиллагааны танилцуулга .....	33
1.6.1. Алсын хараа .....	34
1.6.2. Үнэт зүйл .....	34
1.6.3. Компанийн түүх .....	35
1.6.4. Хөндий алтны дүүрэг .....	36
1.6.5. Ашиглалтын шатанд хөгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд .....	41
1.6.6. Хэтийн төлөв бүхий талбай .....	51
1.6.7. Байгууллагын нийгмийн хариуцлага .....	59
1.7. Санхүүгийн үзүүлэлтүүд .....	62
1.7.1. Санхүүгийн нэгтгэсэн тайлан .....	62
1.7.2. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн орчуулга .....	69
<b>ХОЁР. НЭМЖ ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААС</b> .....	<b>70</b>
2.1. Нэмж гарган санал болгож буй үнэт цаас .....	70
2.1.1. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл .....	72
2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг .....	73

L 2021:0827



*Бернел*



2.2.1.	Канад улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалт.....	74
2.3.	Нэмж үнэт цаас гаргахтай холбоотой эрх, үүргийн тухай.....	85
2.3.1.	Шаардах эрх.....	85
2.3.2.	Тэргүүн ээлж.....	85
2.4.	Үйл ажиллагааны төлөвлөгөө.....	86
2.4.1.	Стратеги, хэтийн төлөв.....	86
2.4.2.	Баян Хөндий төслийн төлөвлөгөө.....	87
2.4.3.	Төслийг тэлэх боломжууд.....	97
2.4.4.	Хайгуулын төлөвлөгөө.....	97
2.4.5.	Үнэлгээ өсөх боломж.....	97
2.4.6.	Зах зээлийн судалгаа.....	99
2.5.	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт.....	108
2.6.	Санхүүгийн төсөөлөл.....	110
2.7.	Үнэт цаасны арилжаа.....	112
2.8.	Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон этгээдүүд.....	113
2.8.1.	Андеррайтер.....	113
2.8.2.	Хуулийн зөвлөх компани.....	115
2.8.3.	Хуулийн дүгнэлт.....	117
2.8.4.	Хараат бус техникийн зөвлөх компани.....	118
	<b>ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА.....</b>	<b>119</b>
3.1.	Эрсдэлийн хүчин зүйлс.....	119
3.1.1.	Эрдсийн хайгуул, ашиглалтын салбарын эрсдэл.....	119
3.1.2.	Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл.....	119
3.1.3.	Монгол Улсын хууль, эрх зүйн орчны эрсдэл.....	119
3.1.4.	Тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрлийн эрсдэл.....	120
3.1.5.	Дэд бүтэцтэй холбоотой эрсдэл.....	120
3.1.6.	Үл даатгагдах эрсдэлүүд.....	121
3.1.7.	Ашиг сонирхлын зөрчил.....	121
3.1.8.	Валютын эрсдэл.....	121
3.1.9.	Металын үнийн хэлбэлзэл, түүнээс үүсэх эрсдэл.....	121
3.1.10.	Байгаль орчны болон зохицуулалтын шаардлагууд.....	122
3.1.11.	Боловсон хүчний эрсдэл.....	122
3.1.12.	Улс төрийн эрсдэл.....	122
3.1.13.	Уламжлалт эрсдэлүүд.....	123
3.1.14.	Өрсөлдөөн.....	123
3.1.15.	Эзэмшлийн хувь буурах.....	123
3.1.16.	Ковид-19-ийн нөлөөлөл.....	123
2.8.5.	Бүтээн байгуулалттай холбоотой эрсдэл.....	123
3.	Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө.....	124

L 2021:0827



*Бернесс*



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



### Хавсралт материалын жагсаалт

1	Эрдэнэ Ресурс Девелопмент ХК-ийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамтаар
2	Эрдэнэ Ресурс Девелопмент ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамтаар
3	Аниан Ресорсиз ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
4	Аниан Ресорсиз ХХК-ийн дүрмийн хуулбар
5	Эрдэнэ Монгол ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
6	Эрдэнэ Монгол ХХК-ийн дүрмийн хуулбар
7	Лидер Эксплорэйшн ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
8	Лидер Эксплорэйшн ХХК-ийн дүрмийн хуулбар
9	Компанийн өмнө гаргасан үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээлэл
10	Компанийн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарууд
11	Баянхөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ, NI 43-101 техникийн тайлан
12	Нөөц бүртгэсэн холбогдох тушаал, зөвшөөрөл
13	Баянхөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ, NI 43-101 техникийн тайлангийн орчуулга
14	2020 оны аудитын дүгнэлт, орчуулгын хамт
15	Сүүлийн 6 сарын тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл, орчуулгын хамтаар
16	МХБ-д нэмж үнэт цаас гаргаж буй талаар ТХБ-д мэдэгдсэн мэдэгдэл, орчуулгын хамтаар
17	Канад улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалтын талаар дүгнэлт
18	Андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
19	Андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
20	Андеррайтерийн гэрээний хуулбар
21	Андеррайтерийн дүгнэлт
22	Хуулийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
23	Хуулийн зөвлөх компанийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл
24	Хараат бус техникийн шинжээч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
25	Хуулийн дүгнэлт
26	Үнэт цаас гаргах тухай ТУЗ-ийн шийдвэр, тэмдэглэл
27	2021 оны 1-р хагасын санхүүгийн тайлан, орчуулгын хамтаар

20210827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Баянхөндий





ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл	16
Хүснэгт 2. Холбоотой этгээдийн мэдээлэл	17
Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл	20
Хүснэгт 4. Компанийн өмнө гаргасан энгийн хувьцааны мэдээлэл	29
Хүснэгт 5. Биржүүд дээрх хувьцааны ханшийн үзүүлэлт	32
Хүснэгт 6. Тусгай зөвшөөрөл	38
Хүснэгт 7. Баян Хөндий ордын үйлдвэрлэлийн нөөц	44
Хүснэгт 8. Баян Хөндий ордын геологийн нөөцийн тооцоолол	45
Хүснэгт 9. Алтан Нар ордын геологийн нөөцийн тооцоолол	49
Хүснэгт 10. Хар Морь талбайд хийсэн өрөмдлөгийн онцлох дүн: 2021 оны 1-р улирал	53
Хүснэгт 11. Хар Морийн Дэл (өмнөд) талбайн 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай)	53
Хүснэгт 12. 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтны агуулгатай)	55
Хүснэгт 13. Санхүүгийн байдлын тайлан	64
Хүснэгт 14. Ашиг алдагдлын тайлан	65
Хүснэгт 15. Мөнгөн гүйлгээний тайлан	66
Хүснэгт 16. Өмчийн өөрчлөлтийн тайлан	67
Хүснэгт 17. Биржүүд дээрх ханшийн үзүүлэлт	72
Хүснэгт 18. Капиталжуулах зардал	91
Хүснэгт 19. Ашиглалтын хугацаанд гарах алт үйлдвэрлэхтэй холбоотой нийт зардал	93
Хүснэгт 20. Баян Хөндий төслийн эдийн засгийн тооцооллын голлох үзүүлэлтүүд	95
Хүснэгт 21. Алтны үнээс хамаарсан NPV, IRR мэдрэмжийн шинжилгээ	96
Хүснэгт 22. Төв банкны алтны нөөцөөрөө тэргүүлэгч орнууд	100
Хүснэгт 23. Монгол Улсын алтны нөөц	106
Хүснэгт 24. Баян Хөндий төслийн мөнгөн урсгалын таамаглал	110
Хүснэгт 25. Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл	116
Хүснэгт 26. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн хуульчдийн гэрчилгээ	116

2021:0827





### Зургийн жагсаалт

Зураг 1. Хөндий Алтны Дүүргийн байршил.....	36
Зураг 2. Хөндий алтны дүүрэг дэх орд, хэтийн төлөв бүхий талбай .....	37
Зураг 3. Зүүн Төв Азийн Орогенийн бүслүүр, түүнд байрлах алт, зэсийн томоохоон ордууд .....	39
Зураг 4. Эдрэнгийн террейн.....	40
Зураг 5. Баян Хөндий ордын байршил, тусгай зөвшөөрлийн талбай.....	42
Зураг 6. Бага болон их сульфидтай эпитеpmаль ордын загвар.....	43
Зураг 7. Баян Хөндий ордод хийсэн өрөмдлөг .....	46
Зураг 8. Алтан Нар төслийн байршил, тусгай зөвшөөрлийн талбай .....	48
Зураг 9. Алтан Нар ордын хэтийн төлөв бүхий талбайнууд.....	50
Зураг 10. Хар Морь талбайн 2020 оны 2-р улирлын хайгуулын үр дүн.....	52
Зураг 11. Хар Морь хэтийн төлөв бүхий талбайн өрөмдлөгийн үр дүн 2021 оны 2-р улирал .....	54
Зураг 12. Улаан талбай геологийн тогтоц.....	56
Зураг 13. Улаан талбай: Байрлал, 2021 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээ .....	57
Зураг 14. Баян Хөндий ордын өндөр агуулга бүхий талбай.....	89
Зураг 15. Баян Хөндий төслийн уурхайн төлөвлөлт.....	89
Зураг 16. Баян Хөндий уурхайн боловсруулах үйлдвэрийн үйл явцын зураглал .....	90

### Схемийн жагсаалт

Схем 1. Холбоотой этгээдийн мэдээлэл.....	17
Схем 2. Бүтэц зохион байгуулалт.....	18
Схем 3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	19
Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүх.....	35
Схем 5. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө .....	86
Схем 6. Төслийн ерөнхий үйл ажиллагааны схем.....	87
Схем 7. Анхдагч зах зээлд санал болгох явц.....	112
Схем 8. Анхдагч зах зээлд захиалга өгөх.....	112

L 2021:0827



СЭХ

2021-09-03

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

0000013  
МОНГОЛЫН АЖИРАГЧИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-09-03

БҮРТГЭВ-03

**Графикийн жагсаалт**

График 1. Торонтогийн хөрөнгийн бирж дээрх сүүлийн 5 жилийн хувьцааны арилжаа	30
График 2. Монголын хөрөнгийн бирж дээрх 2018 оноос хойш хувьцааны арилжаа	31
График 3. МХБ, ТХБ-ийн ханшийн харьцуулсан үзүүлэлт	31
График 4. Уурхайн ашиглалтын хугацаанд олборлох хүдэр	92
График 5. Төслийн хугацаанд боловсруулах алтны хэмжээ	92
График 6. Баян Хөндий төслийн алт олборлох өртгийн задаргаа	93
График 7. Уурхайн үйл ажиллагааны зардлын задаргаа	94
График 8. Боловсруулах үйл ажиллагааны зардлын задаргаа	94
График 9. Төслийн мөнгөн урсгал	95
График 10. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл	96
График 11. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл	96
График 12. Дэлхийн алтны зах зээлийн эрэлт	99
График 13. Дэлхийн алтны зах зээл дээрх төв банкны нөөцийн хэмжээ (тонн)	100
График 14. Хөрөнгө оруулалтын чиглэлийн алтын эрэлт	101
График 15. Дэлхийн алтны зах зээлийн нийлүүлэлт	101
График 16. 2000-2020 оны алтны үнийн түүхэн үзүүлэлт (ам.доллар/унц)	102
График 17. Алтны үнийн төсөөлөл (ам.доллар/унц)	103
График 19. 2019 оны байдлаар алтны нийлүүлэлтээр тэргүүлэгч орнууд (тонн)	103
График 20. Ковид-19 цар тахлын үеийн алтны үйлдвэрлэлийн нөлөө	103
График 21. Алтны нийлүүлэлтээр тэргүүлэгч	104
График 21. Дотоодын нийт бүтээгдэхүүн /их наяд төгрөг/	104
График 23. Уул уурхайн салбарын орлогын төсөвт эзлэх хувь	105
График 23. Дотоодын нийт бүтээгдэхүүн, уул уурхайн салбарын эзлэх хувь /их наяд төгрөг/	105
График 24. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал /тэрбум. Ам.дол/	105
График 25- Гадаад валютын нөөц, /сая, ам.дол/	106
График 26. Алтны олборлолт болон экспорт, /тонн/	107
График 27. Монгол банкинд тушаасан алтны хэмжээ, /тонн/	107
График 28. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл	111
График 29. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл	111

2021:0827





ӨРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

ҮЦК	Үнэт цаасны компани
IRR	Internal rate of return эсхүл Дотоод өгөөжийн түвшин
IPO	Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгох
ХК	Хувьцаат компани
CAD	Канад доллар
MNT	Төгрөг
As	Хүнцэл
Cu	Зэс
Au	Алт
Pb	Хар тугалга
Mo	Молибден
Ag	Мөнгө
Zn	Цайр

**Хөрвүүлэх хүснэгт ба мэргэжлийн товчилсон үгс**

Уг Танилцуулгад багтсан тоо хэмжээ нь ихэвчлэн метрийн нэгжээр илэрхийлэгдсэн. Метрийн бус хэмжээснээс метрийн хэмжээсний хөрвүүлэг ба метрийн хэмжээснээс метрийн бус хэмжээсийн хөрвүүлгийг дараах байдлаар үзүүлэв.

Метрийн хэмжээс	Метрийн бус хэмжээс	Метрийн бус хэмжээс	Метрийн хэмжээс
0.4047 гектар ("га")	1 акр	2.47 акр	1 гектар
0.3048 метр ("м")	1 фут	3.28 фут	1 метр
1.609 километр ("км")	1 бээр	0.62 бээр	1 километр
0.0283 куб метр	1 куб фут	35.315 куб фут	1 куб метр
31.103 грамм ("г")	1 унц (трой)	0.032 унц	1 грамм
0.907 тон ("т")	1 тон (шорт)	1.102 тон	1 тон
34.28 гр/тнон ("гр/тн")	1 унц (трой/тон)	0.029 унц	1 грамм/тон
0.454 килограмм ("кг")	1 фунт	2.2 фунт	1 килограмм

**Баримт бичгүүдийн эх сурвалж ба линкүүд**

Танилцуулгад тусгасан баримт бичгүүдийг доорх эх сурвалж болон линкээс үзэж болно. Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) болон SEDAR (System for Electronic Document Analysis and Retrieval) [www.sedar.com](http://www.sedar.com)-оос танилцах боломжтой.

20210827

*Б.Сүрэн*





ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



## НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

### Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр:	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн ("Erdene Resource Development Corp.")
Хаяг:	(Metropolitan Place, Suite 1480, 99 Wyse Halifax, Nova Scotia, Canada, B3A AS5)
Утас:	1-902-423-6419
Төлбөргүй утас:	1-800-261-1422
Вебсайт:	<a href="http://www.erdene.com">www.erdene.com</a>
И-мэйл:	<a href="mailto:info@erdene.com">info@erdene.com</a>
Монгол Улс дахь төлөөлөгч:	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн, Эрдэнэ Монгол ХХК
Хаяг:	Монруд ХХК-ийн байр, Монгол Улс, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6
Утас:	976-11-319758
Факс:	976-11-315988
И-мэйл:	<a href="mailto:info@erdene.com">info@erdene.com</a>

### Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн" ("Эрдэнэ ресурс" эсхүл "Компани" эсхүл "Үнэт цаас гаргагч") нь 2000 оны 07 сарын 14-ний өдөр Канад Улсын "Бизнесийн байгууллагын хууль"-ийн дагуу "3779751 Canada Inc" нэрээр үүсгэн байгуулагдсан. 2003 оны 02 сарын 18-ны өдөр нэмэлт өөрчлөлтийг оруулан "Эрдэнэ Гоулд Инк" ("Erdene Gold Inc") болгож нэрээ өөрчлөн, 2008 оны 05 сарын 29-ний өдөр "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн" болгон өөрчилсөн.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, компанийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг Хавсралт №1,2-оос үзнэ үү.

2021:0827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Ваерини






### 1.3. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

#### 1.3.1. Холбоотой этгээд

Үнэт цаас гаргагч нь Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК гэсэн 2 охин компанитай бөгөөд охин компани Эрдэнэ Монгол ХХК нь Лидер Эксплорейшн ХХК-ийг 100% эзэмшиж байна. Үнэт цаас гаргагчид толгой болон зэргэлдээ компани байхгүй байна.

Схем 1. Холбоотой этгээдийн мэдээлэл



Хүснэгт 2. Холбоотой этгээдийн мэдээлэл

Нэр	РД	Эзэмшлийн хувь	Холбоо хамаарал	Хаяг
Аниан Ресорсиз ХХК	2874229	100%	Охин компани	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6, Эрдэнэ Монгол ХХК-ийн байр
Эрдэнэ Монгол ХХК	2718243	100%	Охин компани	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6, Эрдэнэ Монгол ХХК-ийн байр
Лидер Эксплорейшн ХХК	6183077	100%	Охин компанийн охин компани	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6, Эрдэнэ Монгол ХХК-ийн байр

Компанийн охин компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрмийн хуулбарыг Хавсралт №3, 4, 5, 6, 7, 8-аас үзнэ үү.

*Б.Сүрэн*




20210627



### 1.3.2. Бүтэц зохион байгуулалт

Схем 2. Бүтэц зохион байгуулалт



- Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо
- Цалин, урамшууллын хороо
- Төлбөр тооцооны хороо
- Компанийн засаглал, ил тод байдлын хороо
- Техникийн хороо

### 1.3.3. Хөрөнгийн бүтэц

Компанийн энгийн хувьцаа болон бусад хувьцаанд хөрвөх үнэт цаасны дүн 2021 оны 06 сарын 30-ны өдөр буюу эхний хагас жилийн тайланд дараах байдлаар тусгасан.

#### Энгийн хувьцаа

2021 оны 06 сарын 30-ны байдлаар компани нийт 268,550,433 ширхэг энгийн хувьцаатай байсан. (2021 оны 7 сарын 31-ны байдлаар компани 274,404,183 ширхэг энгийн хувьцаа ТХБ, МХБ дээр арилжигдаж байна)

#### Варрант

Компани 2021 оны 06 сарын 30-ны байдлаар 0.56 канад долларын жигнэсэн дундаж хэрэгжих үнэтэй, 50,771,102 ширхэг варрант гаргасан байна.

#### Опцион

Компани 2021 оны 06 сарын 30-ны байдлаар 0.45 канад долларын жигнэсэн дундаж хэрэгжих үнэтэй, 15,305,000 ширхэг опцион гаргасан байна.

#### DSU/Ирээдүйд олгогдох хувьцааны эрх

2021 оны 06 сарын 30-ны байдлаар 5,360,913 ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон байна.

### Энгийн хувьцаа эзэмшигчид

Компани нь 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар Монголын хөрөнгийн бирж болон Торонтогийн хөрөнгийн бирж дээр нийт 268,550,433 ширхэг энгийн хувьцааг гаргаад байна.

Нийт хувьцааны 64%-ийг хөрөнгө оруулалтын сангууд болон олон нийт эзэмшиж байна. 2020 онд 8 сард Эрик Спротт нь хаалттай хүрээнд 15 сая кан.долларын санхүүжилт хийж, томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг болсон. 2020 оны 10 сард Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD эсхүл ЕСБХБ) нь 5 сая ам.долларын дүн бүхий хөрвөх нөхцөлтэй зээлийн нөхцөлийн дагуу хөрвүүлэх опционыг хэрэгжүүлж, зээлийг Компанийн 30,043,290 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлсэн.


Эрдэнэ Ресурс нь Монголын хөрөнгийн бирж дээр анх 4,000,000 ширхэг хувьцааг санал болгон бүртгэгдсэн ба 2021 оны 05 сарын 14-ний өдрийн байдлаар Монгол улсад бүртгэлтэй 5,267 гаруй хувьцаа эзэмшигч байна.

*Берин*



20210827

Схем 3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц



- Энгийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар мэдээлэл авах, түүнд оролцох, санал өгөх эрхтэй.
- Энгийн хувьцаа гар өргөн санал тоолохоос бусад үед нэг саналын эрхтэй.
- Компанийн ТУЗ нь ногдол ашиг тараах эсэхийг шийдвэрлэх бөгөөд компани дампуурах, татан буулгах буюу үйл ажиллагаагаа зогсоовол ТУЗ зарласны дагуу энгийн хувьцаа эзэмшигчид Компанийн үлдсэн бүх хөрөнгийг эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хүлээн авах эрхтэй.
- Энгийн хувьцаа нь тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрх, аливаа үнэт цаасанд хөрвөх болон шаардах эрх олгодоггүйгээс гадна өр дарах /sinking fund/ эсвэл худалдан авах сангийн /purchase fund/ зориулалтыг агуулаагүй болно.

**Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох**

Хувьцаа эзэмшигчид нь Канад улсын зохих хууль эрхзүйн хүрээнд “Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч” эсвэл “Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч” байж болно. Компанийн энгийн хувьцаа нь хувьцаа эзэмшигчийн нэр дээр бус, зуучлагчийн нэр дээр бүртгэгдсэн бол “Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч” гэнэ. Зуучлагч нь ихэвчлэн зуучлалын ажиллагааг явуулдаг банк, итгэмжит компани, үнэт цаасны дилер эсвэл брокер, төлбөр тооцооны байгууллага байна. Хувьцаа эзэмшигч нь аль нэг иргэн эсвэл хуулийн этгээдийг (хувьцаа эзэмшигч байх албагүй) өөрийг нь төлөөлөн хуралд оролцох, санал өгөхөөр томилж болно.

Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хуралд хоёр хэлбэрээр оролцох ба үүнд биечлэн эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хуралд оролцож саналаа өгч болно. Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчид нь өөрийн зуучлагчаар дамжуулан түүнд зааварчилгаа өгсний үндсэн дээр санал өгөх боломжтой. Зуучлагч нь бүртгэлгүй хувьцаа эзэмшигчийг төлөөлж санал өгөхийн тулд өргөдөлд зааснаар итгэмжлэлийг хавсарган хүргүүлэх шаардлагатай.

Эрдэнэ Ресурс нь Монгол Улс дахь хувьцаа эзэмшигчид компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх эрхийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг түгээж, бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийг биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хуралдаа оролцож санал өгөх боломжийг бүрдүүлэн ажилладаг.


**1.3.4. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь найман гишүүнээс бүрдэх ба 6 гишүүн нь Канадын Үнэт Цаасны холбогдох хууль эрх зүйн шалгуурт нийцсэн “хараат бус” гишүүн буюу компанитай шууд болон шууд бус харилцаагүй этгээд байна.

*Бернис*

Андрей  
 Брокер, дилерийн  
 үйлчилгээний  
 үйлчилгээний  
 1115205447 205 482

L 2021-0827



Компанийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Петер К.Акерли болон 2019 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэл компанийн Дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгчөөр ажиллаж асан Кеннет МакДоналд нар ТУЗ-ийн хараат гишүүн байна.

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

№	Гишүүдийн нэр	Энгийн хувьцаа (хяналттай)	ТУЗ-ийн гишүүнд томилогдсон огноо	Гишүүнчлэл
1	Лэйтон Т.Крофт	1,228,478	2015 оны 07-р сарын 02-с хойш	ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн
2	Петер К.Акерли	2,879,199	2003 оны 2-р сарын 25-с хойш	Хараат гишүүн, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал
3	Кеннет В. МакДоналд	2,102,781	2019 оны 6-р сарын 20-с хойш	Хараат гишүүн, Санхүү хариуцсан захирал асан
4	Др. Анна Г.Биолик	131,462	2016 оны 6-р сарын 14-с хойш	Хараат бус гишүүн
5	Жон П.Бюрн	7,248,290	2004 оны 8-р сарын 25-с хойш	Хараат бус гишүүн
6	Камерон МакРэй	578,111	2018 оны 3-р сарын 14-с хойш	Хараат бус гишүүн
7	Дэвид В.Мошер	812,067	2016 оны 6 сарын 14-с хойш	Хараат бус гишүүн
8	Хэдли Виддап	N/A	2019 оны 9 сарын 30-с хойш	Хараат бус гишүүн

**1.3.5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт**

ТУЗ нь компанийн бизнесийн үйл ажиллагаа болон удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй. Канад Улсын “Үнэт цаасны тухай хууль”-ийн дагуу Компани нь засаглалын тухай мэдээллийг жил бүр тайлагнах үүрэгтэй. Компани нь өөрчлөгдөн хөгжихийн хэрээр сайн засаглал болон үндсэн үйл ажиллагаа, арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү үүргийг ТУЗ нь шууд болон дараах таван хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.



**Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо**

Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явц болон дотоод хяналтын системийг бие даасан, бодит байр сууринаас хянаж, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Мөн Компанийн санхүүгийн хэлтэс, удирдлага болон хөндлөнгийн аудиторуудыг холбох, ил тод байдлыг хангах болон хөндлөнгийн аудиторын ажил үүрэгт дотоод хяналт тавих үүрэгтэй. Хороо нь жилд дөрвөөс доошгүй удаа хуралддаг ба хараат бус гурван гишүүнээс бүрддэг. Үүнд:

- ✓ Жон П. Бюрн (John P.Byrne)
- ✓ Лэйтон Крофт (Layton Croft)
- ✓ Др. Анна Биолик (Dr. Anna Biolik)
- ✓ Кеннет МакДоналд (Kenneth MacDonald) нь аудит ба эрсдэлийн удирдлагын хороонд ажиглагчаар ажилладаг.




20210827

*Берин*



ERD ENERGY RESOURCE DEVELOPMENT CORPORATION | TSX:ERD | MSE:ERDN |



### **Цалин урамшууллын хороо**

Цалин урамшууллын хорооны эрх, үүрэг нь Компанийн гүйцэтгэх албан тушаалтнууд, мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэл, цалин урамшууллыг хянан шалгах, төлөвлөгөөний дагуу зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Гүйцэтгэх захиралтай хамтран харьцуулсан судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагад өгөх цалин урамшууллын түвшинг ТУЗ-д санал болгодог. Хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралддаг ба хоёр хараат бус, нэг хараат гишүүнээс бүрддэг:

- ✓ Лэйтон Крофт (Layton Croft)
- ✓ Кеннет МакДоналд (Kenneth MacDonald)
- ✓ Дэвид В.Мошер (David V. Mosher)



### **Дотоод хяналтын хороо**

Хороо нь Компанийн ажилтан, захирлууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн Компанийн үнэт цаасны арилжааг Компанийн Дотоод хяналтын бодлогын дагуу хянадаг. Хороо нь ТУЗ-ийн нэг гишүүн, нэг гүйцэтгэх албан тушаалтнаас бүрддэг:

- ✓ Петер К. Акерли (Peter C.Akerley)
- ✓ Роберт Женкинс (Robert Jenkins)



### **Компанийн засаглал ба мэдээлэл түгээх бодлогын хороо**

Энэхүү хороо нь мэдээлэл түгээх, ил тод байдлын хуулийн шаардлагууд болон Компанийн ил тод байдлын бодлого журам, Дотоод мэдээлэл эзэмшигчдийн арилжаанд оролцох бодлогын биелэлтийг хянах үүрэгтэй. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь мэдээлэл түгээх, ил тод байдлын талаарх зохих тогтолцоо, үйл явц, хяналт шалгалтыг хангах үүрэгтэй бөгөөд бүх хэвлэлийн мэдээлэл болон олон нийтэд ил байлгах үндсэн бичиг баримтуудыг нийтэд дэлгэх, болон тайлагнахын өмнө нягтлан хянах үүрэгтэй. Хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралддаг ба гурван хараат бус гишүүнээс бүрддэг:

- ✓ Др. Анна Г. Биолик (Dr. Anna G. Biolik)
- ✓ Лэйтон Крофт (Layton Croft)
- ✓ Жон П. Бюрн (John P.Byrne)



### **Техникийн хороо**

Уг хороо нь аливаа хөрөнгө оруулалт, хамтын хөрөнгө оруулалт, нөөц, боломжуудыг ТУЗ-д танилцуулахаас өмнө тодорхойлж, хянан шалгахад удирдлагад туслан ажилладаг. Хороо нь жилд дөрвөөс доошгүй удаа хуралддаг ба хоёр хараат гишүүн, нэг зөвлөхөөс бүрдэнэ:

- ✓ Петер К. Акерли (Peter C.Akerley)
- ✓ Хэдли Виддап (Hedley Widdup)
- ✓ Пол Корпи (Paul Corpi) (Зөвлөх)

2021:0827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Б.Сүрэн





### 1.3.6. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

#### ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл



#### Т.Лэйтон Крофт /ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн/

##### Туршлага

Лэйтон Крофт нь 2017 оноос хойш АНУ-д цэнэг хураагуурын металл болон алтны хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг Канадын Панконтинентал Гоулд Корпораци ("Pancontinental Gold Corporation")-ийн (TSXV: PUC) Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг хашиж байна. Тэрээр Монгол Улсад Азийн сангийн суурин төлөөлөгч, Оюу толгойн тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Пийбоди Энержи ("Peabody Energy") компанийн Дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан.

##### Боловсрол

Лэйтон Крофт нь Чапел Хилл дахь Хойд Каролинагийн их сургууль ("University of North Carolina"), Вермонт дахь Олон улсын сургууль, Массачуссетс дахь Тафтс их сургууль ("Tufts University")-ийн Хууль, Дипломат харилцааны Флетчер сургуулийг тус тус дүүргэсэн.



#### Др. Анна Биолик /ТУЗ-ийн хараат бус гишүүн/

##### Туршлага

Др. Анна Биолик нь дэлхийн бизнес стратеги, худалдааны дипломат харилцааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Аллам Эдвайзори Групп ("Allam Advisory Group")-ын Дэд Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Тэрээр Канад Улсаас Монгол, Казахстан, Киргизстан болон Таджикстан улсад суух бүрэн эрхт элчин сайд, ОХУ-ын Санкт Петербург хотноо суух Ерөнхий консулаар тус тус томилогдон ажиллаж байсан.

##### Боловсрол

Др. Анна Биолик нь Монреалын их сургууль ("University of Montreal")-д докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.



#### Жон П. Бюрн /ТУЗ-ийн хараат бус гишүүн/

##### Туршлага

Жон Бюрн нь 1997 оноос хойш Канада Эксплорэйшн Лимитедийн Петролиум Корпораци ("Canada Exploration Limited", "Petroleum Corporation")-ийн (Петрекс) Ерөнхийлөгчийн албыг хашиж байна. Тэрээр өмнө нь Петрексийн туслалцаатай байгуулагдаж, санхүүжсэн Энерплас Энержи сервисес Лтд. Компани ("Enerplus Energy Services Ltd")-ийн Дэд Захирал, Левеск Бюбин Жеоффрион Инк. ("Levesque Beaubien Geoffrion Inc") (одоогийн Үндэсний Санхүүгийн банк), А.Е Амес энд Компани ("A.E Ames & Company") / Доминион Секьюритиз Амес ("Dominion Securities Ames") болон Дэ Ферст Бостон Корпораци

20210927





ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

("The First Boston Corporation") зэрэг байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан.

*Боловсрол*

Жон Бюрн нь МакГилл Их сургууль ("McGill University")-ийн Бакалавр (B.A), Торонтогийн Их сургууль ("University of Toronto")-ийн Хуулийн сургуулийн эрхзүйн бакалавр (LL.B) зэрэгтэй.



**Петер К.Акерли / Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн/**

*Туршлага*

Петер К.Акерли нь ашигт малтмалын хайгуул, компанийн санхүүжилт, төсөл хөгжүүлэлт болон хөрөнгийн биржид бүртгэлтэй ашигт малтмалын компаниудыг удирдах чиглэлээр 25 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн-ийн үүсгэн байгуулагчдын нэг юм.

*Боловсрол*

Петер К.Акерли нь Сэнт Мэригийн их сургууль ("Saint Mary's University")-ийг геологич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



**Кеннет В.МакДоналд / ТУЗ-ийн ердийн гишүүн/**

*Туршлага*

Кеннет В.МакДоналд нь 2003 оноос хойш Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн ХК-ийн Санхүү хариуцсан захирал, 2016 оноос хойш Дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байсан. Мөн тэрээр 1992 оноос хойш Фишер Транспорт Лимитед компани ("Fisher Transport Limited")-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

*Боловсрол*

Кеннет В.МакДоналд нь Сэнт Мэригийн их сургууль ("St Mary's University")-ийн бакалаврын (BCom) зэрэгтэй. 1980 онд мэргэшсэн нягтлан бодогч болсон.



**Камерон Макрэй /ТУЗ-ийн хараат бус гишүүн/**


*Туршлага*

Камерон Макрэй нь Монгол Улсад Оюу Толгой ХХК-ийн Захирал, Рио Тинтогийн Монгол улсыг хариуцсан захирлын албыг тус тус хашиж байсан. Мөн Өмнөд Африк дахь Ричардс Бей Минералс ("Richards Bay Minerals")-т Гүйцэтгэх захирал (2008-2010), Зимбабве улсын Мурова Даймондс ("Murowa Diamonds")-д Ерөнхий захирал (2006-2007), Австрали дахь Хайл Крик ("Hail Creek")-ийн коксжих нүүрсний өргөжүүлэлтийн төсөлд Төслийн захирлаар тус тус ажиллаж байсан.

*Боловсрол*

Камерон Макрэй нь Австрали, Африк улсуудад боловсрол эзэмшсэн бөгөөд Худалдаа болон Бизнесийн удирдлагын магистрын (Монаш

20210827



*Бүрэлд*



Маунт Элиза бизнесийн сургууль, 1991) ("Monash mount Eliza, 1991") зэрэгтэй.



**Дэвид Мошер / ТУЗ-ийн хараат бус гишүүн/**

*Туршлага*

Дэвид Мошер нь Панконтинентал Уран корпораци ("Pancontinental Uranium Corporation") (TSX-V), Пелангио Эксплорэйшн Инк. ("Pelangio Exploration Inc") (TSX-V) зэрэг хайгуул, олборлолтын хэд хэдэн компанийн захирлаар ажиллаж байна. Тэрээр өмнө нь Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Канад, Африк, Орос улсад алтны хайгуул, олборлолт, боловсруулалт хийдэг Хай Ривер Гоулд Майнз Лтд. Компани ("High River Gold Mines Ltd")-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

*Боловсрол*

Дэвид Мошер нь Акадиа их сургууль ("Acadia University")-ийг геологийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй дүүргэсэн.



**Хэдли Виддап /ТУЗ-ийн хараат бус гишүүн/**

*Туршлага*

Хэдли Виддап нь Мт Кэйт Никелийн уурхай ("Mt Keith Nickel Mine, WA"), Олимпик Дам Зэс-Ураны уурхай ("Olympic Dam Copper-Uranium Mine, SA"), Мт Иса уурхайн цогцолбор ба Ст Ивэс алтны уурхай ("Mt Isa Mining complex, Qld" ба "St Ives Gold Mine, WA")-н нэг хэсэг: Блэк Стар Цайрын ил уурхай ("Black Star Open cut zinc project")-н геологийн багт ажиллаж байсан.

*Боловсрол*

Хэдли Виддап нь Австрали улсын Мельбурнийн Их Сургуулийг геологич мэргэжлээр Бакалаврын зэрэг, хэрэглээний санхүүгийн чиглэлээр магистрын зэрэг тус тус дүүргэсэн.



**Д.Сюзан Фрайзер /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

*Туршлага:*

2003 оноос эхлэн ТУЗ-ийн нарийн бичгийн албыг хашиж байна. Тэрээр МакИннес Купер хуулийн фирм ("McInnes Cooper")-ийн Халифакс дахь салбарын зөвлөх бөгөөд байгууллагын эрх зүйн чиглэлээр 35 гаруй жилийн ажлын туршлагатай бөгөөд ашигт малтмалын салбар дахь нээлттэй болон хувийн компаниудыг төлөөлөн ажилладаг туршлагатай хуульч юм.

*Боловсрол:*

Д.Сюзан Фрайзер нь Дэйлхауси Их сургуульд (Dalhousie University) бакалавр, LLB зэрэг хамгаалсан.



20210827

*Берина*



### Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх удирдлага нь санхүү, уул уурхай, ашигт малтмал, геологийн салбарт олон жил ажилласан туршлагатай баг хамт олон.



**Петер К.Акерли**  
Ерөнхийлөгч,  
Гүйцэтгэх захирал

**Ажлын туршлага:**

Ашигт малтмалын хайгуул, корпорацийн санхүүжилт, төсөл хөгжүүлэлт болон хөрөнгийн биржид бүртгэлтэй ашигт малтмалын компаниудыг удирдах чиглэлээр 25 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн-ийн үүсгэн байгуулагчдын нэг юм.

**Боловсрол:**

Сэнт Мэригийн их сургууль ("Saint Mary's University")-ийг геологич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн



**Роберт Женкинс**  
Санхүү хариуцсан  
захирал

**Ажлын туршлага:**

Роберт Женкинс нь 2019 оны 5 сараас эхлэн Компанийн Санхүү хариуцсан захиралаар томилогдсон. Тэрээр 2018 онд компанийн бизнес стратеги хариуцсан дэд ерөнхийлөгчөөр томилогдон, бизнес болон санхүүгийн төлөвлөлтийг хариуцан ажиллаж байсан. 2010 оноос 2017 оны хооронд Канадын тэргүүлэгч хөрөнгийн удирдлагын компанид санхүү болон үйл ажиллагаа хариуцан ажиллаж байсан.

**Боловсрол:**

Сэнт Мэригийн их сургууль ("Saint Mary's University")-ийг санхүүгийн бакалавр мэргэжлээр төгссөн, Итгэмжлэгдсэн Нягтлан Бодогч ("CPA").



**Майкл Х.Гиллис**  
Хайгуул, Үйл  
ажиллагаа хариуцсан  
дэд ерөнхийлөгч

**Ажлын туршлага:**

2006 оноос Бизнесийн үйл ажиллагаа хариуцсан захирлаар, 2010 онд Монгол дахь үйл ажиллагаа хариуцсан захирлаар томилогдсон. 2017 оноос үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгчөөр давхар томилогдон ажиллаж байна. 1996-2002 онд Каоклей Ресурсиз Инк.Корпораци-д геологич, газрын менежерийн албан тушаалыг хашиж байсан ба ашигт малтмалын хайгуулын салбарт 25 гаруй жил ажилласан туршлагатай.

**Боловсрол:**

1985 онд Ст.Фрэнсис Хавер Их сургууль ("St Francis Xavier University")-ийг геологич мэргэжлээр бакалаврын (BSc Hons) зэрэгтэй дүүргэсэн.



**Жон М.Л.Лёнс**  
Стратеги, тусгай  
зөвшөөрөл хариуцсан  
дэд ерөнхийлөгч

**Ажлын туршлага:**

2017 онд Стратеги, тусгай зөвшөөрөл хариуцсан дэд ерөнхийлөгчөөр томилогдон, компанийн ашигт малтмалын хайгуул, олборлолтын төслүүдийг үргэлжлүүлэхэд шаардлагатай төр засгийн зөвшөөрөл авах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.

**Боловсрол:**

Маастрихт их сургууль (Maastricht University) болон ЕвроЭМБиЭй консорциумын (Euro MBA consortium) бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

2021.09.27

*Осорино*





**Г.Бат-Эрдэнэ**  
Ахлах геологич

**Ажлын туршлага:**

2010 оноос эхлэн тус компанийн ахлах геологичоор томилогдон ажиллаж байна. Тэрээр Рио Тинто, Трой Ресурсиз зэрэг нэр хүнд бүхий компаниудад үнэт болон полиметаллын хайгуулын чиглэлээр 25 гаруй жил ажилласан туршлагатай.

**Боловсрол:**

1986 онд Эрхүүгийн их сургуулийг геологич мэргэжлээр бакалаврын зэрэг, 1999 онд Монгол Улсын техникийн их сургуулийг геологич мэргэжлээр магистр зэргийг тус тус дүүргэсэн.



**Дарин Бродерик**  
Санхүүгийн газрын дарга

**Ажлын туршлага:**

2017 онд Санхүүгийн газрын даргаар томилогдсон. Тэрээр АНУ-д төвтэй програм хангамжийн томоохон борлуулагч компанийн партнераар ажиллаж байсан. Мөн Африкт үйл ажиллагаа эрхэлдэг, хэд хэдэн уурхайтай олон улсын алт олборлогчдод Байгууллагын нөөц төлөвлөлтийн (ERP) системийг нэвтрүүлэн, хэрэгжүүлсэн туршлагатай.

**Боловсрол:**

Сэнт Мэригийн их сургуулийг ("Saint Mary's University") нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бакалаврын зэргийг дүүргэсэн ба Итгэмжлэгдсэн нягтлан бодогч зэрэгтэй (CPA) юм.



**А.Билгүүн**  
Бизнес хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгч

**Ажлын туршлага:**

2017 онд Бизнес хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгчөөр томилогдсон. Өмнө нь Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй хайгуулын болон олборлолтын компаниудад санхүүгийн болон нэгдэн нийлэх асуудлаар зөвлөгөө өгч ажилладаг Толл Кросс Секюритис (Toll Cross Securities) -д ажиллаж байсан туршлагатай. Түүнээс гадна, Улаанбаатар хот дахь Олон улсын уул уурхайн хөрөнгө оруулагчдын "Дисковер Монголиа" форумын Ерөнхий нарийн бичгийн дарга, Эм Ай Би Жи ҮЦК (MIBG)-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан туршлагатай.

**Боловсрол:**

Сэнт Мэригийн их сургуулийг ("Saint Mary's University") Санхүүгийн бакалаврын зэргийг дүүргэсэн ба Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч (CFA) юм.



**Б.Баярмаа**  
Захиргааны ерөнхий захирал

**Ажлын туршлага:**

2005 оноос хойш Захиргаа хариуцсан менежер ба Захиргааны ерөнхий захирлын албан тушаалыг хашиж байгаа. Тэрээр ашигт малтмалын чиглэлээр 15 гаруй жилийн туршлагатай.

**Боловсрол:**

1994 онд Монгол улсын их сургуулийг Эдийн засгийн ухааны бакалаврын зэрэг, 1998 онд Солонгосын Соганг их сургуулийг Олон улсын эдийн засгийн магистр зэргээр тус тус дүүргэсэн.

20210027





### Бизнесийн ёс зүйн дүрэм

2006 оны 3 сард компанийн ТУЗ нь Бизнесийн болон ёс зүйн дүрмийг баталж захирал, албан тушаалтан, ажилтан тус бүрт уг дүрэмд тусгасан стандартуудыг дагаж мөрдөх шаардлага тавьж эхэлсэн. Уг дүрмээр доорх агуулга, үзэл санааг баримтлахыг чухалчилдаг.

Үүнд:

- i. Шударга, ёс зүйт арга барилаар ажиллах;
- ii. Компанийн нууцыг хадгалах;
- iii. Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;
- iv. Компанийн хөрөнгийг зөв зохистой хэрэглэх, хамгаалах;
- v. Холбогдох хууль, журам, дүрэм болон зохицуулалтыг дагаж мөрдөх;
- vi. Дүрэм зөрчсөн талаар зохих ажилтан, мэргэжилтэнд нэн даруй мэдэгдэх;
- vii. Дүрмийг дагаж мөрдөх тухай хариуцлага хүлээх;
- viii. Үнэнч шударга байдал ба хариуцлагын соёл багтана.

Энэхүү дүрэмд ашиг сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал, хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал, ёс бус зан авир, доголдлын талаар мэдэгдэх асуудлыг тусгайлан хөндсөн.

### Ашиг сонирхлын зөрчил

Канад Улсын хуулийн хэм хэмжээний хүрээнд Компанийн захирлууд нь Компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар ажиллахыг шаарддаг бөгөөд Компанийн аливаа төсөл эсвэл хамтын ажиллагаа нь ашиг сонирхлын зөрчилтэй байвал нээлттэй мэдэгдэхийг шаарддаг. Хэрэв ашиг сонирхлын зөрчил ТУЗ-ийн хүрээнд үүссэн тохиолдолд уг гишүүн нь өөрийн ашиг сонирхлоо нээлттэй мэдэгдэж, тухайн асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй.

Компанийн захирлууд болон ажилтнууд Компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударга ажиллах ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүсвэл энэ талаар Компанид мэдэгдэх ёстой. Уг танилцуулгын хүрээнд энгийн хувьцааг худалдан авах талаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч нь үүсч болзошгүй ямар нэгэн ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд оролцож буй хүмүүсийн үнэнч шударга байдал, шийдвэрт итгэлтэй байх нөхцөлийг компани бүрдүүлэх үүрэгтэй.

#### 1.4. Гэрээ болон хамтын ажиллагаа

Эрдэнэ Ресурс нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэг томоохон хэлцэл хийгээгүй бөгөөд өмнө байгуулж одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Компьютершэйр Инвестор Сервисэс Инк. компанитай байгуулсан Хувьцаа эзэмшигчийн эрхийн гэрээнээс гадна дараах хүчин төгөлдөр үйлчилж байгаа томоохон гэрээг хэрэгжүүлж байна. Тэдгээр нь 2019 оны 10-р сарын 11-ний өдөр байгуулсан Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХС)-тай байгуулсан Зээлийн гэрээ, Сандсторм Гоулд Лимитэд компанитай хийсэн 1%-ийн Роялти гэрээ юм. Дээрх гэрээг байгуулахтай холбоотойгоор Эрдэнэ Ресурсаас зохих шийдвэр, тогтоолыг гаргасан, гэрээнүүд нь хүчин төгөлдөр болно.



20210927



ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



Эрдэнэ Монгол ХХК нь 2020 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна. Эрдэнэ Монгол ХХК нь 2020 онд Лидер Эксплорейшн ХХК-ийн 49 хувийн хувьцааг худалдан авах хэлцэл байгуулж, Эрдэнэ Монгол ХХК нь Лидер Эксплорейшн ХХК -ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч болсон байна.

Эрдэнэ Монгол ХХК нь 2021 оны 3 сарын 18-нд СИТИК ЭйчАйСи Австрали Питивай Лтд-тай Баян Хөндий алтны төслийн Милл Плант (цахилгаан механикийн үйлдвэрлэл болон барилга, инженерийн ажил гүйцэтгэх) барих гэрээг байгуулсан бөгөөд гэрээ байгуулахад шаардлагатай холбогдох шийдвэр, тогтоолыг зохих ёсоор авсан байна.

Эрдэнэ Ресурсийн бусад Монгол компаниуд болох Аниан Ресорсиз ХХК болон Лидер Эксплорейшн ХХК нь 2020 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №25 дахь Хуулийн дүгнэлтээс харна уу.*

2021:0827

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Б. Доржиев*





## 1.5. Хувьцааны мэдээлэл

### 1.5.1. Өмнө гаргасан хувьцааны мэдээлэл

Компани нь 2000 онд үүсгэн байгуулагдсан ба 2004 онд хувьцаагаа нээлттэй санал болгох хүртэл хаалттай хүрээнд 13,058,910 ширхэг энгийн хувьцааг гаргасан.

2004 оны 3 сард компани нь Торонтогийн Хөрөнгийн Биржийн Венчур (гарааны бизнесийн) самбар дээр 12,500,000 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь \$0.85-ын нэрлэсэн үнээр нэмж гарган бүртгүүлсэн.

2005 оны 12 сарын 14-өөс эхлэн компанийн хувьцаа Торонтогийн Хөрөнгийн Бирж үндсэн самбарт шилжин арилжаалагдаж эхлээд байна. Компанийн хувьцааны арилжаа нь Канадын Хөрөнгө Оруулалтын Зохицуулах Байгууллага ("IIROC") ("КХОЗБ")-ын хяналт, зохицуулалтын дагуу хийгддэг. Энэхүү байгууллага нь Канад улс дахь хувьцааны зах зээл дээрх хөрөнгө оруулалтын дилер, арилжааны үйл ажиллагааг хянадаг өөрийгөө зохицуулагч байгууллага бөгөөд Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллагын ("International Organization of Securities Commission") гишүүн юм.

Компани нь хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах, опцион хэрэгжүүлэх зэргээр санхүүжилт татан үйл ажиллагаагаа санхүүжүүлж ирсэн.

2018 онд Эрдэнэ Ресурс нь Монголын Хөрөнгийн Биржийн 2018 оны 04 сарын 04-ний өдрийн А/48 тоот тушаал, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 05 сарын 23-ны өдрийн 187 тоот тогтоолын дагуу Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд 4,000,000 ширхэг хувьцаагаа санал болгон давхар бүртгүүлсэн.

Хүснэгт 4. Компанийн өмнө гаргасан энгийн хувьцааны мэдээлэл

Он сар	Оны эцсийн үлдэгдэл
2005.04.15	27,269,635
2006	53,051,127
2007	70,200,939
2008	89,230,877
2009	89,230,877
2010	89,688,377
2011	95,802,901
2012	53,785,299*
2013	68,621,503
2014	82,636,233
2015	105,060,005
2016	126,810,031
2017	145,963,086
2018	162,426,416
2019	191,068,490
2020.10.20	267,885,433



20210927



\* 2012 онд хууль эрхзүйн дагуу хийсэн хэлэлцээрийн хүрээнд Эрдэнэ Ресурсийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж буй нэг ширхэг энгийн хувьцаа бүрд Эрдэнэ Ресурсийн нэмж гаргасан энгийн хувьцааны 1/2, Мориен Ресурс Корпорэйшний энгийн хувьцааны 1/2 хүлээн авсан. Канадын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Торонтогийн хөрөнгийн биржийн журмын дагуу үнэт цаас гаргахад Канадын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид нийцсэн байх ёстой бөгөөд энгийн хувьцаа (энгийн хувьцаанд хөрвөх, шилжих нөхцөлтэй үнэт цаас) гаргах тохиолдолд ТХБ-ээс урьдчилан зөвшөөрөл авдаг.

2020 онд “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам” шинэчлэгдсэнтэй холбоотой Эрдэнэ Ресурс нь нийт хувьцаагаа МХБ-д бүртгүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг нэмж гаргах тухай бүр Торонтогийн хөрөнгийн биржээс гадна Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж байгаа ба энэ нь биржүүдийн хувьцааны мэдээллийн хооронд зөрүү үүсгэхгүй байх зорилготой.

Компанийн өмнө гаргасан үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №9-өөс харна уу.

### 1.5.2. Хувьцааны арилжааны мэдээлэл

2020 оны 12 сард Эрдэнэ Ресурс нь МХБ-д нийт Энгийн хувьцааг бүртгүүлснээр компанийн хувьцаа нь ТХБ болон МХБ дээр болон тухайн биржүүдийн хооронд чөлөөтэй хөрвөн арилжигдах боломж бүрдсэн.

График 1. Торонтогийн хөрөнгийн бирж дээрх сүүлийн 5 жилийн хувьцааны арилжаа




20210921

Баерин



График 2. Монголын хөрөнгийн бирж дээрх 2018 оноос хойш хувьцааны арилжаа



Хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж, Торонтогийн Хөрөнгийн Биржүүдийн хооронд хөрвүүлэх боломжийг нээлттэй болгосноор ханшийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоодын зах зээлд хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, ханшийн зөрүү буурах зэрэг ач холбогдолтой.

Биржүүдийн хооронд арилжиж эхлээгүй үед ТХБ болон МХБ дээрх ханшийн зөрүү харьцангуй өндөр буюу дунджаар 117 төгрөг байсан. 2020 оны 12 сараас МХБ, ТХБ хооронд хөрвөх боломжтой болсноор зөрүү буурч, дунджаар 65 төгрөг болсон.

График 3. МХБ, ТХБ-ийн ханшийн харьцуулсан үзүүлэлт



20210827



ЭРДЭНЭ-РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

Хүснэгт 5. Биржүүд дээрх хувьцааны ханшийн үзүүлэлт



Торонтогийн хөрөнгийн бирж (CAD)

Монголын хөрөнгийн бирж (MNT)

Хаалтын ханш	0.37	885
52 долоо хоногийн хэлбэлзэл	0.32-0.71	800-1,020
Дундаж арилжааны хэмжээ /50 өдөр	193,258	4,596
Зах зээлийн үнэлгээ	110,105,678	247,992,260,745
P/B	2.04	1.55
P/E	-6.09	-4.62
EPS	-0.07	-185.87

2021 оны 06 сарын 30-ний өдрийн байдлаар

Компани хайгуулын үр дүнгээ танилцуулах, тусгай зөвшөөрөл авах, мэдээ мэдээлэл гаргах зэрэг үйл явдлууд хувьцааны ханшид нөлөөлдөг. Монголын хөрөнгийн бирж дээр ханшийн хязгаараас хамааран үнийн хэлбэлзэл 15% байгаа бол Торонтогийн хөрөнгийн бирж дээр 30 хүртэл хувиар хэлбэлзэж байна.

### 1.5.3. Ногдол ашиг


Одоогоор Компанийн үндсэн зорилт нь хувьцааны ханшийн өсөлтөөр хувьцаа эзэмшигчиддээ үнэ цэнийг бий болгоход чиглэгдэж байна. Компани өнөөг хүртэл энгийн хувьцаандаа ногдол ашиг хуваарилаагүй. Компанийн хөрөнгө нь үйл ажиллагааг дэмжих, ордын нөөцийг илрүүлж түүнийг өсгөн нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн ажиллагааг эхлүүлэхэд зарцуулагдах төсөөлөлтэй байгаа тул ойрын ирээдүйд ногдол ашиг хуваарилах төлөвлөгөөгүй байна. Энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах тухай аливаа шийдвэрийг орлого, санхүүгийн тайлан болон тухайн цаг үеийн бусад нөхцөл байдалд тулгуурлан Компанийн ТУЗ гаргана.

20210921

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бернис*





**1.6. Үндсэн үйл ажиллагааны танилцуулга**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн нь Монгол Улсад өндөр агуулга бүхий, газрын дөт гүнд суурь болон үнэт металлын хайгуул, олборлолт, худалдан авалт болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэх үндсэн зорилттой.

Компани нь Баянхонгор аймгийн Шинэжинст болон Баян-Өндөр сумдын нутагт орших өөрийн эзэмшдэг 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд гүйцэтгэсэн хайгуул, судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн.

 <b>Хөндий Алтны Дүүрэг</b>	 <b>Хайгуулын туршлага</b>	 <b>Орд, хэтийн төлөв бүхий талбай</b>	 <b>Ашиглалт руу хөгжүүлж буй Баян Хөндий алтны төсөл</b>
<p>Дэлхийн томоохон алт-зэсийн ордуудыг агуулдаг Төв Азийн Орогенийн бүсийн хязгаарлагдмал судлагдсан хэсэгт Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн.</p>	<p>Урт хугацаанд Монгол Улсад төвлөрөн ажиллаж буй хайгуулын туршлагатай компани. Монгол Улсын баруун өмнөд бүсэд томоохон хувийн геологийн мэдээллийн санг үүсгэсэн.</p>	<p>Цаашид өргөжих боломжтой томоохон орд, хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Үүнд: Баян Хөндий орд, Алтан Нар орд, Зуун Мод орд, Хар Морь, Улаан болон бусад талбай багтдаг.</p>	<p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл Өндөр агуулгатай (3.7 гр/тн) 409,000 унц (12.7 тн) үйлдвэрлэлийн нөөц (батлагдсан ба магадалсан). Илээр олборлож, уламжлалт аргаар боловсруулах боломжтой.</p>
 <b>Анхны давхар бүртгэлтэй уул уурхайн компани</b>	 <b>Байгаль орчин, орон нутгийн хамтын ажиллагаа</b>	 <b>Туршлагатай баг</b>	 <b>Санхүүгийн нөөц болон тогтвортой хувьцаа эзэмшигчид</b>
<p>МХБ, ТХБ-ээр хувьцаа нь нээлттэй арилждаг ба биржүүдийн хооронд хөрвөн арилжих боломжтой.</p>	<p>Орон нутагтай байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон бусад чиглэлээр хамтран ажилладаг. Үйл ажиллагаа явуулж буй 2 сумын 5,000 гаруй иргэн Компанийн энгийн хувьцааг эзэмшдэг.</p>	<p>Геологи, санхүү, уул уурхайн салбарт олон жил ажилласан туршлагатай удирдлагын баг, ТУЗ</p>	<p>ТХБ болон МХБ дээр хаалттай, нээлттэй хүрээнд санхүүжилт босгон үйл ажиллагаагаа санхүүжүүлж байна.</p>


20210827








0000035



### 1.6.3. Компанийн түүх

Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүх



20210027

*Бермис*



**1.6.4. Хөндий алтны дүүрэг**

Эрдэнэ Ресурс нь Хөндий алтны дүүрэгт Баян Хөндий, Алтан Нар зэрэг өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн орд, хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлж, ашиглалтын үйл ажиллагаа хөгжүүлэхээр зорьж байна.

Өмнөх хайгуулын үр дүн, илрүүлээд буй орд газрууд нь Хөндий алтны дүүрэгт байрлаж буй төслүүдийн ирээдүйн геологийн боломж, хэтийн төлөвийг тодорхойлдог.

Уг дүүрэг нь Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын нутагт Улаанбаатар хотоос өмнө зүгт 980 км, Баянхонгор хотоос урд зүгт 300 км гаруй зайд байрладаг.

Зураг 1. Хөндий Алтны Дүүргийн байршил



20210827


**Орд, хэтийн төлөв бүхий талбай**

Компани нь тус бүс нутагт байрлах өөрийн эзэмшлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайнуудад цаашид өргөжих боломжтой алт, полиметалл, зэс, молибденийн гурван орд болон хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлсэн.

*Бүрэл*

МОНГОЛЫН  
 МҮЭГЛИЙН ГИШУУ  
 ХАЛДВАЛЫН  
 БРОКЕР ДАВРЫН  
 "БНТ-ЭРД" 36  
 УИХ ХН  
 1115205447 @ 2052

Зураг 2. Хөндий алтны дүүрэг дэх орд, хэтийн төлөв бүхий талбай



Орд	Хэтийн төлөв бүхий талбай
- Баян Хөндий алтны төсөл	- Хар Морь алтны хайгуулын төсөл
- Алтан Нар алт-полиметаллын төсөл	- Алтан Сум алт, мөнгөний хайгуулын төсөл
- Зуун Мод молибден-зэсийн төсөл	- Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл
	- Улаан зэс порфирын хайгуулын төсөл
	- Хойд Хөндий хайгуулын төсөл
	- Бусад анхан шатны хайгуулын төслүүд

Ордуудын хувьд хайгуул, үнэлгээний ажил хийгдэн ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан ба Баян Хөндий ордод нарийвчилсан ТЭЗҮ хийгдсэн, Алтан Нар ордын хувьд анхан шатны эдийн засгийн тооцооллыг гүйцэтгэсэн. Баян Хөндий ордыг ойрын хугацаанд ашиглалтын шатанд хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Зуун Мод орд болон Хөвийн Хар талбайн хөгжүүлэлт нь зэс, молибденийн үнээс хамаарна. Зэс ба молибденийн үнэ өнгөрсөн жилүүдэд өсөн, ойрын хугацаанд тогтвортой чангарах төлөв болон бусад зах зээлийн таатай нөхцлийг харгалзан 2021 оны 07 сард Компани нь дээрх төслийн стратегийн үнэлгээг эхлүүлсэн.

Хэтийн төлөв бүхий талбайнуудын хувьд нэмэлт хайгуул үнэлгээний ажил хийгдсэнээр нөөц, эдийн засгийн үр ашгийг нарийвчлан тогтооно. Хар Морь талбайд өндөр агуулгатай алтны хүдэржилтийг нээн илрүүлээд байгаа ба цаашид хайгуул, үнэлгээний ажлыг төвлөрөн гүйцэтгэхээр төлөвлөсөн. Эрдэнэ Ресурс нь хайгуулын хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан Хөндий Дүүрэгт алт, зэсийн шинэ нээлтүүдийг хийж боломжтой гэж үзэн,

*Б.Сергеев*

“ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА”-ЫН ХАВЧГАЛТЫН БИРЖ  
1115295447-2052462  
37

20210827



системчилсэн хайгуул болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг дээрх хүдэржилт бүхий дүүрэгт үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

### Тусгай зөвшөөрөл

Компани нь нийт 17,004.2 га талбай бүхий хайгуулын 2, ашиглалтын 3 нийт 5 тусгай зөвшөөрлийг өөрийн 100% эзэмшил бүхий охин компаниудын (Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК болон Лидер Эксплорейшн ХХК) нэр дээр эзэмшдэг.

Компанийн хуулийн зөвлөх Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүхий л хууль зүйн болон зохицуулалтын баримт бичгийг хянаж дүгнэлт гаргасан бөгөөд Компанийн бүх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр ба Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгасан хууль ёсны шаардлагаас бусдаар ямарваа үүрэг, хариуцлага хүлээгээгүй болно.

Хүснэгт 6. Тусгай зөвшөөрөл

Нэр	Лицензийн дугаар	Ашигт малтмал	Байршил	Хэмжээ, га	Хүчинтэй хугацаа	Эзэмшигч
Ашиглалтын тусгай зөвшөөрөл						
Хөндий	MV-021444	Алт	Баянхонгор, Шинэжинст	2,308.62	2019.08.05 2049.08.30	Эрдэнэ Монгол ХХК
Алтан нар	MV-021547	Алт	Баянхонгор, Шинэжинст, Баян-Өндөр	4,668.64	2020.03.04 2050.03.04	Эрдэнэ Монгол ХХК
Хөвийн хар	MV-016836	Молибден	Баянхонгор, Шинэжинст	6,041.03	2011.05.26 2041.05.26	Аниан Ресорсиз ХХК
<b>Нийт талбай</b>				<b>13,018.29</b>		
Хайгуулын тусгай зөвшөөрөл						
Улаан	XV-016057	N/A	Баянхонгор, Шинэжинст, Баян-Өндөр	1,780.20	2015.02.16 2027.02.16	Лидер эксплорейшн ХХК
Хөндий	XV-015569	N/A	Баянхонгор, Шинэжинст, Баян-Өндөр	2,205.71	2010.04.14 2022.04.14	Эрдэнэ Монгол ХХК
<b>Нийт талбай</b>				<b>3,985.91</b>		
<b>Нийт тусгай зөвшөөрлийн талбай</b>				<b>17,004.20</b>		

20210927

Компанийн эзэмшиж буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн талаар мэдээллийг Хавсралт №10-аас үзнэ үү

Бүрэлд



## Байршил

Хөндий алтны дүүрэгт байрлах Эрдэнэ Ресурсийн төслүүд нь Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын нутагт Улаанбаатар хотоос баруун өмнө зүгт 980 км, Баянхонгор хотоос баруун өмнө зүгт 300 км гаруй зайд байрладаг.

Геологийн хувьд төслүүд нь Төв Азийн Орогены бүслүүрийн зүүн хэсэгт байрладаг ба энэхүү бүслүүрт Кумтор (14 сая унц алтны нөөц), Алмалик (25 сая унц алтны нөөц), Мурунтау (140 сая унц алтны нөөц) болон Оюу Толгой (62 сая унц алтны нөөц) зэрэг алт, алт-зэсийн хэд хэдэн том ордууд байрлаж байна.

Зураг 3. Зүүн Төв Азийн Орогенийн бүслүүр, түүнд байрлах алт, зэсийн томоохон ордууд



Бүслүүр дэх ороген, порфир, эпитермаль төрлийн ордууд нь ихэвчлэн Арлан нумын структурын орчинтой уялдахын зэрэгцээ томоохон металоген ба тектоник үйл явцаас үүдэлтэй байдаг. Эдгээр ордууд нь вулканик-плутоник идэвхжилтийн төвд трансформ хагарлаас үүдэн хэсэгчлэн тохиолддог бөгөөд энэ нь баруун-зүүн суналтай субдукцаар үүссэн мантийн тархацтай уялдан бүс нутгийн хагарлаас салаалан үүссэн. Бүслүүрийн дагуу зүүн хойд хувирлын структурууд нь алт, зэсийн ордын гарал үүсэлд чухал ач холбогдолтойг харуулж байна.


Эрдэнэ Ресурс нь хайгуулын ажлын хүрээнд томоохон ордуудын голлох шинж чанаруудыг судалснаас гадна Монгол Улс дахь Палеозойн арлан нумын террейний үнэлгээг хийсэн ба үүний үр дүнд геологи-структурын орчинд үндэслэн Эдрэнгийн арлан нумын террейд төвлөрөн ажилласан.

СЭХ  
2021 оны  
сар 22 өдөр  
БҮРТГЭВ  
№ 31

0000040  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-09-03  
БҮРТГЭВ-03

ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

Зураг 4. Эдрэнгийн төррейн



20210827

Төв Азийн Орогенийн бүс дэх Эдрэнгийн төррейн нь 400 орчим км урт үргэлжилдэг. Компани нь Эдрэнгийн төррейн зүүн хэсэгт хийсэн хайгуулын хөтөлбөрөөр өндөр хэтийн төлөв бүхий зорилтот талбайнуудыг тодорхойлсон.

Хөндий Дүүрэгт бүс нутгийн структуртэй холбоотой зэс болон зэс-молибдений порфир, их, бага, дундлаг сульфиджилт зэрэг арлан нумын хүдэржилтийн бүх төрлүүд багтаж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Б. Сүрэн*

МҮБ-ийн түүвэр  
Брокер, "Эрдэнэ"  
ҮНБ АК 40  
1114205447



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



### 1.6.5. Ашиглалтын шатанд хөгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд

#### БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны ордыг 2015 онд нээн илрүүлсэн ба 2019 онд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан, 2020 онд Баян Хөндий төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-г NI 43-101 төслийн тайлагналын стандартын боловсруулсан.

Баян Хөндий төслийг газрын гадаргад ойр, өндөр агуулгатай бөгөөд ил уурхайн аргаар олборлох боломжтой төсөл гэж үзэн алтны олборлолтыг 2023 оноос эхлүүлэхээр төлөвлөж байна.

Нарийвчилсан ТЭЗҮ-ийн голлох үзүүлэлтүүд:

Ашигт малтмал	Алт
Ашиглалтын тусгай зөвшөөрөл	2019 он
Олборлох хүдэр	3.4 сая тонн
Алтны дундаж агуулга	3.7 гр/тн
Үйлдвэрлэлийн нөөц	409,000 унц (12.7 тн) алт (Батлагдсан ба Магадалсан)

#### Алтны олборлолт

Ашиглалтын хэлбэр	Ил уурхай /газрын гадаргаас 144 м гүнд/
Ашиглалтын хугацаа	8 жил
Олборлож эхлэхээр төлөвлөсөн хугацаа	2023 он
Алтны үйлдвэрлэл	Жилд дунджаар 63,000 унц (1.95 тн) Нийт 381,000 унц (11.85 тн)
Уурхайн ашиглалтын хугацааны дундаж металл авалт	93%
Дундаж хөрс хуулах харьцаа	9.1:1

#### Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Капиталжуулах зардал	63.8 сая ам.доллар
Үүнд: Анхны бүтээн байгуулалтын зардал	59.2 сая ам.доллар
Нэг унц алт олборлох нэгжийн өртөг	733 ам.доллар
Алтны үнийн төсөөлөл	1,400 ам.доллар/унц
Татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн /NPV@ 5%/	100.3 сая ам.доллар
Татварын дараах дотоод өгөөжийн хувь /IRR/	42.4%
Анхны хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа	1.9 жил

20210827

*Баян*



### Тусгай зөвшөөрөл


Баян Хөндий төсөл нь Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг. Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийг анх 2010 оны 04 сард 4,514.33 га талбайд авсан ба 2019 онд Баян Хөндий орд байрлаж буй өмнөд хэсгийн 2,308.62 га талбайг ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэн, үлдсэн талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл хэвээр үлдээсэн.

Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 11 дэх жилдээ хайгуул хийж байна. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу 12 жилийн хугацаа дуусахаас өмнө хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

Дээрх тусгай зөвшөөрлийн 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг Сэндсторм Гоулд Лтд.-д ирээдүйд хуваарилах үүрэгтэй.

Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2019 онд, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 онд тус бүр 30 жилийн хугацаатай авсан ба ирээдүйд 70 жил хүртэл сунгах боломжтой.

Зураг 5. Баян Хөндий ордын байршил, тусгай зөвшөөрлийн талбай




### Ордын төрөл, эрдэсжилт

Баян Хөндий орд нь өндөр алтны агуулгатай, бага сульфидтэй (адуляр-серицит) эпитермаль судлын төрлийн орд юм. Хүдэржилт нь олон үе шаттай үүссэн кварц-адуляр-халцедон, кварц-спекулярит-гематитийн судал болон судланцаруудын бүс хэлбэртэй илэрнэ.

20210021

Зураг 6. Бага болон их сульфидтай эпитеpmаль ордын загвар



Алтайн Чанадын бүсийг эпитеpmаль хүдэржилт болон зэс-порфирийн системийн хэтийн төлөвтэй бүс нутаг гэж үздэг. Компани нь Алтайн Чанадын бүсийн хүрээнд хийсэн эрэл-хайгуулын судалгааны ажлынхаа үр дүнд Баян Хөндий ордыг нээн илрүүлсэн.

Баян Хөндий нь Девоны галт уулын чулуулагт агуулагдах бага сульфидтай эпитеpmаль алтны ордын төрөлд хамаарагдана. Энэ Девоны агуулагч чулуулаг нь газрын гадарга дээр өгөршил-элэгдэлийн 2 цонх үүсгэн Юраболон Дөрөвдөгчийн хучаас хурдас доороос гарш үүсгэн газрын гадаргад ил гарсан байдаг.

Баян Хөндийд илрэх туффоген чулуулаг нь олон үе шаттай үүссэн цахиуржилт болон шаврын хувиралд хүчтэй орсон байдаг. Талбайд геологи, структур, петрограф, шаврын хувирлын спектрийн болон ормын мөрийн судалгаануудыг хийсэн бөгөөд эдгээр судалгаанууд нь хүдэржилтийг бага сульфидтэй эпитеpmаль ордын төрөл болохыг харуулдаг. Алтны хүдэржилт нь хувирсан агуулагч туфуудыг зүссэн кварц ± адуярын судлууд, кварцын брекчүүдтэй холбоотой гематит-спекуляритын судлууд, кварцын судлуудыг хүрээлэн эмжээрлэсэн хувирлын бүс, мөн ан цавыг дүүргэсэн гематит-спекуляритын эрдэсжилттэй холбоотой. Баян Хөндий нь Хишикари (Япон), Купол (Орос) болон Раунд Маунтэйн (АНУ) зэрэг дэлхийн бусад бага сульфидтэй ордуудтай ижил төстэй тогтоцтой байна.

### Баян Хөндий нөөцийн тооцоолол

ТЭЗҮ боловсруулсан мэргэшсэн этгээд нь нөөцийн тооцооллыг Тетра Тек компанийн 2019 оны 10 сарын байдлаар боловсруулсан нөөцийн тайланд суурилан тусгасан. 2021 оны 6-р сарын 17-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон Баян Хөндийн шинэчилсэн нөөцийн тооцоолол

нь NI 43-101, дагуу бодлого 43-101CP, Эрдэс баялаг, ашигт малтмалын нөөцийн CIM тодорхойлолтын стандартын дагуу боловсруулагдсан.

2019 оны 10-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон нөөцийн тооцоололд багтсан мэдээллээс хойш нийт 12,889 метрийн 95 цооногийн мэдээлэл болон шинэчилсэн структурын тайллын судалгааг шинэчилсэн тооцоололд багтаасан. Баян Хөндийн шинэчилсэн нөөцийн тооцоололд нийт 55,791 метрийн 350 цооног болон 1,075 метрийн 23 суваг малталтын мэдээлэл багтсан.

### Үйлдвэрлэлийн нөөц

Олборлолтын явцад гарах хаягдал, бохирдолт болон бусад хүчин зүйлийн шалтгаанаар олборлох боломжгүй нөөцийг геологийн нөөцөөс хасч тооцсон эдийн засгийн үр ашигтай нөөцийг үйлдвэрлэлийн нөөц гэнэ.

ТЭЗҮ боловсруулсан мэргэшсэн этгээд нь үйлдвэрлэлийн нөөцийг Тетра Тек нь геологийн загварчлал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны параметр зэргийг харгалзан тооцоолсон. Ордын үйлдвэрлэлийн нөөцийг 409,000 унц (12.72 тн), дундаж агуулгыг 3.7 гр/тн байхаар тооцоолжээ. Алтны дундаж агуулга 3.7 гр/тн байгаа нь ил уурхайнуудын дундаж алтны агуулгатай харьцуулахад харьцангуй өндөр байна. Нарийвчилсан ТЭЗҮ-ээр Баян Хөндий төсөл нь өндөр агуулга бүхий, газрын дөт гүнд илээр олборлох боломжтой хэмээн тооцоолсон бөгөөд хойд зүг рүү Мидфийлд, Хойд Мидфийлд бүсэд 144 метрийн гүн хүртэл үргэлжилж байна.

Хүснэгт 7. Баян Хөндий ордын үйлдвэрлэлийн нөөц

Нөөцийн ангилал	Нийт хүдэр	Алтны агуулга	Агуулсан алт	
	Сая.тон	Гр.тн	мян.унц	тн
Баттай / Proven	1.2	4.2	166	5.16
Магадалсан/ Probable	2.2	3.5	244	7.59
<b>Нийт нөөц</b>	<b>3.4</b>	<b>3.7</b>	<b>409</b>	<b>12.72</b>

1. Ашигт малтмалын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол нь 2020 оны 07-р сарын 01-аас хүчин төгөлдөр болсон. Тооцооллыг Мэргэшсэн этгээд Auraria Mining Consulting-ийн захирал, Мэргэшсэн этгээд Антони Кийрс ("Mr. Anthony Keers") боловсруулсан.
2. Ашигт малтмалын нөөцийн Тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны дээд сургууль (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн.
3. Нөөцийг ил уурхайн аргаар олборлоно гэж тооцоолсон.
4. Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашигийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон.
5. Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,400 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн.
6. Ашигт Малтмалын Нөөцөд 9% бохирдолт болон 1% алдагдал багтсан.



20210827

**Геологийн нөөц**

Хайгуулын ажлын үр дүнгээр тогтоож, газрын хэвлийд орших байдлаар нь тооцоолсон ордын нөөцийг геологийн нөөц гэнэ.

2021 оны 1-р улиралд Тетра Тек нь өнөөгийн алтны үнэд тулгуурлан Баруун Страйкер, Страйкер, Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүдэд 2020 онд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрүүдийн үр дүнг багтаан эрдсийн нөөцийг шинэчлэн тооцоолсон.

Энэхүү нөөцийн тооцооллыг Эрдэнэ Ресурсийн мэдээлэлд тулгуурлан, шаардлагатай тохиолдолд Tetra Tech баталгаажуулсан. Ашигт малтмалын нөөцийн тооцооллын хүрээнд өгөгдлийн баталгаажуулалт, статистик судалгааг Tetra Tech хийсэн. Шинэчилсэн нөөцийн тооцоолол нь өмнө мэдээлсэн ашигт малтмалын нөөцөөс материалын өөрчлөлт ороогүй тул National Instrument 43-101 (NI 43-101) -д заасанчлан шинэ техникийн тайлан гаргах шаардлагагүй.

Ашигт малтмалын нөөцийг Whittle™ -ийн Lerchs Grossman алгоритмыг ашиглан эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзсэн блокийн хязгаарлалтын параметруудийг ашиглан анхан шатны шурфаар хязгаарласан. Доорх хүснэгтэд харьцуулалтын хүрээнд ашигт малтмалын нөөцийн хэд хэдэн захын агуулгыг харуулсан. Tetra Tech нь 0.4 г/т захын агуулгыг тайлагнахыг зөвлөсөн.

Хүснэгт 8. Баян Хөндий ордын геологийн нөөцийн тооцоолол

Захын агуулга (1)	Нөөцийн ангилал	Хэмжээ (тонн)	Агуулга Au г/т	Алт унц
0.4 Санал болгосон	Баттай	3,031,000	2.39	232,700
	Бодитой	5,269,000	2.08	352,400
	<b>Баттай &amp; Бодитой</b>	<b>8,301,000</b>	<b>2.19</b>	<b>585,100</b>
	Боломжтой	512,000	2.18	35,900
0.55	Баттай	2,221,000	3.08	220,200
	Бодитой	3,885,000	2.65	331,100
	<b>Баттай &amp; Бодитой</b>	<b>6,105,000</b>	<b>2.81</b>	<b>551,400</b>
	Боломжтой	375,000	2.80	33,800
1.0	Баттай	727,000	7.96	186,100
	Бодитой	1,454,000	5.91	276,100
	<b>Баттай &amp; Бодитой</b>	<b>2,181,000</b>	<b>6.59</b>	<b>462,200</b>
	Боломжтой	133,000	6.68	28,500
1.4	Баттай	628,000	9.04	182,600
	Бодитой	1,282,000	6.55	269,900
	<b>Баттай &amp; Бодитой</b>	<b>1,910,000</b>	<b>7.37</b>	<b>452,500</b>
	Боломжтой	121,000	7.22	28,100

- (1) Нөөцийн тайлангийн захын агуулгыг, алтыг нэг унц нь US\$1,600, олборлолтын зардал нэг тонн тутамд US\$3, ерөнхий ба захиргааны зардал нэг тонн тутамд US\$16, металл авалт 0.95% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан.
- (2) Нөөцийн тайланд эрдэсжсэн бүсийн дундаж нягтаршил 2.66 т/м3 байхаар төсөөлсөн.
- (3) Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлосон болно.
- (4) NI 43-101, 43-101CP, болон геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллын CIM стандартын дагуу тооцоолсон.
- (5) Баттай ба бодитой нөөц нь эдийн засгийн тооцоололд багтахгүй. Боломжит нөөцийг техник эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд хүндрэлтэй. Үйлдвэрлэлийн нөөцөд багтаахгүй.

**Хайгуулын ажил**

**ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА**

*Берисе*

МХБ-ийн гишүүн  
 Андерригтер  
 Брокер, Улсын  
 45  
 1115205447

7  
 19  
 10  
 19


Баян Хөндий нь алтны өндөр агуулгатай, гадаргад ойр, металлургийн хувьд хялбар нөхцөлтэй тул Компани нь энэхүү төсөл дээр хайгуул, судалгааны ажлыг төвлөрөн гүйцэтгэсэн.

- Геологийн зураглал, кварцын судлуудын штуфын дээжлэлт
- Геофизикийн 3D загварчлал, геофизикийн мэдээллийн шинжилгээ үнэлгээ, тайлал
- Нарийвчилсан чулуулгийн болон хөрсний геохимийн дээжлэлтийн судалгаа
- Байрзүйн зураглал
- Хүндийн хүчний 3D загварчлал, геофизикийн хүндийн хүч болон соронзон орнысудалгаа, загварчлал
- Петрограф, минерограф, хий, шингэний ормын мөрийн судалгаа
- Суваг малталтын хөтөлбөр
- Өрөмдлөгийн хөтөлбөр

### Өрөмдлөг

2019 оны 10-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон нөөцийн тооцоололд багтсан мэдээллээс хойш нийт 12,889 метрийн 95 цооногийн мэдээлэл болон шинэчилсэн структурын тайллын судалгааг шинэчилсэн тооцоололд багтаасан. Баян Хөндийн шинэчилсэн нөөцийн тооцоололд нийт 55,791 метрийн 350 цооног болон 1,075 метрийн 23 суваг малталтын мэдээлэл багтсан.

Зураг 7. Баян Хөндий ордод хийсэн өрөмдлөг



Өрөмдлөгийн хөтөлбөрөөр гурван бүс: Страйкер бүсэд эрдэсжилт газрын гадаргаас эхлэн, Мидфийлд, хойд Мидфийлд бүсүүдэд газрын дөт гүнээс эхлэн алтны өндөр агуулга бүхий бүс тогтвортой үргэлжилж байгааг тодорхойлсон. Эдгээрээс гадна Баруун страйкер, Зүүн Хойд Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий хэсэгт өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэж байна.

20210817



### Металлург

2016-2020 онд Баян Хөндий ордын нөөцийн өрөмдлөгийн дээжид хэд хэдэн үе шат бүхий металлургийн шинжилгээ, судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүнд бутлах, хүндийн хүчний баяжуулалтын тест, хүдрийн оновчлолын програм, цианидын, нүүрсээр уусгах, цианидыг саармагжуулах, ус шавхах зэрэг тестийг гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнд уурхайн ажиллагааны хугацаанд алтны дундаж металл авалтыг 93% байхаар тооцоолсон. Алтны металл авалт нь анхан шатны бутлалт, нунтаглах үе шатнаас ихээхэн хамааралтай ба 80% нь 60 микроноос бага хэмжээтэй бутлахаар үйлдвэрийн суурь тооцоололд ашигласан.

### Техник эдийн засгийн үндэслэл

Рома Ойл Майнинг Ассошиэйтс Лимитед нь хараат бус Баян Хөндий алтны төслийн нарийвчилсан ТЭЗҮ /Bankable Feasibility Study/, NI 43-101 хараат бус техникийн тайланг Канадын NI 43-101 стандартын дагуу 2020 оны 07 сарын 20-ны өдрөөр тасалбар болгон хийж гүйцэтгэсэн. Нарийвчилсан ТЭЗҮ-ийг компанийн веб хуудас болон Канад улсын үнэт цаасны мэдээлэл дамжуулах SEDAR цахим мэдээллийн санд нийтэлсэн.

Энэхүү танилцуулгад тусгасан Баян Хөндий төслийн мэдээллийг дээрх Нарийвчилсан ТЭЗҮ, Компанийн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.



Нэмэлт техникийн мэдээллийг [www.erdene.com](http://www.erdene.com) эсвэл [www.SEDAR.com](http://www.SEDAR.com) цахим хуудсаас авах эсвэл хараат бус зөвлөх Рома Группийн техникийн дүгнэлттэй танилцана уу.

*Баян Хөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ, түүний орчуулга болон холбогдох зөвшөөрлийг Хавсралт №11,12,13-аас үзнэ үү.*

2021.09.22

Б.Серие





### АЛТАН НАР АЛТ-ПОЛИМЕТАЛЛЫН ТӨСӨЛ

2009 оны хайгуулын хөтөлбөрөөр Алтан Нар хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Алтан Нар төслийг нээн илрүүлсэн ба 2018 онд нөөцийн тооцооллыг боловсруулан 2020 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан.


Алтан Нар орд нь Баян Хөндий ордоос хойш 16 км зайд оршдог ба компани 5.6 км урттай хүдэржилт бүхий бүсэд 18 хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлон хайгуул, судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Хайгуул, судалгааны дүнд Алтан Нар ордыг дунд сульфидтай эпитеpmаль алт болон мөнгө, хар тугалга, цайрын полиметаллын орд хэмээн тодорхойлсон хэдий ч өнөөг хүртэл харьцангуй хязгаарлагдмал хайгуул судалгаа хийгдсэн.

### Тусгай зөвшөөрөл

Алтан Нар төсөл нь Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг. Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг анх 2009 оны 12 сард 4,668.64 га талбайд авсан ба 2020 онд ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэн эзэмшиж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 онд 30 жилийн хугацаатай авсан ба ирээдүйд 2 удаа 20 жилээр буюу 70 жил хүртэл сунгах боломжтой.

Энэхүү тусгай зөвшөөрлийн 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг Сэндсторм Гоулд Лтд.-д ирээдүйд хуваарилах нөхцөлтэй.

Зураг 8. Алтан Нар төслийн байршил, тусгай зөвшөөрлийн талбай



### Судалгаа, тайлан

2018 онд RPM Глобал хараат бус техникийн шинжээч нь Алтан Нар алт-полиметаллын төслийн нөөцийн хараат бус техникийн тайланг /Mineral resource technical report/ Канадын NI 43-101 стандартын дагуу 2018 оны 06 сарын 21-ны байдлаар хийж гүйцэтгэсэн. Нөөцийн тооцоололд 2018 оны 05 сарын 07 хүртэл өрөмдлөгийн үр дүнг оруулсан.

Бермисе



2021.10.8-7



Энэхүү танилцуулгад тусгасан Алтан Нар төслийн мэдээллийг дээрх нөөцийн тайлан болон Компанийн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

Хараат бус дүгнэлтүүдийг компанийн цахим хуудас [www.erdene.com](http://www.erdene.com) эсвэл [www.SEDAR.com](http://www.SEDAR.com) цахим хуудсаас танилцана уу.

**Ордын төрөл, эрдэсжилт**

Алтан Нар орд нь Эдрэнгийн арлан нумын терреинд хамаардаг ба Алтан Нар төслийг магма болон порфирын ордтой холбоотой, ихэвчлэн полиметаллаар баяжсан, дундлаг сульфидтэй карбонат-полиметалл-алтны систем гэж тайлбарладаг.

Энэ төрлийн алтны хүдэржилт нь зүүн өмнөд Азийн хамгийн эдийн засгийн үр ашигтай алтны хүдэржилтийн төрөлд хамаардаг бөгөөд Индонезийн Келиан уурхай (одоо хаагдсан боловч урьд нь Рио Тинто олборлолт хийж байсан) болон Папуа Шинэ Гвинейн Поргера алтны уурхай (Баррик Гоулд олборлолт хийж байгаа), мөн дэлхийн өөр бусад газруудад байх Эквадорын Фрута дэл Нортэ алтны уурхай (Лундин Гоулд Инк олборлолт хийж байгаа), Колорадын Крипэл Крик болон Виктор алтны уурхай (АнглоГоулд Ашанти Лимитэд олборлолт хийж байгаа), Руминий Росиа Монтана (Росиа Монтана Гоулд Корпораци олборлолт хийж байгаа) болон дэлхийн шилдэг 5 мөнгө олборлогч компанийн нэг Мексикийн Пенаскүйто (Гоулдкорп олборлолт байгаа) зэрэг ордууд үүнд багтана.

**Нөөц**

RPM Global нь 2018 оны 05 сарын 07 хүртэл бүрдүүлсэн өрөмдлөг, судалгааны үр дүнд тулгуурлан Алтан Нарын геологийн нөөцийг хэтийн төлөв бүхий 2 дэд талбайд тооцоолсон.

Ил уурхайн нөөцийн захын агуулгыг 0.7 гр/тн AuEq харин ил уурхайгаас гүнд буй нөөцийн захын агуулгыг 1.4 гр/тн AuEq байхаар хязгаарлан тооцоолол хийсэн. Нөөцийн 90% нь газрын дөт гүнд буюу 150 метрт агуулагдаж байгаа ба эрдэсжилт суналын дагуу болон гүндээ нээлттэй хэвээр байна. Дээр дурдагдсан нийт 2 дэд талбайгаас Нээлтийн Бүс хэмээх голлох талбайд нийт нөөцийн 60% нь агуулагддаг. Цаашид хэтийн төлөв бүхий дэд талбайнуудад нэмэлт хайгуул, өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэснээр нөөц өсөх боломжтой.

Хүснэгт 9. Алтан Нар ордын геологийн нөөцийн тооцоолол


Нөөцийн ангилал	Нийт		Алт		Мөнгө		Цайр		Хар тугалга		AuEq	
	сая.тн	г/т	м.унц	гр/тн	м.унц	%	м.тн	%	м.тн	гр/тн	м.унц	тн
Бодитой / Indicated	5.0	2.0	317.7	14.8	2,349.7	0.6	31.6	0.6	29.0	2.8	453.0	14.1
Боломжтой / Inferred	3.4	1.7	185.7	7.9	865.8	0.7	23.7	0.7	22.3	2.5	277.1	8.6

1. Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын эрдэсжилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
2. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай
3. \*Au Equivalent (AuEq) буюу алтны дүйцэх нэгж нь 2023 - 2027 "Energy & Metals Consensus Forecasts"-ын 2018 оны 3 сарын 19-ний өдрөөр алтыг нэг унц US\$1310, мөнгийг нэг унц US\$17.91, хар тугалга нэг фунтыг US\$1.07, цайрыг нэг фунтыг US\$1.42 байхаар тооцоолсон. Металлург метал авалтыг компанийн урьд нь хийгээд анхан шатны судалгаанд тулгуурлан хийсэн бөгөөд уусгалтын аргаар, үүнд колчеданы арга орфо нь баяжмалыг ялган авах нь алт болон мөнгийг салгах боломжтой. Алт, мөнгө, хар тугалга, цайрын агуулж буй метал болон агуулж буй харьцаа бүгд эдийн засгийн хувьд гарган авахад үр ашигтай байх боломжтой гэж үзсэн.

2021.09.03

Бернис






- a. Алтны дүйцэх нэгжийн агуулгын тооцоолол:  $AuEq \text{ гp/тн} = Au \text{ гp/тн} + Ag \text{ гp/тн} * 0.0124 + Pb \% * 0.509 + Zn \% * 0.578$ , метал авалт 88.8% Au, 80.6% Ag, 80.4% Pb болон 69.1% Zn.
- b. Алтны дүйцэх нэгжийн унцыг нөөцийн тооцооллын тонныг алтны дүйцэх нэгжийн агуулгад үржүүлэн, унаад шилжүүлсэнээр тооцоолсон. Ашигласан тооцоолол:  $AuEq \text{ унц} = [Тонн \times AuEq \text{ агуулга (гp/тн)}] / 31.1035$ .
- 4. Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан
- 5. Алтны дүйцэх нэгжийг ("AuEq") алтыг нэг унц 1,310 ам.доллар, ил уурхайн зардал нэг тонн тутамд US\$6, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$20, ба метал авалт 88.8% Au, 80.6% Ag, 80.4% Pb and 69.1% Zn.

### Хайгуулын ажил

2009 онд тусгай зөвшөөрлийг авснаар Эрдэнэ Ресурс нь геологийн эрэл хайгуулын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн ба үүнд хөрсний геохимийн дээжлэлт болон бусад анхан шатны эрэл-хайгуулын ажлууд багтсан.

2013 оноос 2017 онуудад хийгдсэн хайгуулын ажлаар буюу суваг малталт, гадаргуун геологийн зураглал, геохими болон геофизикийн судалгааны ажлууд болон олон үе шаттайгаар эрэл болон нөөц тогтоох өрөмдлөгийн ажил хийснээр хүдэржилттэй талбайг тэлж чадсан. 2011-2018 онуудад тус талбайд нийт 19,490.6 тууш метр бүхий 125 цооног, нийт 3,151 тууш метр бүхий 42 сувгийг малтсан ба эдгээр хайгуул, өрөмдлөгийн үр дүн нь 2018 оны RPM-ийн анхан шатны эдийн засгийн нөөцийн тооцоололд орсон.

Зураг 9. Алтан Нар ордын хэтийн төлөв бүхий талбайнууд



20210907


### Өрөмдлөг

Компани 2021 оны 6-р сарын 30 өдрийн байдлаар нийт 20,867 тууш метр бүхий 133 цооногийн өрөмдлөг, дээжлэлт болон холбогдох судалгааг хийгээд байна.

### Металлург

2012-2019 онд Алтан Нар ордоос авсан өрөмдлөгийн дээжид ALZ Ammetc (Австрали), Actlabs Asia LLC (Монгол), Blue coast Research Ltd (Канад) болон SGS Canada Inc (Канад) зэрэг компаниудаар металлургийн судалгаа, шинжилгээг хийлгэж гүйцэтгүүлсэн.

*Бүрэлд*





### 1.6.6. Хэтийн төлөв бүхий талбай

#### ХАР МОРЬ АЛТНЫ ТӨСӨЛ

Хар Морь ("Dark Horse" эсхүл "Khar Mor") талбай нь Баян Хөндий төслөөс хойш 3.5 км зайд, Алтан Сум талбайтай залгаа, Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог.

2019 оны 4-р улиралд хайгуулын үр дүнгээр Хар Морь талбайн баруун хэсэгт орших 4 км үргэлжлэх бүс нь газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт агуулж байгааг нээсэн. Хар Морь нь 1.5км х 3км талбайг хамардаг ба 1.4 км урт структурын дагуубайршсан зүүн хойш чиглэлтэй хөрсөн дэх алтны үргэлжилсэн нарийн аномаль бүхий хэтийн төлөв өндөртэй талбай юм.

2019-2021 онд нийт 12,395 тууш метрийн 94 цооног өрөмдсөний ихэнх нь тодорхой алтны хүдэржилтийг огтолсон бөгөөд өндөр агуулга бүхий интервалууд илрээд буй нь энэхүү талбайг хайгуулын хэтийн төлөв өндөртэй болохыг харуулдаг. Цаашид нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байгаа ба геофизик, хувирлын эрдсийн судалгаа, петрографи, минерограф, хий-шингэний ормын мөрийн судалгаа 3D загварчлал хийгдэж байгаа нь Хар Морь талбайн ирээдүйн өрөмдлөгийн төлөвлөгөөг боловсруулахад ашиглагдана.

#### Эрдэсжилт, структур

Хар Морь талбайн структурыг хөрсөнд илэрсэн алтны аномаль, чулуулгийн дээжлэлтээр илэрсэн маш өндөр алтны агуулга, кварцын биетийн үлдэгдэл, эрчимтэй цахиуржилт болон цагаан гялтгануурын хувирал гэж тодорхойлсон. Хар Морь талбайн одоогийн тайллаар зүүн хойд чиглэлийн хагарлуудын дагуу, баруун хойд чиглэлийн хагарлуудтай огтлолцох гол зүүн хойд структурын дагуу байрласан шүдлэг-кварц, штокверк судлуудаар хянагдсан алтны хүдэржилтийг агуулсан хэмээн таамаглажээ. Энэхүү эсрэг структуруудын огтлол нь шингэн урсгал болон дараалсан алтны давхарга үүсгэхэд тааламжтай бүсийг бий болгосон байх боломжтой. Хар Морь талбайд хязгаарлагдмал судалгаа хийсэн, судлын дагуу томоохон нээлт хийх боломжтой бөгөөд зүүн хойд-баруун хойд структурын огтлолтой ойролцоо хөрсөнд хэд хэдэн алтны аномаль илэрсэн.

#### Хайгуул, өрөмдлөгийн ажил

Тус хэтийн төлөвт талбайг 2019 оны 4-р улиралд нээж илрүүлсэн ба өмнө хайгуул харьцангуй бага хийгдэж байсан талбай юм. Дараах геологи-хайгуулын ажлыг гүйцэтгэсэн.

- Кварцын судлуудын гадаргууд хийсэн дээжлэлт
- Геофизикийн 3D загварчлал, геофизикийн мэдээллийн шинжилгээ үнэлгээ, тайлал
- Нарийвчилсан чулуулгийн болон хөрсний геохимийн дээжлэлтийн судалгаа
- Геологийн зураглал болон суваг малталтын хөтөлбөрүүд
- Геофизикийн хүндийн хүчний 3D загварчлал, хүндийн хүч болон соронзон орны судалгаа-загварчлал
- Петрограф, минерограф, хий-шингэний ормын мөрийн судалгаа

2021.03.03



**2019 он**


2019 онд гүйцэтгэсэн нарийвчилсан геологийн зураглал болон геохимийн дээжлэлт (чулуулгийн болон хөрсний) зэрэг газрын гадаргууд хийсэн хайгуулын ажлын үр дүн:

- Кварцын штокверк судлаар зүсэгдсэн массив турмалиныг дээжлэн, 32.9 гр/тн алтны агуулга;
- Нэмэлт гадаргуун хайгуул буюу геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийсэн бөгөөд үүнээс бш дээжинд буюу сиенит-порфирийг зүссэн шүдлэг кварц-адулярын судалд 5-87.8 гр/тн хүртэл алтны агуулгууд илэрсэн.

**2020 он**

2020 оны 2-р улиралд, нарийвчилсан зураглал, өндөр нягтрал бүхий торлолоор хөрс, чулуулгийн дээжлэлт, суваг малталт зэрэг нийт 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэсэн. Энэхүү суваг малталтын ажлын үр дүнг хөрсний геохимийн дээжлэлт, сорьцлолт болон геологийн зураглалын үр дүнгүүдтэй нэгтгэж үзсэнээр Хар Морь талбайг хэтийн төлөв өндөртэй болохыг тогтоосон.

Зураг 10. Хар Морь талбайн 2020 оны 2-р улирлын хайгуулын үр дүн



- KMT-01 50.8 гр/тн алтны агуулга бүхий 1 метр агуулсан 8.8 гр/тн алтны агуулга бүхий 6 метрийн интервал
- KMT-02 Хүчтэй самнасан кварц штокверкын бүс
- KMT-03 45.3 гр/тн алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 14 гр/тн алтны агуулга бүхий 4 метрийн интервал

2021.09.07

Эрдэнэ Ресурс нь 2020 оны 3, 4-р улиралд Хойд-Өмнөд (N-S) структурын дагуу алтны хүдэржилт бүхий 1.2 км структурын трендийг тодорхойлон судлагдаагүй бүсэд 4,660 метрийн турш 25 цооногийг (AAD-40-аас 64 хүртэл) өрөмдсөн. Бүх цооногуудад алтны аномаль агуулга болон/эсвэл индикатор элементүүд (As, Mo, Sb) бүхий өргөн бүсүүд огтлогдсон. 6 цооногт алтны эрдэсжилт өндөр илэрсэн.

**2021 оны 1-р улиралд хийсэн өрөмдлөгийн үр дүн**

2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Хар Морь талбайн Дэл бүсийн өмнөд хэсэгт хийсэн өрөмдлөгийн хайгуулын хөтөлбөрийн анхан шатны үр дүнг танилцуулсан. 4-р сарын 20-нд эцэслэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр нийт 3,757 метрбуюу 37 цооног өрөмдсөн. Хойш-

*Берие*

МХБ-ийн гишүүн  
Андрей Сергеевич  
Л. роков. дүрсний  
"БЭХСОН" УИР-ийн  
192054



урагш чиглэлтэй структур бүхий Хар Морь талбайн Дэл бүсийн өмнөд хэсэгт 300 метрийн чиглэлд нийт 1,072 метрийн 10 цооногийн үр дүнг хүлээн авсан.

Хүснэгт 10. Хар Морь талбайд хийсэн өрөмдлөгийн онцлох дүн: 2021 оны 1-р улирал

Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал <sup>1</sup>	гр/тн алт <sup>2</sup>
AAD-79	31	39	8	1.81
Түүнд	32	36	4	3.23
AAD-81	4	39	35	2.65
Түүнд	5	17	12	5.10
Түүнд	5	6	1	19.11
Түүнд	12	13	1	14.04

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Хар морь талбайд эрдэсжсэн бүсийн чиглэлийг тодорхойлох хангалттай өрөмдлөг хийгдээгүй тул одоогоор бодит зузааныг тодорхойлох боломжгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногууд нь (зөв өнцгөөр) 45-75 градусын уналтаар энгийнээс боломжит эрдэсжсэн талбайн трендийн дагуу өрөмдсөн.
2. Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 гр/тн алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

### 2021 оны 2-р улиралд хийсэн хайгуулын өрөмдлөгийн үр дүн

2021 оны 2-р улиралд Хар Морь талбайн Дэл бүсийн урд зүгт гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажлаар өргөн, газрын дөт гүнд (100 метрийн гүнд), бага агуулга бүхий алтны бүсүүдийг баталгаажуулсан. AAD-89, AAD-95 болон AAD-98 цооногуудын огтлолцолд хамгийн өндөр хувирал болон эрдэсжилттэй бүсүүд илэрсэн ба алт агуулсан хэд хэдэн бүсийг огтолсон.

Мөн 2-р улиралд эхлүүлсэн 3,000 метрийн хайгуулын хөтөлбөрийн үр дүнгүүдийг 7-р сард танилцуулсан. Үүнд: Баян Хөндий алтны ордоос хойш 3.5 км-т орших Хар Морь талбайн Дэл бүсийн өмнө хэсэгт судлын дагуу доош уналттай эрдэсжсэн бүсэд хэд хэдэн цооногт өндөр агуулгатай ( $\geq 1$  г/т алт) эрдэсжилтийг огтолсон:

Хүснэгт 11. Хар Морийн Дэл (өмнөд) талбайн 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т алт
AAD-120	83	84	1	0.67
Ба	178	180	2	0.37
AAD-121	38	40	2	0.46
Ба	48	58	10	1.01
AAD-122	80	85	5	2.13
AAD-123	58	88	30	2.86
Түүнд	61	72	11	7.03
Түүнд	63	64	1	17.59
түүнд	67	68	1	16.50
AAD-124	18	19	1	1.74
Ба	24	51	27	5.86
Түүнд	28	31	3	17.41 <sup>(2)</sup>
Түүнд	33	34	1	14.03
Түүнд	37	38	1	25.37
Түүнд	42	43	1	10.08
Түүнд	46	47	1	11.51

Б.Сүрэн





2021.09.07

Ба	60	61	1	0.36
AAD-125	65	72	7	3.65
Ба	100	101	1	0.32
AAD-126	10	40	30	5.63
Түүнд	21	33	12	13.38
Түүнд	26	32	6	24.12 <sup>(3)</sup>
AAD-127	60	67	7	2.33
Түүнд	65	66	1	10.24
Ба	71	72	1	6.22
AAD-128	38	39	1	0.47
Ба	47	51	4	0.58
Ба	55	63	8	0.36
AAD-129	4	37	33	2.05
Түүнд	14	26	12	5.07
Түүнд	17	18	1	38.44
AAD-130	9	45	36	1.39
Түүнд	23	40	17	2.46
Түүнд	24	25	1	10.74
AAD-132	42	53	11	0.54
AAD-133	3	4	1	0.31
Ба	11	18	7	0.32
Ба	20	21	2	0.42

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. >10 г/т алтны агуулга бүхий гурван зэргэлдээ дээж багтсан. Үүнд 13.78-аас 21.71 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.
3. >10 г/т алтны агуулга бүхий зургаан зэргэлдээ дээж багтсан. Үүнд 13.97-аас 36.49 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.

Зураг 11. Хар Морь хэтийн төлөв бүхий талбайн өрөмдлөгийн үр дүн 2021 оны 2-р улирал





### АЛТАН СУМ

Алтан Сум хэтийн төлөв бүхий талбай нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлах ба Баян Хөндий ордоос хойд зүгт 4.0 км зайд оршдог. Анх 2013 оноос Алтан Сум ордод урьдчилсан хайгуул хийж эхлэн хайгуулын үр дүнгүүд ахицтай байсан ч 2015 онд Баян Хөндий ордыг илрүүлснээр хайгуул судалгааны ажлуудыг Баян Хөндийд голчлон төвлөрүүлсэн.

### Өрөмдлөгийн үр дүн

Өрөмдлөгийн судалгаа нь талбайн гол структурын өндөр агуулгыг огтолсон өмнө бүсэд төвлөрсөн ба Алтан Сумд өрөмдсөн эхний 21 цооногийн (2,605 тууш метр) 77% нь алтны аномаль хүдэржилт огтолсон. Онцлох үр дүн:

- 39 гр/тн алтны агуулга бүхий 1м интервал,
- 70 гр/тн алтны агуулга бүхий 2м интервал огтлогдсон.

Энэхүү талбайд нийт 5,407 метрийн 39 цооног өрөмдсөн ба өрөмдлөгийн судалгаагаар алтны хүдэржилт нь нийт 1.2 км (суналын дагуу нээлттэй) урттай коридорыг үүсгэж буйг тогтоосон бөгөөд хүдрийн биет байх магадлалтай хэсгээс өмнө зүгт 400 метрт мөн алтны хүдэржилт илрүүлсэн.

Хайгуул судалгааны үр дүнгээс үзэхэд дүүрэг дэх алтны хүдэржилт нь структурын огтлол болон тэлэх чадвар бүхий гол бүсүүдээр хянагдсан байна. Эдгээр бүсүүд нь гидротермаль хувирлаас үүдэлтэй магнетитийн задралтай холбоотой, нам соронзон шинж чанар бүхий бүсүүдийг бий болгосон.

### УЛААН ЗЭС-АЛТНЫ ПОРФИРИЙН ТӨСӨЛ

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Эрдэнэ Ресурсийн Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд зэргэлдээ оршдог ба нийт 1,780 га талбайг хамардаг. Эрдэнэ Ресурсийн 100% охин компани болох Лидер Эксплорейшн ХХК тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна.

2021 оны 8-р сард Эрдэнэ Ресурс нь Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баян Хөндий ордоос баруун зүгт 300 метрт алтны шинэ нээлт хийсэн. Энэхүү анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөрийг Улаан тусгай зөвшөөрлийн талбайн урд бүсэд Баян Хөндий алтны ордтой төстэй эрдэсжилт байгаа эсэхийг шалгах зорилготой гүйцэтгэсэн.

Хүснэгт 12. 2021 оны 3-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтны агуулгатай)

Цооног	М-ээс	М хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т алт
UDH-07	85	185	100	0.63
ба	250	254	4	1.39
ба	340	350 <sup>(2)</sup>	10	0.34
UDH-08	20	22	2	0.44
UDH-10	69	70	1	0.57
ба	92	350.2 <sup>(2)</sup>	258.2	0.98
Түүнд	99	139	40	3.77



20210827

Б.Сереев



Түүнд	103	104	1	39.57
Түүнд	123	124	1	58.4
UDH-13	96	112	16	0.79
ба	134	154	20	0.38

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Цооногийн төгсгөл
3. Цооног UDH-09, UDH-11 ба UDH-12 нь алтны эрдэсжилт огтлоогүй (0.3 г/т алт).


Компани нь 2017 оны 3-р улиралд Улаан тусгай зөвшөөрлийн талбайг эзэмшиж буй Лидер Эксплорейшн ХХК-ийн 51%-ийг худалдан авсан ба улмаар 2020 оны 12-р сард үлдсэн 49%-ийг 755,000 ам.доллараар худалдан авснаар 100% эзэмших болсон.

Улаан хайгуулын тусгай зөвшөөрөл нь 7 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт Малтмалын тухай хуульд заасан нөхцөлүүдийг хангаснаар хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд хөрвүүлэх боломжтой.

### Эрдэсжилт тогтоц

Порфирын зэс болон эпитеpmаль алтны системийн шинж чанар бүхий кварц-серицит-пирит (QSP)-ийн хүчтэй хувирлын томоохон бүсийг (ойролцоогоор 3км диаметр) агуулдаг. Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км х 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирийн хэтийн төлөвтэй талбай юм.

Зураг 12. Улаан талбай геологийн тогтоц



20210827

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь томоохон хувирлын бүсийн зүүн өмнө зүгт байрладаг ба энэхүү хувирлын бүс нь зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь

*Берисе*




Баян Хөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг.

**Хайгуул, үнэлгээний ажил**

2021 оны хайгуулын ажлын хүрээнд Улаан тусгай зөвшөөрлийн талбайн урд бүсэд Баян Хөндий алтны ордтой төстэй эрдэсжилт байгаа эсэхийг шалгах зорилготой гүйцэтгэсэн. Энэхүү хөтөлбөрөөр нийт 1,543 тууш метрийн 7 цооног өрөмдсөн. Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдсөн хэд хэдэн цооногт эрдэсжилт огтолсноор алтны шинэ нээлт хийсэн.

Зураг 13. Улаан талбай: Байрлал, 2021 оны хайгуулын хөтөлбөрийн хүрээ



20210827


**ХӨВИЙН ХАР ТАЛБАЙ**

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл нь Хөвийн Хар ашиглалтын зөвшөөрлийн талбайд байрладаг ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн ордоос баруун хойд зүгт 2.2 км байрладаг.

Хөвийн Хар талбайд геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хоорондох зай нь хол байх өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилшалгах өрөмдлөгийн ажлаар 308-342 метр гүнд

ХААМБААТАР ХОТ  
 УЛААН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ  
 БИШГЭГЧИЙН ҮЙЛ АЖ АХУЙ  
 111500047-20210903

*Бермисе*



34 метрийн 1.3% зэс болон 9.24 гр/тн мөнгөний агуулгатай интервал огтолсон (цооног ZMD-121). Хөвийн Хар талбайд хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-иас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон. Хайгуулын ажлын үр дүн нь зэс порфирийн төрлийн хүдэржилт Хөвийн хар талбайд байгааг баталгаажуулсан.

Зэс ба молибденийн үнэ өнгөрсөн жилүүдэд өссөн ба ойрын хугацаанд тогтвортой чанга байх төлөвтэй байгаа ба бусад зах зээлийн таатай нөхцлийг харгалзан 2021 оны 07 сард компани Зуун Мод орд болон Хөвийн Хар хэтийн төлөв бүхий талбайд стратегийн үнэлгээг эхлүүлсэн.

### ХОЙД ХӨНДИЙ ТАЛБАЙ

Хойд Хөндий талбай нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Баян Хөндий ордоос зүүн хойд зүгт 4 км-т оршдог бөгөөд 2018 онд анхны өрөмдлөгийн ажлыг хийсэн.

2017 онд хийсэн гадаргуун хайгуулын зураглалын үр дүнд энэхүү талбайг илрүүлсэн бөгөөд 650 метр урт үргэлжлэх структураар хянагдсан кварцын штокверк болон брекчийн судлын бүсээс дээжилсэн кварцын судлын биетэд 22 гр/тн хүртэл өндөр агуулга бүхий алтны хүдэржилт илэрсэн. Хойд Хөндий талбай нь ирээдүйн хайгуулын өндөр боломж, хэтийн төлөвтэй талбай юм.

20210827

*Бермаа*





### 1.6.7. Байгууллагын нийгмийн хариуцлага

Компани нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, амьжиргааг дэмжих чиглэлээр орон нутгийн оролцогч талуудтай хамтран ажилладаг.

Байгаль орчны менежментийн хувьд компани байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг (Ус, хог хаягдал, хүрээлэн буй орчин, эрчим хүч) бууруулах арга хэмжээг тогтмол гүйцэтгэн, хянаж, тухайн ашигт малтмалын төслийн хэрэгжилтийн хугацаанд шинэчлэн ажилладаг.

Мөн компани нь алслагдсан орон нутгийн худгуудыг нөхөн сэргээх, Байгаль орчны нөлөөлөл бууруулах хаягдлын нэгдсэн санг ("IWF") Монгол улсад нэвтрүүлж буй анхны уул уурхайн компани болсон. Баян Хөндийн бүтээн байгуулалтад мөн усны 85%-ийг дахин ашиглах боловсруулах үйлдвэр; нарны эх үүсвэрийг ашиглах зэрэг байгаль орчны менежментийн шинэлэг шийдлүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.


Эрдэнэ Ресурс төслийн талбай, оффисийн байр бүрд ажлын байран дахь эрүүл мэнд, эрүүл ахуйн арга хандлагыг хэвшүүлэн сахиулдаг ба эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, харуул хамгаалалтын бодлого нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хамгаалалтын асуудалтай холбоотой эрсдлүүдийг үнэлж, бууруулах заавар журам, протоколыг дагаж мөрдөн ажилладаг. Хүн, байгаль орчинтой холбоотой ямар нэгэн эрсдэл илэрсэн тохиолдолд Компанийн зүгээс хяналт шалгалтыг нэн даруй хийж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авдаг. Компани нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг байнга хянаж, сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, ажилчдын мэргэшлийг дээшлүүлсээр ирсэн.

Компани нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд Баянхонгор аймгийн Шинэжинст суманд төвлөрч ажилласан. 2018 онд Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгэл хийлгэснээр Шинэжинст, Баян-Өндөр сумдад нийт 5,000 гаруй иргэнд хувьцаа эзэмшүүлсэн. Орон нутгийн иргэд хувьцаа эзэмшсэнээр хувьцаагаар дамжуулан уул уурхайн баялгаас өгөөж хүртэх, саналын эрхээрээ ХЭХ-д оролцож, хяналт тавих, байнгын мэдээлэл бололцоо нээгдсэн. Мөн Хөрөнгийн зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалтын мэдлэг авах ач холбогдолтой.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Баянхонгор аймагт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиглэлүүд:

- Иргэд, орон нутгийн хөгжлийг дэмжих
- Ажлын байр, сургалтын хөтөлбөрүүдээр иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах
- Хайгуул, олборлолтоос үүсэх нөлөөллийг бууруулах байгаль орчны хөтөлбөр
- Ил тод, шударга, нээлттэй харилцааг бий болгох
- Байгаль орчин хамгаалах, уурхай, үйлдвэртэй холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх
- Иргэдэд компани, үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүргүүлэх

2007 оноос 2020 оны хугацаанд Эрдэнэ Ресурс нь орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд 1.3 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт Баянхонгор аймагт хийснээс 656 сая төгрөгийг аймгийн түвшинд, Шинэжинст суманд 404 сая төгрөг, Баян-Өндөр суманд 237 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Эдгээр хөрөнгө оруулалтыг дараах үйл ажиллагаанд зарцуулсан байна.





### ЭРҮҮЛ МЭНД

### БАЙГАЛЬ ОРЧИН



Иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн нэгдсэн эмнэлгийн уламжлалт эмчилгээний тасгийг тохижуулав.



Дэлхийн усны өдөр болон Говийн мазаалайг хамгаалах өдрийг олон нийтэд таниулах, нэн ховор биологийн төрөл зүйлийг хамгаалах ажлыг хийсэн.



Шаргалжуутын рашаан сувилал дахь саажилттай хүүхдийн Халуун болор сувиллын бүтээн байгуулалтын хандивын аянд нэгдэв.



Эхийн голын тунхаглалын ажлыг гүйцэтгэх, ГГ-6 уулзалт зохион байгуулсан.



Жил бүрийн "Хөдөлгөөн ба эрүүл мэнд" бүх нийтийн эрүүл мэндийн хөтөлбөрийг санхүүжүүлж ажилласан.



Сэгс цагаан богд уул орчмын цэвэр усны эх үүсвэрийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Шинэжинст сумын хүн эмнэлгийн зөөлөн эдлэл шинэчлэх, эмийн эргэлтийн санг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлсэн.




Биологийн олон янз байдлыг хамгаалах, булаг шандны эх үүсвэрийг хамгаалах ажлын хүрээнд Зуун Мод, Толь булгийн эхийг хамгаалах, хөв далан байгуулах ажлыг гүйцэтгэсэн.



20210807

*Бермас*





ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



### БОЛОВСРОЛ

### АМЬЖИРГААНЫ ТҮВШИН



2013 оноос хойш сургалтын тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж 80 орчим оюутанд тэтгэлэг олгосон.



Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой залуу гэр бүлүүдийг малжуулах хөтөлбөр хэрэгжүүлэв.



Залуу багш нарыг дэмжих анхдугаар чуулганыг аймгийн ЗДТГазартай хамтран зохион байгуулсан.



Дэд бүтцийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлын нэгдсэн цэг, булгийн эх, онгоц буудлыг хашаажуулах, ундны усны эх үүсвэрийг бий болгох ажлыг хийж гүйцэтгэсэн.



Сургуулийн өмнөх насны боловсролыг дэмжих зорилгоор бага насны хүүхдийн сурах орчныг сайжруулав. ЕБС-ийн дотуур байр, хүүхэд хөгжлийн төвд хөрөнгө оруулав.



Аймгийн хэмжээнд анх удаа Уртын гол багт эрсдэлээс хамгаалах өвс тэжээлийн санг бий болгов.



ЕБС-ийн мэдээллийн технологийн кабинетийн тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хэрэгжүүлэв.



Бэлчээрийн хүртээмж ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор худаг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Сургалтын орчин сайжруулах төслийн хүрээнд нэгдүгээр ангийн иж бүрэн тохижилт, Монгол хэл, технологийн кабинетийн тохижилтод хөрөнгө оруулав.



Орон нутгийн бизнесийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор сумын оёдлын цехэд хөрөнгө оруулж үйл ажиллагааг эхлүүлэв.



Нутгийн иргэдэд Ажлын байрны чиглэл олгох сургалт хөтөлбөр хэрэгжүүлж байна.



Орон нутагт цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх бүрт өвс ба малын тэжээл нутгийн малчдад нийлүүлж байв.

2021.09.22



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бөгөөд*





## 1.7. Санхүүгийн үзүүлэлтүүд

### 1.7.1. Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Компанийн 2019, 2020 оны жилийн эцсээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн Монгол орчуулгыг Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан.

*Хавсралт №14, 15, 27-оос Аудитлагдсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг, орчуулгын хамтаар, сүүлийн 6 сарын санхүүгийн тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл, 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг харна уу.*

#### Үйл ажиллагааны онцлог: Хөрвөх чадвар болон хөрөнгийн талаар

Үйл ажиллагааны онцлог буюу бусад хайгуулын компаниудын адилаар Компани нь хайгуулын төслүүдийг голчлон опцион, түншлэл, үнэт цаас, болон хөрөнгө борлуулалтын аргаар санхүүжүүлдэг. Энэхүү санхүүжилтийн хэмжээ ба хугацааг Компанийн хайгуулын хөтөлбөрийн үр дүн, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалд тулгуурлан тодорхойлдог.

Компани нь хайгуул болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг дээр дурдсан аргаар санхүүжүүлдэг тул Компанийн ашиг орлогын түвшин, ирээдүйн мөнгөн гүйлгээ болон санхүүгийн хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй.

#### Санхүүгийн эрсдэл

Канад улсын үнэт цаасны эрх зүйн хүрээнд Компани нь санхүүгийн эрсдлүүдэд дүн шинжилгээ хийх, олон нийтэд танилцуулах үүрэг хүлээсэн. Компанийн санхүүгийн эрсдэлүүдийг тодорхойлбол:

- *Кредит эрсдэл:*

Кредит эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдлийг агуулдаг. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь хөрөнгө оруулалтын баталгаажсан гэрчилгээ, банкинд байршуулсан хадгаламжаас бүрдэнэ. Удирдлагын зүгээс Компани мөнгөн хөрөнгөө алдах эрсдэл бага гэж үзэж байгаа бөгөөд Канадын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөө байршуулах замаар зээлийн эрсдлийг удирдаж байна.

- *Хөрвөх чадварын эрсдэл:*

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

- *Зах зээлийн эрсдэл:*

#### *Хүүгийн эрсдэл:*

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь хүүтэй зээл байхгүй хүүгийн эрсдэлд өртөхгүй.

#### *Гадаад валютын эрсдэл:*





ЭРДЭНС РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



Компанийн үйл ажиллагааны голлох валют нь Канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь Монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь Америк доллараар санхүүжилт авч, зардал гаргадаг. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкуудад Канад болон ам.доллар байршуулдаг.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн нөхцөл байдлын шинжилгээгээр ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$6,900 кан.долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2019.12.31 - \$277,200). Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$8,100 кан.долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2019.12.31 - \$5,600) байна.

**Үнийн эрсдэл:**

Компани нь тогтвортой мөнгөн орлогогүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

20210907

*Бсерина*





ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

## Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 13. Санхүүгийн байдлын тайлан

/канад доллар/	2018.12.31	2019.12.31	2020.12.31
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,748,249	5,106,863	12,800,728
Дансны авлага	113,412	70,361	89,344
Урьдчилж төлсөн зардал	34,633	69,029	212,479
<u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u>	<u>1,896,294</u>	<u>5,246,253</u>	<u>13,102,551</u>
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	15,687,348	21,483,517	29,364,155
Хөрөнгө ашиглах эрх	-	137,064	107,693
Үндсэн хөрөнгө	125,277	105,998	239,431
<u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u>	<u>15,812,625</u>	<u>21,726,579</u>	<u>29,711,279</u>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>17,708,919</b>	<b>26,972,832</b>	<b>42,813,830</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
Арилжаа болон бусад өглөг	224,387	591,999	582,356
Түрээсийн өглөг	-	25,697	27,853
<u>Богино хугацаат өр төлбөр</u>	<u>224,387</u>	<u>617,696</u>	<u>610,209</u>
Түрээсийн өглөг	-	113,553	85,699
Хөрвөх боломжтой зээл	-	6,260,521	-
<u>Урт хугацаат өр төлбөр</u>	<u>-</u>	<u>6,374,074</u>	<u>85,699</u>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>224,387</b>	<b>6,991,770</b>	<b>695,908</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	104,003,644	109,466,565	136,618,086
Нэмж төлөгдсөн капитал	16,110,116	16,829,920	25,937,667
Хуримтлагдсан ба бусад алдагдал	(955,713)	(1,958,616)	(2,964,666)
Алдагдал	(101,673,515)	(104,356,807)	(117,473,165)
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17,484,532</b>	<b>19,981,062</b>	<b>42,117,922</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>17,708,919</b>	<b>26,972,832</b>	<b>42,813,830</b>

### Нийт хөрөнгө

- Компани нь эрдсийн нөөц тогтоохтой холбоотой бүх шууд зардлыг хайгуулын төсөл тус бүрээр капиталжуулан бүртгэдэг. Хайгуул, үнэлгээний хөрөнгийг эхлээд зардал байдлаар хэмжин, биет хөрөнгөөр ангилдаг. Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд: хайгуул, судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг, суваг малталт, дээжлэх эрхийг олж авах болон төслийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бусад шууд зардлууд орно.
- Хайгуулын төсөл эсвэл талбайн боломжийг тодорхойлж, ТУЗ-өөр батлагдаж хайгуул, үнэлгээний зардал капиталжих хүртэлх хугацаанд гарсан хайгуулын зардлыг үйл ажиллагааны зардлаар зарлагдана.

### Өр төлбөр ба эздийн өмч

- Компани хувьцаа, хувьцаа худалдан авах эрх, опцион гарган үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг.
- Компанийн хуримтлагдсан алдагдал 2020 оны 12 сарын 30-ны өдрийн байдлаар 117.5 сая кан.доллар байна.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Бермас



2021.09.22

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN



**Нэгтгэсэн дэлгэрэнгүй алдагдлын тайлан**

Хүснэгт 14. Ашиг алдагдлын тайлан

/канад доллар/	2018.12.31	2019.12.31	2020.12.31
<b>Үйл ажиллагааны зардал</b>			
Хайгуул, үнэлгээний зардал	1,595,675	1,090,786	1,372,811
Ерөнхий болон удирдлагын зардал	2,120,390	1,615,724	1,868,905
<b>Үйл ажиллагаанаас учирсан алдагдал</b>	<b>3,716,065</b>	<b>2,706,510</b>	<b>3,241,716</b>
Санхүүгийн орлого	(50,816)	(36,512)	(62,858)
Хүүгийн зардал	-	165,934	1,661,960
Санхүүгийн хэрэгслээс үүдсэн үнэ цэнийн зөрүү	-	(178,972)	8,508,076
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (олз)	(8,259)	26,332	(232,536)
<b>Цэвэр алдагдал</b>	<b>3,656,990</b>	<b>2,683,292</b>	<b>13,116,358</b>
<b>Бусад дэлгэрэнгүй алдагдал:</b>			
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү	60,858	1,002,903	1,006,050
<b>Бусад дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>60,858</b>	<b>1,002,903</b>	<b>1,006,050</b>
<b>Нийт дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>3,717,848</b>	<b>3,686,195</b>	<b>14,122,408</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь, алдагдал	0.02	0.02	0.06
<b>Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо</b>	<b>155,104,960</b>	<b>178,522,823</b>	<b>216,535,792</b>

- 2020 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст Компанийн алдагдал \$13,116,358 байсан нь 2019 оны мөн үеийн \$2,683,292 -той харьцуулахад өссөн.
- 2020 оны 12 сарын 31-нд эцэслэгдсэн жилийн эцсийн капиталжуулсан зардлыг хамруулсан хайгуулын зардал \$9,276,028 байсан нь өнгөрсөн оны мөн үеийн \$6,694,914 кан.доллортой харьцуулахад өссөн бөгөөд энэ нь Компанийн тухайн жилд гүйцэтгэсэн 15,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөртэй холбоотой бөгөөд 2019 онд дунджаар 5,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Түүнээс гадна Баян Хөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ, нарийвчилсан инженерийн загварчлал, болон бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудад зарцуулсан зардлууд нь өнгөрсөн жилийн урьдчилсан ТЭЗҮ-тэй харьцуулахад өссөн.
- Компани, захиргааны зардал 2020 оны 12 сарын 31-нд \$1,868,905 байсан нь 2019 оны мөн үеийн \$1,615,724-тэй харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Энэ нь захиргааны цалин, хөрөнгө оруулагчтай харилцах зардлууд болон бэлэн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн зардал өссөнтэй холбоотой.
- Мөнгөн бус бодит үнэ цэнийн тохируулга болох \$8,412,081 ба хуримтлагдсан хүүгийн зардал болох \$1,661,960 байсан нь 2020 оны 10-р сард Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас авсан хөрвөх нөхцөлтэй зээлийг хувьцаанд хөрвүүлсэнтэй холбоотой.

2021.08.17

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бермае*





Мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 15. Мөнгөн гүйлгээний тайлан

канад доллар	2018.12.31	2019.12.31	2020.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Цэвэр алдагдал	(3,656,990)	(2,683,292)	(13,116,358)
Мөнгөн бус гүйлгээнүүд:			
Элэгдэл, хорогдол	20,904	32,248	54,632
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	1,186,004	703,061	1,211,657
Санхүүгийн орлого	(50,816)	(36,512)	(62,858)
Хүүгийн зардал	-	162,051	1,653,178
Мөнгөн бус гадаад валют	(8,259)	26,332	(232,536)
Хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт	-	(178,972)	8,508,076
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	74,124	392,315	(172,509)
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,435,033)</b>	<b>(1,582,769)</b>	<b>(2,156,718)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн	5,007,375	5,309,865	18,934,376
Хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээгээр татан төвлөрүүлсэн цэвэр дүн	-	6,357,763	-
Опцион хэрэгжүүлсний төлбөр	254,725	169,800	344,300
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт	-	(7,604)	(25,698)
Хөрвөх нөхцөлтэй зээлийн хүү	-	-	(608,302)
Варрант хэрэгжүүлсний төлбөр	-	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>5,262,100</b>	<b>11,829,824</b>	<b>18,644,676</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	(4,363,017)	(6,804,128)	(8,873,361)
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн зардал	(16,077)	(10,653)	(175,630)
Хүүгийн орлого	50,816	36,512	62,858
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,328,278)</b>	<b>(6,778,269)</b>	<b>(8,986,133)</b>
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	24,258	(110,172)	192,040
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	(1,476,953)	3,358,614	7,693,865
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	3,225,202	1,748,249	5,106,863
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст</b>	<b>1,748,249</b>	<b>5,106,863</b>	<b>12,800,728</b>

2021.09.22

Гарын үсэг



Өмчийн өөрчлөлтийн тайлан

*Берин*

Хүснэгт 16. Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
<b>2018.01.01-ний үлдэгдэл</b>	<b>145,963,086</b>	<b>99,890,270</b>	<b>13,775,386</b>	<b>(894,855)</b>	<b>(98,016,525)</b>	<b>14,754,276</b>
Тайлант хугацааны нийт алдагдал:						
Цэвэр алдагдал	-	-	-	-	(3,656,990)	(3,656,990)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	-	(60,858)	-	(60,858)
Хаалттай хүрээнд гарсан хувьцааны цэвэр зардал	14,834,580	3,706,199	1,301,176	-	-	5,007,375
Хэрэгжүүлсэн опцион	1,628,750	407,175	(152,450)	-	-	254,725
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	1,186,004	-	-	1,186,004
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ	16,463,330	4,113,374	2,334,730	-	-	6,448,104
<b>2018.12.31-ний үлдэгдэл</b>	<b>162,426,416</b>	<b>104,003,644</b>	<b>16,110,116</b>	<b>(955,713)</b>	<b>(101,673,515)</b>	<b>17,484,532</b>
<b>2019.01.01-ний үлдэгдэл</b>	<b>162,426,416</b>	<b>104,003,644</b>	<b>16,110,116</b>	<b>(955,713)</b>	<b>(101,673,515)</b>	<b>17,484,532</b>
Тайлант хугацааны нийт алдагдал:						
Цэвэр алдагдал	-	-	-	-	(2,683,292)	(2,683,292)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	-	(1,002,903)	-	(1,002,903)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	25,922,044	4,895,464	414,401	-	-	5,309,865
Хэрэгжүүлсэн опцион	1,105,000	276,900	(107,100)	-	-	169,800
Олгосон ирээдүйд олгогдох хувьцааны эрх	1,615,030	290,557	(290,557)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	703,060	-	-	703,060
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ	28,642,074	5,462,921	719,804	-	-	6,182,725
<b>2019.12.31-ний үлдэгдэл</b>	<b>191,068,490</b>	<b>109,466,565</b>	<b>16,829,920</b>	<b>(1,958,616)</b>	<b>(104,356,807)</b>	<b>19,981,062</b>
<b>2020.01.01-ний үлдэгдэл</b>	<b>191,068,490</b>	<b>109,466,565</b>	<b>16,829,920</b>	<b>(1,958,616)</b>	<b>(104,356,807)</b>	<b>19,981,062</b>
Тайлант хугацааны нийт алдагдал:						
Цэвэр алдагдал	-	-	-	-	(13,116,358)	(13,116,358)

111529447 # 20200102

MONGOLIAN STOCK EXCHANGE  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
0000067  
2021-03-03  
БҮРТГЭЭ-03

20210807

2021.09.22 өдөр  
БҮРТГЭВ


0000068  
2021-09-03  
БҮРТГЭВ-03

Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	(1,006,050)	-	-	(1,006,050)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	44,444,441	-	10,727,732	8,206,644	-
Хөрвүүлэх боломжит зээлийн хүрээнд гаргасан энгийн хувьцаа	30,043,290	-	15,768,935	-	-
ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан энгийн хувьцаа	2,175,000	-	521,890	(177,590)	344,300
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	719,212	-	132,964	(132,964)	-
<b>Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ</b>	<b>77,381,943</b>	<b>-</b>	<b>27,151,521</b>	<b>9,107,747</b>	<b>36,259,268</b>

*Бернис*

УЛААНБААТАР У.  
МХБ-ийн нэгдүг  
Андеррайтер  
ОХСР-д ажилла  
"БИЛС" А  
ҮНХ АБ  
11152/4447 ш. 105201

2021.09.22



### 1.7.2. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн орчуулга

KPMG нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2019, 2020 оны 12 сарын 31-ны байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байр суурь, нэгдсэн дэлгэрэнгүй алдагдлын тайлан, тухай жилд дууссан өмчийн болон мөнгөн урсгалын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлого болон бусад тайлбарт мэдээллийн хураангуй бүхий тайлбараас бүрдсэн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийсэн байна.

KPMG нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2019, 2020 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн байр суурийг санхүүгийн нэгдсэн тайлангуудад бүхий л баримт бичгийн хувьд, мөн санхүүгийн нэгдсэн гүйцэтгэл, мөнгөний урсгал нь тухайн төгссөн жилүүдэд Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудын дагуу үнэн зөв танилцуулсан байна гэж үзжээ.

2020 оны 03 сарын 11-нд Ковид 19 тархалтыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас цар тахал хэмээн зарласан. Энэхүү цар тахлын дэгдэлтийг хязгаарлах оролдлогууд нь түүхий эдийн болон олон улсын хөрөнгийн зах зээлд томоохон нөлөө үзүүлсэн. Компани нь Ковид 19-ийн хүрээнд алсын зайнаас ажиллах, томилолтын хязгаарлалт, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хүрээнд журмуудыг батлан ажилласан. Энэхүү ажлуудын үр дүнд цар тахал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд томоохон нөлөөлөл үзүүлээгүй. Ажлын байрны аюулгүй байдлыг хангах талаар идэвх санаачилгатай ажиллаж байгаа боловч ирээдүйд Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой. Компани нь 2020 оны 12 сарын 31-ний байдлаар \$12,492,342-ын эргэлтийн хөрөнгөтэй байсан нь энэхүү тодорхойгүй нөхцөл байдлыг даван туулахуйц хөрвөх чадвартай хэмээн үзжээ.

2021.08.27

Бермае





## ХОЁР. НЭМЖ ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААС

### 2.1. Нэмж гарган санал болгож буй үнэт цаас

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд санал болгон нэмж үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг 2021 оны 08 сарын 24-ний өдөр гаргасан.

Уг шийдвэрт компанийн үнэт цаас гаргахтай холбоотой дараах асуудлыг тусгасан:

1. Үнэт цаасны танилцуулгад заасан нөхцөлөөр энгийн хувьцаа гаргахыг үүгээр баталж, энгийн хувьцааг дурдсан зорилгоор нөөцөлж, хуваарилсугай.
2. Компанийн эрх ашгийн үүднээс, Компанийн захирлууд нь гаргахаар Санал болгож буй хувьцаа бүрийн үнийг Компани зөвшилцсөний үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгыг СЗХ-нд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлсэний дараа, СЗХ-ны зөвшөөрөл гарахаас өмнө Компани болон Андеррайтер өдрийг тодорхойлж, МХБ-д арилжиж буй Энгийн хувьцааны арван өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10%-ийг хорогдуулсан дүнгээр ("Санал болгох үнэ"), ТХБ-ээс авах зөвшөөрлийн хүрээнд үүгээр баталж, энэхүү үнийн дүнг тодорхойлж тогтоох эрхийг Компанийн аливаа албан тушаалтан буюу захиралд (тус бүрийг "Эрх бүхий албан тушаалтан") олгосугай.
3. Компани нь Үнэт цаас гаргах хүрээнд Санал болгож буй хувьцааны Санал болгох үнийг хүлээн авсны дараа ийнхүү Санал болгож буй хувьцааг үнийг нь тогтоосон бөгөөд үнэ нь бүрэн төлөгдсөн Энгийн хувьцаа болгон гаргахыг үүгээр зөвшөөрч, Энгийн хувьцааны шилжүүлгийн агент бөгөөд бүртгэгч Компьютершэйр Инвестор Сервисэс Инк. компанид ("Computershare Investor Services Inc", "Компьютершэйр") Корпорацийн зүгээс цаашид аливаа арга хэмжээ авах шаардлагагүйгээр Санал болгож буй хувьцааг илэрхийлэх баталгаа буюу бусад нотлох баримтад хоёр дахь гарын үсэг зурах, бүртгэх, олгох болон хүргүүлэх эрхийг үүгээр олгосугай.
4. Энгийн хувьцааны шилжүүлгийн агент бөгөөд бүртгэгч Компьютершэйр нь Корпораци Санал болгож буй хувьцааг гаргах, хуваарилахтай холбоотой төлбөрийг бүрэн хүлээн авсан талаарх Корпорацийн албан тушаалтан гарын үсэг зурсан баталгаанд найдаж болохыг дурдсугай.
5. Аливаа Эрх бүхий албан тушаалтанд, Монгол улсын үйлчлэх хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо, МХБ, Монгол Улсын аливаа бусад зохицуулах байгууллагад ("Монголын эрх бүхий байгууллагууд") бүхий л өргөдөл, хүсэлт гаргах, Үнэт цаасны танилцуулга болон Үнэт цаас гаргахтай холбоотой бүх баримт бичгийг гаргах өгөх зэргээр Үнэт цаас гаргахтай холбогдуулан бүхий л шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрх олгож, үүрэг болгосугай.
6. Үнэт цаас гаргахтай холбогдуулан МХБ-д бүхий л шаардлагатай өргөдөл, хүсэлт гаргах эрхийг, үүргийг Компанид олгож, МХБ-д гаргаж өгөх шаардлагатай бүх баримт бичгийг гаргаж өгөх эрхийг Компанийн аль нэг захирал, албан тушаалтан, хуулийн зөвлөх эсхүл аливаа бусад итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосугай.

2021.08.27



- Компанийн бүрэн өмчилдөг охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-д, Монголын эрх бүхий байгууллагуудад Үнэт цаас гаргахтай холбогдуулан Компанийн өргөдлийг өгөх, Монголын эрх бүхий байгууллагуудаас мэдэгдэл хүлээн авах, Монголын эрх бүхий байгууллагууд болон Монгол Улсад оршин суугаа Корпорацийн хувьцаа эзэмшигчидтэй харилцахдаа аливаа Эрх бүхий албан тушаалтны зааварчилгаар Компанийг төлөөлөх эрх олгосугай.
- Үнэт цаас гаргах, Санал болгож буй хувьцааг ТХБ-д бүртгүүлэх болон энгийн хувьцааг МХБ-д бүртгүүлэхтэй холбогдуулан ТХБ-д бүхий л шаардлагатай өргөдөл, хүсэлт, баримт бичиг гаргаж өгөх эрхийг, үүргийг Компани олгож, ТХБ-д гаргаж өгөх шаардлагатай бүх баримт бичгийг гаргаж өгөх эрхийг Компанийн аль нэг захирал, албан тушаалтан эсхүл хуулийн зөвлөхөд олгож, баталгаажуулж, зөвшөөрсүгэй.

Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Зах зээлд арилжигдаж буй энгийн хувьцааны тоо ширхэг	274,404,183 (2021.07.31-ний байдлаар)
Арилжигдаж буй бирж	<ul style="list-style-type: none"> <li>Монголын хөрөнгийн бирж (МХБ) MSE:ERDN</li> <li>Торонтогийн хөрөнгийн бирж (ТХБ) TSX: ERD</li> </ul>
Санал болгож буй хувьцааны үнэ	<p>Үнэт цаас гаргагч нь Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг <b>үнэ тогтох өдрөөр</b> тасалбар болгон Монголын хөрөнгийн бирж дэх өмнөх 10 өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10 хувийн хөнгөлөлттэй үнээр тогтооно.</p> <p>ТХБ/МХБ дээрх хувьцааны ханшийн хэлбэлзлээс хамаарч дээрх нөхцөл хангагдах боломжгүй болсон тохиолдолд СЗХ-ны шийдвэр гарахаас 3-с доошгүй өдрийн өмнө үнийг шинэчлэн тогтооно.</p>
МХБ-ийн ангилал	2-р ангилал
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгө	14,250,000,000 төгрөг буюу 5 сая ам.доллартай дүйцэх санхүүжилт
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Баян Хөндий төслийн бүтээн байгуулалт, хайгуул, ерөнхий удирдлагын зардал.
Анхдагч зах зээлд санал болгох хэлбэр	Нийтэд санал болгож буй хувьцааг тогтоосон үнийн аргаар 75 хүртэл хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх хувийг нийтэд хуваарилан анхдагч зах зээлд санал болгоно.

Компанийн нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэг, нийтэд санал болгох хувь нь нийтэд санал болгох хувьцааны үнэ, тухайн үеийн зах зээлд арилжигдаж буй энгийн хувьцааны ханшаас хамааран тодорхойлогдоно.

Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн дэлгэрэнгүйг Хавсралт №26-өөс үзнэ үү.

*Бериее*

МХБ-ийн гишүүн  
 Анхдагч зах зээл  
 Бүртгүүлэгч  
 Б.Сүхбаатар  
 ХХК



2.1.1. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Энгийн хувьцааны санал болгох үнийг тодорхойлоход зах зээлийн нөхцөл байдлаас гадна Компанийн хувьцааны үнийн түүхэн гүйцэтгэл, үйл ажиллагааны хэтийн төлөвийн тооцоолол, удирдлагын үнэлгээ зэрэг хүчин зүйлсийг харгалзан үздэг. Компани нь Монголын хөрөнгийн бирж, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгүүлэн хувьцаагаа нээлттэй арилжаалж хувьцааны үнэ зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тогтож байгаа тул нэмж гарган санал болгох хувьцааны үнийг МХБ, ТХБ-д бүртгэгдсэн хувьцааны зах зээлийн үнэлгээнд тулгуурлан үнэлэх нь зүйтэй гэж үзсэн.

Мөн компани Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гарган хөрөнгө татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа тул нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг Монголын хөрөнгийн бирж дэх сүүлийн 10 өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10 хувийн хөнгөлөлттэй үнээр тогтоохоор шийдвэрлэсэн. Торонтогийн хөрөнгийн бирж/Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцааны ханшийн хэлбэлзлээс хамаарч дээрх нөхцөл хангагдах боломжгүй болсон тохиолдолд СЗХ-ны шийдвэр гарахаас 3-с доошгүй өдрийн өмнө үнийг шинэчлэн тогтооно.

Нэмж үнэт цаас гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан даруйд Компанийн хуулийн зөвлөх McInnes Cooper LLP нь Торонтогийн хөрөнгийн биржид мэдэгдэн зөвшөөрөл авсан.

*МХБ-д нэмж үнэт цаас гаргаж буй талаар ТХБ-д мэдэгдсэн мэдэгдэл болон орчуулгыг Хавсралт №16-аас үзнэ үү.*

Нөгөө талаас компани нь давхар бүртгэлийн хүрээнд санал болгож буй үнэт цаасны үнийг урьдчилж тогтооход МХБ, ТХБ дэх хувьцааны ханш өөрчлөгдсөнөөр тогтоосон үнэд нөлөөлөх нөхцөл үүсэж болзошгүй тул компани нь энэхүү танилцуулгын хүрээнд нэмж гарган санал болгох хувьцааны үнийг дээрх байдлаар тогтоохоор шийдвэрлэв.

Хүснэгт 17. Биржүүд дээрх ханшийн үзүүлэлт

	Торонтогийн хөрөнгийн бирж	Монголын хөрөнгийн бирж
Хувьцааны ханш	0.37	885
Зах зээлийн үнэлгээ	110,105,678	247,992,260,745
P/B	2.04	1.55
P/E	-6.09	-4.62
EPS	-0.07	-185.87

2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар

2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар компанийн зах зээлийн үнэлгээ Торонтогийн хөрөнгийн бирж дээр 110.1 сая кан.доллар, Монголын хөрөнгийн бирж дээр 247.9 тэрбум төгрөг байна.

168012027

Бермее





## 2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

Компанийн дүрэм болон Канадын компанийн болон үнэт цаасны хуулийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулах эрхтэй холбоотой эрх үүргүүд МХБ болон ТХБ-д хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдэд харилцан тэгш эрхтэйгээр хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчид нь тухайн хэлэлцэж буй асуудлын хүрээнд нэг хувьцаа нэг санал буюу гар өргөн санал өгөх зарчмаар явагдана.

Канадын Үнэт Цаасны Хуулийн дагуу Компанид материаллаг өөрчлөлт гарах тухайд Канадын Үнэт Цаасны Захиргаанд мэдэгдэх үүрэгтэй. Мэдээлэл нь нууцын чанартай, эсвэл хувийн гэж үзсэнээс бусад тохиолдолд нийтэд нээлттэй буюу SEDAR, [www.sedar.com-ооc](http://www.sedar.com-ооc) авч, танилцах боломжтой. Материаллаг өөрчлөлтөд орох мэдээлэлд: материаллаг гэрээ хэлцлүүд, техникийн судалгаа, тайлангууд, хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын үр дүн болон тайлангууд, санхүүгийн тайлангууд болон ТУЗ, удирдах албан тушаалтнуудын цалин урамшууллын мэдээлэл болон Монгол Улсын холбогдох засаг захиргааны байгууллагад тайлагнасан тайлангууд багтана. ТХБ-ийн шаардлагын дагуу компанид материаллаг өөрчлөлт гарсан даруйд Компани олон нийтэд мэдээллэх үүрэгтэй. Энэхүү мэдээллийг Компанийн вэб хуудас болон SEDAR, [www.sedar.com-ооc](http://www.sedar.com-ооc) авч танилцах боломжтой.

Дээрх дурдсан материаллаг өөрчлөлт орох бүрт Компани нь ТХБ болон Канадын Үнэт Цаасны Захиргаанд мэдээллэхээс гадна МХБ-д Монгол хэл дээрх орчуулга эсвэл Монгол хэл дээрх товч танилцуулгын хамт зэрэг хүргэнэ. Хэрэв энэхүү мэдээлэл нь МХБ-д ажлын бус цагаар хүргэгдсэн тохиолдолд дараагийн ажлын өдөр олон нийтэд ил тод болно. Мэдээллүүдийг [www.mse.mn](http://www.mse.mn), [www.sedar.com](http://www.sedar.com) болон Компанийн вэб хуудасаас танилцах боломжтой.

2021.09.03

Бүрмисе





**2.2.1. Канад улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалт**

#	Монгол Улс	Канад Улс	Эрсдэл / Арга хэмжээ
<b>Үнэт цаас гаргах этгээд<sup>1</sup></b>			
	Засгийн газар эсвэл компаниуд үнэт цаас гаргана.	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
	Компаниуд үнэт цаас гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.	Зөрчилдөөнгүй. Компаниуд үйлчилж буй компанийн тухай хууль тогтоомж, мужийн болон нутаг дэвсгэрийн үнэт цаасны тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.	
<b>Үнэт цаас гаргах<sup>2</sup></b>			
	Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, эсвэл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гаргаж болно.	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
	Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Монгол Улсын нутаг дэвсгэрт СЗХ-оос тогтоосон журмын дагуу бүртгэж болно.	Аливаа үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг (гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй буюу бусад эсэхийг үл харгалзан) мужийн болон нутаг дэвсгэрийн үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Канад дахь үнэт цаасны танилцуулгадаа тодорхойлсончлон бүртгэдэг болно.	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <b>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</b> аль аль улсуудын хууль тогтоомжид үнэт цаасыг гаргахаас өмнө нарийвчлан шалгах зохицуулалтын систем үйлчилдэг.
<b>Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг<sup>3</sup></b>			

2021.09.03

<sup>1</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 7 дугаар зүйл.  
<sup>2</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 6 дугаар зүйл.  
<sup>3</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 20 дугаар зүйл.

*Берие*





<p>Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй: Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;</p>	<p>Зөрчилдөөнгүй. Компанийн тухай хуулиар захирлууд үнэт цаас гаргах тухай шийдвэр гаргахыг шаарддаг.</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд СЗХ-нд хүргэх, нийтэд мэдээлэх;</p>	<p>Процедурын зохицуулалт бөгөөд Канад улсын хууль тогтоомжид байхгүй.</p>	<p><b>Процедурин ялгаатай байдал:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны тухай хууль болон хөрөнгийн биржийн журмаар хараат бус гишүүний доод хэмжээг тогтоосон байдаг.</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Тохиромжтой этгээдийг<sup>4</sup> эрх бүхий албан тушаалтнаар<sup>5</sup> томилох буюу сонгох;</p>	<p>Канад улсын хууль тогтоожид зохицуулалт байхгүй. Захирлуудаас тухай бүр үүрэг болгосны дагуу албан тушаалтнууд, захирлууд болон бусад этгээдүүдэд компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөх эрх олгох боломжтой.</p>	<p>Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <b>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</b> аль аль улсуудын хууль тогтоомжид (i) компанийг төлөөлөх эрх бүхий эдгээдийн төлөөлөл хэрэгжүүлэхдээ баримтлах стандарт, үүргийг тогтоосон байдаг; (ii) 'тохиромжтой этгээдийг' тодорхойлсон нь</p>

108070807

<sup>4</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 68.1.Хороо дор дурдсан шалгуурыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж тооцно:


68.1.1.тухайн үйл ажиллагаа, албан тушаалыг мэргэжлийн түвшинд шударгаар эрхлэх чадвартай байх;

68.1.2.хувь хүн бол мэргэжил, мэргэшил, туршлага, эрхэлж байсан ажил, албан тушаал, түүнтэй холбоотой хариуцлага хүлээж байсан эсэх, санхүүгийн болон ёс зүйн байдал нь уг албан тушаал эрхлэхэд тохиромжтой;

68.1.3.Хорооноос тогтоосон бусад нэмэлт шалгуур.

<sup>5</sup> Компанийн тухай хууль, 84.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Бсерие



2021 09 22 өдөр  
ЭРДНЭ-РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН

МОНГОЛЫН КОМПАНИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
0000076  
2021-09-03  
БҮРТГЭЛЭГ-03

ЭРДНЭ-РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

		зарчмын хувьд зөрчилдөөнгүй байна.
Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;	Зөрчилдөж байна. ТХБ-д бүртгэлтэй Канадын үнэт цаас гаргагчийг нууцад хамаарахаас бусад чухал мэдээллээ мэдээлэхийг шаарддаг.	<b>Зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</b> аль аль улсуудын хууль тогтоомжид төслийн хэрэгжилтэд онцгой ач холбогдол бүхий өөрчлөлт бий болсон тохиолдолд олон нийтэд мэдээлэх үүрэг болон тогтолцоог тогтоож өгсөн байна.
Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан болон аудитаар баталгаажуулаагүй улирлын жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд СЗХ болох Хөрөнгийн биржид хүргүүлэх;	Зөрчилдөж байна. Канадын үнэт цаас гаргагчийг, үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитаар баталгаажуулаагүй улирлын санхүүгийн тайланг үнэт цаасны зохицуулах байгууллагуудад хүргүүлэхийг шаарддаг.	<b>Зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</b> аль аль улсын хууль тогтоомжид аудитаар баталгаажуулаагүй тогтмол хугацааны санхүүгийн тайлан, тэнцэл мөн аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн тайлан тэнцлийг тодорхойлсон хугацаанд албан ёсоор үнэт цаасны зохицуулах байгууллагагд хүргүүлэх шаардлага, тогтолцоог тогтоон өгсөн байна.
Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх;	Зөрчилдөөнгүй. Санхүүгийн тайланг SEDAR ( <a href="http://www.sedar.com">www.sedar.com</a> ) цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх ёстой.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор СЗХ болон Хөрөнгийн биржид хүргүүлэх;	Зөрчилдөж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүнг SEDAR-аар дамжуулан нийтэд мэдээлэхийг шаарддаг. Дараагийн	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <b>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</b> аль аль улсын хувьд нийтэд мэдээлэх шаардлага, Дараагийн

128 012 000

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бернесс*

АТАР ХО  
МХБ-ийн гишүүн  
Андеррайтер  
Брокер, дилерийн  
"БИДИС" УЦК ХН  
1115205447-205241

	жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг танилцуулдаг.	тогтолцоог тогтоож өгсөн байна.
Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;	Зөрчилдөөнгүй. ТХБ-д бүртгэлтэй Канадын үнэт цаас гаргагчийн нууцад хамаарахаас бусад чухал мэдээллийг мэдээлэхийг шаарддаг.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
СЗХ-оос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх.	Зөрчилдөөнгүй. Канадын үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь үнэт цаас гаргагчдыг холбогдох компанийн засаглалын журам болон компанийн засаглалын асуудлаарх нээлттэй, зөвлөх удирдамж, зааврыг дагаж мөрдөхийг шаарддаг.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
<b>Нэмж хувьцаа гаргах шийдвэрийг гаргах этгээд<sup>6</sup></b>		
Зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа нэмж гаргах тухай шийдвэр гаргах бүрэн эрхтэй. <sup>7</sup>	Зөрчилдөж байна. Хувьцаа гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргадаг. <sup>8</sup> Гэсэн хэдий ч, хувьцаа гаргах өргөдлийг батлахаас өмнө ТХБ нь үнэт цаас эзэмшигчийн гаргасан зөвшөөрлийг баталгаажуулсан баримт бичгийг шаардаж болох ба зохих ёсоор хуралдсан саналын эрхтэй үнэт цаас эзэмшигчдийн	<b>Зөрчилдөж байна:</b> Нэмж хувьцаа гаргахын тулд хувьцаа эзэмшигчийн зөвшөөрлийг харуулсан баримт бичгийг ТХБ нь шаардах эрхтэй боловч бүх тохиолдолд шаардах эрхтэй гэсэн ойлголт биш юм. Иймд, хувьцааг зөвхөн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр гаргаж болно.

20210827

<sup>6</sup> МХБ-ийн Бүртгэлийн Журмын (2018) 16.7.2-т заасны дагуу нэмж хувьцаа бүртгүүлэх өргөдөлд бүртгүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэр.

<sup>7</sup> Компанийн тухай хууль (2011), 62.1.3-р зүйл.

<sup>8</sup> Канадын Бизнесийн Корпорацийн тухай хууль, 25 -р хэсэг.

*Бериее*

УЛААНБААТАР Х.У.  
Аидеррайтер  
Брокер, Английн  
"БИДСЕК"  
УИХ-ЫН  
111520447



ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

		<p>олонхоос эсхүл ТХБ зөвшөөрсөн тохиолдолд санал болгож буй хэлцлийн нөхцөлтэй танилцсан үнэт цаасны үнэт цаасны 50-иас дээш хувийг эзэмшигчдийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр энэхүү зөвшөөрлийг авах ёстой.<sup>9</sup></p>	
<p><b>Мэдээллийг ил тод болгох<sup>10</sup></b></p>			
	<p>Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь дор дурдсан мэдээллийг сонирхсон этгээдэд өгөх үүрэгтэй:          Үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл;          Үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд заасан үнэт цаас гаргах, үнэт цаасыг арилжих журам;          Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан; мөн          СЗХ, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээлэл.</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны танилцуулгыг SEDAR цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байлгадаг.</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b>          Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
	<p>СЗХ доорх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй<sup>11</sup>:          Бүртгэсэн үнэт цаас болон түүний танилцуулга;</p>	<p>Зохицуулалт байхгүй. Үнэт цаас гаргагчид нь үнэт цаасны танилцуулгаа мэдээлэх асуудлыг өөрсдөө хариуцдаг.</p>	<p><b>Процедурын ялгаатай байдал:</b>          Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
	<p>Үнэт цаас гаргагчийн СЗХ-д ирүүлсэн тайлбар, тайлан, дүгнэлт;</p>	<p>Зохицуулалт байхгүй.</p>	<p><b>Процедурын ялгаатай байдал:</b>          Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
	<p>Зохицуулалттай этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлд бүртгэхтэй холбоотой шийдвэр, түүний үндэслэл;</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь гаргасан тушаал,</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b>          Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд</p>

210827

<sup>9</sup> ТХБ-ийн Компанийн Журам, IV-р бүлэг, Бүртгэгдсэн Үнэт Цаас Гаргагчдын Капиталын Бүтцийн өөрчлөлт, 604-р хэсэг.

<sup>10</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 55 дугаар зүйл.

<sup>11</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 59-р зүйл.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бсерин*





	шийдвэрийнхээ талаар нийтэд мэдэгддэг бөгөөд бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүмүүс болон бүртгүүлэхэд хамаарах нөхцлийн талаар нийтэд мэдэгддэг.	аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
СЗХ-ны үйл ажиллагааны жилийн тайлан;	Зохицуулалт байхгүй.	<b>Канад улсын хууль тогтоомжид хамаагүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
СЗХ-оос тогтоосон бусад нэмэлт мэдээлэл.	Зохицуулалт байхгүй.	<b>Канад улсын хууль тогтоомжид хамаагүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.

**Үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээлэл шаардах, нэхэмжлэл гаргах<sup>12</sup>**

<p>Дараах нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсч болзошгүй гэж үзвэл СЗХ үнэт цаас гаргагч болон түүний холбогдох этгээдээс доорх мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй:</p> <p>Бусдыг хууран мэхлэх, залилах, завших зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон;</p> <p>Хууран мэхлэх, залилах, завших болон бусад хууль бус зорилгоор компанийг үүсгэн байгуулсан;</p> <p>Компанийн үүсгэн байгуулагч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон бусад эрх бүхий албан тушаалтан нь тухайн компани, түүний хөрөнгө оруулагчийг хууран мэхлэх, залилах,</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь Өөрсдийн харьяалал дахь үнэт цаас гаргагчдаас мэдээлэл шаардаж болно.</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
--	---	---

1280420877

<sup>12</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 21-р зүйл.

*Бернесс*





завших болон бусад хууль бус ажиллагаа явуулсан; Хөрөнгө оруулагчид болон олон нийтэд ил болгох шаардлагыг биелүүлээгүй.		
<b>Үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа<sup>13</sup></b>		
Үнэт цаасны зах зээлд дараах үйл ажиллагааг хориглоно: Уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох;	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгох, ятгах;	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах;	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх болон бусад арга хэлбэрээр үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах.	Зөрчилдөөнгүй.	<b>Зөрчилдөөнгүй:</b> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй.
<b>Хувьцаа худалдан авах үнийн санал гаргах буюу компани нэгдэх, нийлэх, худалдан авах хэлцлийг хувьцаа эзэмшигч батлах</b>		

2021.09.03

<sup>13</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 76-81-р зүйл.

Берисе





<p>Монгол улсын хуулиар хувьцаа эзэмшигчид өөрсдийн хувьцаагаа захиран зарцуулах буюу хувьцаа худалдан авах үнийн саналыг зөвшөөрөх эсэхээ шийдвэрлэх эрхтэй.</p> <p>Түүнчлэн Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд жижиг хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа заавал худалдахыг ногдуулсан зохицуулалт байхгүй.</p>	<p>Зөрчилдөж байна.</p> <p>Хувьцаа худалдан авах үнийн санал гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигчид тухайн саналыг зөвшөөрч өөрсдийн саналыг худалдах эсэхээ өөрсдөө шийддэг.</p> <p>Гэхдээ зарласан хувьцааны 90% буюу түүнээс дээш хувийг худалдан авах бол худалдан авч буй этгээд нь жижиг хувьцаа эзэмшигчдийг шахаж, үлдсэн хувьцааг худалдахыг албадаж болно. Компани нэгдэх, нийлэх, худалдан авах зарим томоохон хэлцлийг санал хураасан хувьцааны гуравны хоёрын баталснаар байгуулж болдог ба холбогдох этгээдийн хэлцэл хийх тохиолдол жижиг хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авдаг байна.</p>	<p><b>Анхаарвал зохих зөрчилдөөн:</b></p> <p>Канад улсын хуулиар томоохон хувьцаа эзэмшигчдэд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг албан худалдах эрхийг олгосон байдаг бол Монгол улсын хуулиар жижиг хувьцаа эзэмшигчдийг ийнхүү албадах боломжгүй юм.</p> <p>Хэдийгээр энэ нь эдгээр хоёр орны эрх зүйн тогтолцооны хувьд анхаарууштай ялгаа боловч Монгол улсын давхар бүртгэлийн журамд 'гадаад улсын арилцаа эрхлэх бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасаа анх бүртгүүлсэн, хуулийн этгээдийг харьяалах улс болон монгол улсын хууль тогтоомжийн зөрүүтэй байдал үүссэн тохолдолд гадаад улсын үнэт цаасны зах зээлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө'<sup>14</sup> хэмээн заасан байдгийг энд тэмдэглэе.</p> <p>Тиймээс, энэ тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдийг албадан хувьцаагаа</p>
---	--	---

2021.09.27

<sup>14</sup> Давхар бүртгэлийн журам, 1.5-р зүйл, 2018. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Бернис





		<p>худалдахыг дэмжсэн Канадын хууль тогтоомж болон практик үйлчлэнэ.</p> <p>Хууль тогтоомжийн зохицуулалтын энэхүү зөрчилдөөнийг шийдвэрлэх хууль зүйн шийдэл байгаа хэдий ч одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид энэхүү зөрчилдөөнтэй байдал болон давуу эрхтэй үйлчлэх бүхий эрх зүйн зохицуулалтын талаар мэддэг байх нь чухал юм.</p>
--	--	---

**Эсрэг саналтай хувьцаа эзэмшигчийн эрх<sup>15</sup>**

	<p>Эсрэг саналтай хувьцаа эзэмшигч нь компанийн эргүүлэн худалдаж авсан хувьцааны зах зээлийн үнээр төлбөр авах эрхтэй.<sup>16</sup> Хувьцаа эзэмшигч нь компанийн бүтцийн өөрчлөлт, томоохон хэлцэл, компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл компанийн дүрэмд заасан бусад тохиолдлын талаар эсрэг саналтай байж болно.<sup>17</sup> Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авахаас татгалзсан, эсхүл өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахад компаниас санал болгож буй зах зээлийн үнийг бодитой бус гэж үзвэл эсрэг саналтай хувьцаа эзэмшигч нь энэ</p>	<p>Зөрчилдөөнгүй.</p> <p>Эсрэг саналтай хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа зах зээлийн бодит үнээр худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.<sup>19</sup> Хувьцаа эзэмшигч нь компанийн зарим зүйлд өөрчлөлт оруулах, компанийг өөр компанитай нэгтгэх, компанийг өөр эрх мэдэлд үргэлжлүүлэх, компанийн эд хөрөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдах, түрээслэх, солилцох тухай шийдвэрийг болон хуульд заасан бусад нөхцөл байдлын талаар эсрэг саналтай байж болно.<sup>20</sup> Корпораци эсвэл эсрэг саналтай хувьцаа эзэмшигч нь үнийн саналтай санал зөрөлдсөн эсвэл корпораци нь үнийн саналаа өгөөгүй тохиолдолд зах зээлийн</p>	<p><b>Зөрчилдөөнгүй:</b></p> <p>Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
--	---	---	--

2021.09.07

<sup>15</sup> МХБ-ийн Бүртгэлийн Журмын (2018), 16.7.5, 16.7.6-р зүйлд заасан өргөдөлд хавсаргах.  
<sup>16</sup> Компанийн тухай хууль (2011), 53.5-р зүйл.  
<sup>17</sup> Компанийн тухай хууль (2011), 53.1-р зүйл.

<sup>20</sup> Канадын Бизнесийн Корпорацийн тухай хууль, 190 (1) ба 190 (2)-р хэсэг.

*Бсерие*





талаарх гомдлоо шүүхэд гаргаж болно. <sup>18</sup>	бодит үнийг тогтоолгохоор шүүхэд хандаж болно. <sup>21</sup>
--	--

**Нэмж гаргах хувьцааны бүртгэл<sup>22</sup>**

Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн нэмж гаргах хувьцааг СЗХ-оос тогтоосон журмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгүүлж болно. <sup>23</sup>	Аливаа үнэт цаас гаргагчийн нэмж хувьцааг (гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлсэн эсэхээс үл хамааран) Канад улсын үнэт цаасны хөтөлбөрөөр тухайн муж, нутаг дэвсгэрийн үнэт цаасны холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж болно.	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <b>зарчмын хувьд зөрчилдөөнгүй</b> : аль улсуудын хууль тогтоомжид үнэт цаасыг гаргахаас өмнө нарийвчлан шалгах зохицуулалтын систем үйлчилдэг.
Нэмж хувьцаа бүртгүүлэх өргөдлийг МХБ-д хүргүүлэх ёстой бөгөөд МХБ нь дотоод дүрмийнхээ дагуу нийцлийн хяналт шалгалт хийсний дараа өргөдлийг зөвшөөрөх эсвэл хүлээн авахаас татгалзах эрхтэй. <sup>24</sup>	Зөрчилдөөнгүй. Нэмж хувьцаа бүртгүүлэх өргөдлийг ТХБ-д хүргүүлэх ёстой бөгөөд ТХБ нь дотоод журмын дагуу нийцлийн хяналт шалгалт хийсний дараа өргөдлийг зөвшөөрөх эсвэл хүлээн авахаас татгалзах эрхтэй. <sup>25</sup>	<b>Зөрчилдөөнгүй</b> : Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.

20210807

**Давуу эрхийн хувьцаа худалдаж авах эрх<sup>26</sup>**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын нэмж хувьцаа гаргах шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжид нэмж хувьцаа худалдаж авах эрхтэй болно. <sup>27</sup>	Зөрчилдөж байна. Канад улсын хууль тогтоомжид зохицуулалт байхгүй. Нэмж хувьцаа гаргаж буй компанийн хувьцаа эзэмшигчид хувьцаа худалдаж авах хуулиар олгогдсон давуу эрх байхгүй. Гэсэн хэдий ч хувьцаа	<b>Зөрчилдөж байна</b> : Компанийн дүрэм, эсхүл давуу эрхийн хувьцаа гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хэлэлцээрт тусгаагүй бол Хувьцаа эзэмшигчид хувьцаа
---	--	--

<sup>18</sup> Компанийн тухай хууль (2011), 54.7-р зүйл.  
<sup>20</sup> Канадын Бизнесийн Корпорацийн тухай хууль, 190 (3)-р хэсэг.  
<sup>21</sup> Канадын Бизнесийн Корпорацийн тухай хууль, 190 (15) ба 190 (16)-р хэсэг.  
<sup>22</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 20-р зүйл.  
<sup>23</sup> Компанийн тухай хууль (2011), 42.4-р зүйл.  
<sup>24</sup> МХБ-ийн Бүртгэлийн Журмын (2018), 8-р зүйл.  
<sup>25</sup> ТХБ-ийн Компанийн Журам, 602 ба 615-р хэсэг.  
<sup>26</sup> МХБ-ийн Бүртгэлийн Журмын (2018), 16.7.7-р зүйлд заасан өргөдөлд хавсаргах.  
<sup>27</sup> Компанийн тухай хууль (2011), 34.2, 38-р зүйл.

*Берие*



2021.09.22 өдөр

MONGOL INVESTMENT BANK  
BICN0000084  
2021-09-03

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

	худалдаж авах давуу эрхийг компанийн дүрэм, эсхүл хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хэлэлцээрт тусгаж болно. <sup>28</sup>	тэргүүн ээлжид худалдаж авах давуу эрхээ шууд хэрэгжүүлэх боломжгүй.
--	---	--

Канад улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалтын талаар мэдээллийг Хавсралт №17-оос үзнэ үү.

20210827

<sup>28</sup> Канадын Бизнесийн Корпорацийн тухай хууль, 28-р хэсэг.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Всерен

МХБ-ийн гишүүн  
Андраагтер  
Брокер, дэлгэрэнгүй  
"БНДЭСТК" 84  
1102054000201452



### 2.3. Нэмж үнэт цаас гаргахтай холбоотой эрх, үүргийн тухай

#### 2.3.1. Шаардах эрх

Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд өөрөөр заагаагүй бол Канадын бизнесийн корпорацын тухай хуулийн 25 дугаар хэсгийн дагуу нэмж хувьцаа гаргах шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргадаг. ТХБ-ээс зарим шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр эсвэл саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшигчдийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр баталгаажуулахыг шаардаж болдог. Дээрх тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагагүй байна.

Канадын бизнесийн корпорацын тухай хуулийн 190 дүгээр хэсэгт хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээс эсрэг саналтай хувьцаа эзэмшигч нь Компаниас өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авах эрхтэй байх тохиолдлуудыг зааж өгсөн ба үүнд хувьцаа нэмж гаргах асуудал тусгагдаагүй тул нэмж хувьцаа гаргах асуудлаар шийдвэр гаргасан ч эсрэг саналтай хувьцаа эзэмшигч Компаниас хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхгүй.

#### 2.3.2. Тэргүүн ээлж

Нэмж хувьцаа гаргаж буй компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан шиг шууд хуулиар олгогдсон хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхгүй боловч Канадын Бизнесийн корпорацын хуулийн 28 дугаар хэсэгт компанийн дүрэмд зааж өгсөн тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцааг тэргүүн ээлжид худалдаж авах эрхийг хэрэгжүүлж болно гэж тусгайлан зохицуулсан байдаг.

Тодруулбал, Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь МХБ-д нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан хувьцааг эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхгүй. Мөн Компанийн дүрэмд нэмж гаргасан хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах талаар тусгайлан заагаагүй, хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх талаар ямар нэг зөвшөөрөл олгох шийдвэр гаргаагүй байна.

20210827

Бсерие






## 2.4. Үйл ажиллагааны төлөвлөгөө

### 2.4.1. Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэх болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий үнэт болон суурь металлын нөөцийг тэлэх хоёр үндсэн стратегийн зорилтын дагуу ажилладаг.

Схем 5. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө



20210827

*Бернис*





### 2.4.2. Баян Хөндий төслийн төлөвлөгөө

Компани нь өнгөрсөн жилүүдэд Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийг авч холбогдох ажиллагааг гүйцэтгэж ирсэн. Одоогоор Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөг гүйцэтгэн зөвшөөрөл авах, Байгаль орчны үнэлгээг батлуулах зэрэг чухал тусгай зөвшөөрлүүдийг авсны дараагаар бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Схем 6. Төслийн ерөнхий үйл ажиллагааны схем

- Гүйцэтгэсэн
- Хийгдэж буй, төлөвлөж буй

#### Ашиглалтын тусгай зөвшөөрөл

- Баян Хөндийн Техник, Эдийн Засгийн Үндэслэл ("Монгол ТЭЗҮ")-г 2019 оны 08 сарын 05-нд Ашигт Малтмал, Газрын Тосны Газар хүлээн авч Хөндий төслийн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан

#### Орон нутгийн хамтын ажиллагаа

- Баянхонгор аймгийн ЗДТГ-тай 4 жилийн турш хамтран ажиллах гэрээг баталгаажуулсан.
- Орон нутгийн иргэдэд зориулж ажлын байрны чиглэл олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

#### Усны нөөц батлуулах

- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам нь 2019 оны 12 сарын 30-ны өдрийн А/640 тоот тушаалаар Баян Хөндий Алтны Төслийн дэд бүтэц, баяжуулах үйлдвэрийн технологийн усны нөөц болон ундаргын түвшинг баталж, бүртгэсэн.

#### Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл

- 2020 оны 6 сард Эрдэнэ Ресурс нь хараат бус Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас тавигддаг Гүйцэтгэлийн Шаардлагын дагуу боловсруулсан.

#### Тогтворжуулах гэрчилгээ

- 9 жилийн турш Монгол Улсын өнөөгийн татварын хувь хэмжээ тогтвортой үйлчлэх боломжтой татварын тогтворжуулах гэрчилгээний өргөдөл нөхцөлтэйгээр батлагдсан.

#### Газар ашиглах зөвшөөрөл

- Төслийн ил уурхай болон холбогдох дэд бүтэцэд шаардлагатай 100 га талбайн газар ашиглах зөвшөөрлийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу орон нутаг баталсан.

#### БОНБНҮ, Олон нийтийн хэлэлцүүлэг

- Эко Трөйд ХХК Баян Хөндий төслийн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ ("БОНБНҮ", "DEIA")-г боловсруулж олон нийтийн хэлэлцүүлэг хийн саналыг тусгасан.
- Хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан БОНБНҮ-ийн тайланг Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд батлуулахаар хүргүүлнэ.

2021.09.03

Б.Сергеев





- Гүйцэтгэсэн
- Хийгдэж буй, төлөвлөж буй

### Бүтээн байгуулалтын бэлтгэл

Боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажлыг 2021 оны 1-р улиралд эцэслэсэн. Захиргааны байгууллагын дүгнэлт хүлээгдэж байна.

- Уурхайн туслах байгууламжууд болох оффис, ээлж солих байр, харуул хамгаалалтын байр, үйлдвэрийн цех, агуулах болон хотхоны зургийг боловсруулж дууссан, төслийн ерөнхий зохион байгуулалтын зөвшөөрлийг авахаар өргөдөл гаргасан.
- Үйлдвэрийн зарим тоног төхөөрөмжийг захиалсан.

### Голлох зөвшөөрлүүд

- Орон нутгийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан БОНБНУ ("DEIA")-г батлуулахаар Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд хүргүүлэн зөвшөөрөл авна.
- Боловсруулах үйлдвэрээс бусад таван үндсэн дэд бүтцийн холбогдох зөвшөөрлийг авсан.
- Холбогдох зураг төлөвлөгөөг гүйцэтгэн зөвшөөрөл авч, БОНБНУ-г батлуулсны дараагаар бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авахаар өргөдөл гаргана.

### Санхүүжилт

- Компани нь зээлийн санхүүжилт төвлөрүүлэх зорилгоор Төслийн Санхүүжилтийн Зөвлөх HCF компанитай хамтран ажиллаж байна.
- 2020 оны 11 сарын 4-нд Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай Баян Хөндий Алтны Төслийн хүрээнд \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичигт гарын үсэг зурсан. Нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэснээр эцэслэх нөхцөлтэй бөгөөд судалгаа нь төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

### Барилгын ажил

- Холбогдох техникийн зураг төлөвлөгөөг гүйцэтгэн зөвшөөрөл авах, БОНБНУ-г гүйцэтгэх зэрэг голлох ажлуудыг гүйцэтгэсний дараа бүтээн байгуулалтын ажлын зөвшөөрөл аван эхлүүлэхээр төлөвлөж байна.
- Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авснаар бүтээн байгуулалтын ажил эхэлнэ.
- Улсын комиссын зөвшөөрөл авах ажлыг төлөвлөсөн.



### Алтны үйлдвэрлэл эхлэх


- Компани 6 жилийн хугацаанд 381,668 унц алт олборлоно.
- Анхны алтыг 2023 онд үйлдвэрлэхээр төлөвлөсөн.



### Уурхайн төлөвлөлт

Баян Хөндий ордын бүтэц, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар олборлоно. Баян Хөндий ордод Страйкер, Баруун Страйкер, Мидфийлд, Хойд Мидфийлд, Зүүн хойд бүс гэсэн өндөр агуулга бүхий бүсүүдийг тодорхойлсон.

Зураг 14. Баян Хөндий ордын өндөр агуулга бүхий талбай



Ордыг ил аргаар олборлохдоо ордын өмнөд хэсгийн Страйкер бүсээс эхлэн хойш залгаа орших Мидфийлд болон Зүүн-Хойд Мидфийлд бүсүүдийг үргэлжлүүлэн хойд зүгт чиглэн олборлохоор төлөвлөсөн.

Ил уурхайн дэргэд боловсруулах үйлдвэр, хүдрийн овоолго, хаягдлын нэгдсэн байгууламж, дулааны цахилгаан станц болон бусад туслах дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэнэ.

Зураг 15. Баян Хөндий төслийн уурхайн төлөвлөлт



16801207

Баян Хөндий төслийн нарийвчилсан ТЭЗҮ-д Монголд зохих туршлагатай туслан гүйцэтгэгч компаниудаас ирүүлсэн саналд тусгагдсан аргачлал болон зардалд үндэслэн гэрээт олборлолт хийхээр төлөвлөсөн.

**Боловсруулах үйлдвэр**


Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баян Хөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,800 тонн хүдэр, жилд 600,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай.

Нарийвчилсан ТЭЗҮ-д хүдрийн материалыг боловсруулахдаа уламжлалт аргаар буюу бутлан, тээрэмдэж, баяжуулан, нүүрстэй уусгах технологиор (CIP эсхүл Carbon in pulp) алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. Энэхүү нүүрстэй уусгах технологи нь 1980-аад оны эхээр үйлдвэрлэлд нэвтэрсэн бөгөөд хүдэр боловсруулах энгийн боловч үр дүнтэй технологи юм.

Хүдрийн 80%-ийг 60 микронд хүртэл тээрэмдэж, баяжуулах мөчлөгт 36 цаг химийн урвалд оруулах нь алт авалтыг хамгийн өндөр түвшинд байлгахыг металлургийн оновчлолын судалгаагаар тодорхойлсон.

Боловсруулах мөчлөг нь усны нөхөн сэргээлтийг хамгийн өндөр түвшинд байлгах, усгүйжүүлэх үйл явцыг хамгийн үр дүнтэй буюу хаягдлын чийгшлийг 15%-д байлгах, химийн болон урвалжийн хэмжээг бууруулж, байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах аар төлөвлөгдсөн.

Зураг 16. Баян Хөндий уурхайн боловсруулах үйлдвэрийн үйл явцын зураглал



**БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ**  
**БАЯЖУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН**  
**ЗУРАГЛАЛ**

20210827

*Берние*

Аидеграгер  
 Брокер, доторин  
 "БЭД" АТН-ийн  
 11-205447-2052-12



**БАЯН ХӨНДИЙ ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ**

**Хөрөнгө оруулалт**

Баян Хөндий Алтны Төслийн ашиглалтын хугацааны нийт капиталжуулах зардлыг 63.8 сая ам.доллар хэмээн тооцсон. Үүнд анхны хөрөнгө оруулалт буюу бүтээн байгуулалтын зардал 59.2 сая ам.доллар байгаа бол тогтвортой хөрөнгө оруулалтад 4 сая ам.доллар, байгаль орчин болон уурхайн хаалтын зардалд 2.9 сая ам.доллар тусгасан ба уурхай харьцангуй богино хугацаанд үйл ажиллагаа явуулсан тул үлдэгдэл өртгийг 2 сая ам.доллараар тусгасан.

Хүснэгт 18. Капиталжуулах зардал

№	Бүтээн байгуулалт	Сая ам.доллар	Бүтээн байгуулалтын өмнөх бэлтгэл үе	Бүтээн байгуулалтын үе	Үйлдвэрлэлийн эхний жил
			7.7 сая ам доллар	49.7 сая ам доллар	1.8 сая ам доллар
1	Баяжуулах үйлдвэр	24.3	<ul style="list-style-type: none"> <li>- Бүтээн байгуулалтын бэлтгэл ажиллагаа</li> <li>- Газар шорооны ажил</li> <li>- Байр, орон сууц</li> <li>- Болзошгүй зардал</li> <li>- Ерөнхий зардал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт</li> <li>- Үйлдвэрээс бусад дэд бүтэц</li> <li>- Химийн болон тэслэгч бодисууд</li> <li>- Түлш шатахуун</li> <li>- Болзошгүй зардал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүтээн байгуулалттай холбоотой бусад ерөнхий зардал</li> <li>- Болзошгүй зардал</li> </ul>
2	Үйлдвэрээс бусад дэд бүтэц	9.8			
2.1	Газар шорооны ажил	3.1			
2.2	Усны хангамж	0.4			
2.3	Оффис, харуул хамгаалалт, агуулах,	4.5			
2.4	Сайтын үйлчилгээ, бусад орон байр	1.1			
2.5	Дулааны станц	0.7			
3	Байр, орон сууц	2.0			
4	Барилга байгууламжийн шууд бус зардал	6.0			
5	Инженерчлэл ба бусад	4.8			
	<b>Бүтээн байгуулалтын зардал</b>	<b>46.9</b>			
6	Олборлолтын өмнөх зардал	7.5			
7	Болзошгүй зардал	4.8			
	<b>Нийт бүтээн байгуулалтын зардал</b>	<b>59.2</b>			
8	Тогтвортой хөрөнгө оруулалт	3.7			
9	Байгаль орчин болон уурхайн хаалт	2.9			
10	Үлдэгдэл өртөг	(2.0)			
	<b>Нийт CAPEX</b>	<b>63.8</b>			

2021.08.27

Уурхайн байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг бүтээн байгуулалтын жилд 49.7 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын зардал нь 7.7 сая ам.доллар болохоор тооцоолсон. Үүнд бүтээн байгуулалтад бэлдэх, уурхайн хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон хөрс хуулалтын өмнөх зардал багтсан. Хөрөнгийн зардлын тооцоонд 10% болзошгүй зардлыг шингээсэн.

Тогтвортой хөрөнгө оруулалтын зардал болон уурхайн хаалтын зардлыг үйлдвэрлэл эхэлсэн эхний жилээс тогтмол дүнтэйгээр зарцуулахаар төлөвлөсөн. Төсөл нь капиталжуулах зардлыг үйлдвэрлэл эхэлснээс хойш 1.92 жилийн хугацаанд татварын дараах мөнгөн урсгалаар нөхөн төлөхөөр тооцоолсон.

*Баянхонгор*







### Алт үйлдвэрлэх өртөг


Уурхайн үйл ажиллагааны хугацаанд алт үйлдвэрлэхтэй холбоотой 279 сая ам.долларын зардал буюу нэг унц алтыг 733 ам.долларын зардлаар үйлдвэрлэхээр төлөвлөсөн. Нийт нэгжийн өртөг (AISC) нь US\$733/унц байгаа нь Баян Хөндий орд нь дэлхийн хэмжээний ил уурхайнуудтай харьцуулахад бага өртөгтэй ордуудын хэмжээнд тооцогдож байна. S&P Global-ын судалгаагаар 2020 онд дундаж AISC /All in Sustaining Cost/ нь 975 ам.доллар/ унц байна.

Хүснэгт 19. Ашиглалтын хугацаанд гарах алт үйлдвэрлэхтэй холбоотой нийт зардал

Алт үйлдвэрлэхтэй холбоотой хугацаанд гарах нийт зардал	төслийн	Нийт зардал /сая ам.дол/	Нэгжийн зардал Ам.дол/унц
Уурхайн үйл ажиллагааны зардал		133	350
Боловсруулалтын зардал		96	252
Ерөнхий ба захиргааны зардал		13	33
<b>Нийт үйл ажиллагааны зардал</b>		<b>242</b>	<b>635</b>
АМНАТ болон бусад хураамжууд		32	86
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт болон уурхайн хаалтын зардал		5	12
<b>Нийт зардал</b>		<b>279</b>	<b>733</b>

Нийт үйл ажиллагааны зардлын 48%-ийг уурхайн үйл ажиллагааны зардал, 34%-ийг боловсруулалтын зардал, 13%-ийг ерөнхий ба захиргааны зардал буюу нийт үйл ажиллагааны зардал 87%-ийг эзэлж байгаа ба АМНАТ болон уурхайн хаалттай холбоотой зардал 13%-ийг эзэлж байна.

График 6. Баян Хөндий төслийн алт олборлох өртгийн задаргаа




- Уурхайн үйл ажиллагааны зардал сая.дол
- Боловсруулалтын зардал сая.дол
- Ерөнхий ба захиргааны зардал сая.дол
- АМНАТ болон бусад хураамжууд сая.дол
- Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт болон уурхайн хаалтын зардал сая.дол

2020.09.08 27


*Б.Сүрэн*





### Уурхайн үйл ажиллагааны зардал

График 7. Уурхайн үйл ажиллагааны зардлын задаргаа



- Ашиглалтын геологи
- Шууд бус цалингийн зардал
- Бусад шууд бус зардал
- Гэрээт олборлогчид төлөх
- Ерөнхий удирдлагын зардал
- НӨАТ


Компани нь олборлолтын болон боловсруулалтын төлөвлөгөө дээр үндэслэн гэрээт олборлогчтой ажиллахаар төлөвлөсөн. Уурхайн үйл ажиллагааны зардлын дийлэнх хэсгийг гэрээт олборлогчдод төлөх төлбөр эзэлж байна.

Гэрээт олборлогчтой хамтран ажилласнаар тоног төхөөрөмж, шууд цалингийн зардал, өрөмдлөг, тэсэлгээ зэрэг томоохон зардлуудыг хэмнэх давуу талтай.

Ерөнхий удирдлагын зардлыг уурхайн зардал болон боловсруулах зардалд хуваарилсан ба үүнд ажилчдын цалин, тээвэр, байр орон сууц, түрээс, баяжуулах үйлдвэрээс бусад дэд бүтцийн зардал гэх мэт зардлууд багтаж байна.

### Боловсруулах зардал

График 8. Боловсруулах үйл ажиллагааны зардлын задаргаа



- Цахилгаан, дулааны зардал
- Урвалжийн зардал
- Ерөнхий удирдлагын зардал
- Цалингийн зардал
- Бусад зардал

Боловсруулах зардлын 39.3%-ийг үйлдвэрийн цахилгаан, дулааны зардал эзэлж байгаа бол 28.6%-ийг урвалж /reagent/-ийн зардал эзэлж байна. Хүдэр боловсруулах процесст урвалж нь ашигт металлыг бусад металл, хүдрээс салгах процессыг гүйцэтгэдэг.

Үйлдвэрийн шууд цалингийн зардал 8%-ийг, Ерөнхий удирдлагын зардал 13%-ийг эзэлж байна.

420270827

Басерма






### Төслийн мөнгөн урсгал

Компани Баян Хөндий уурхайд үйлдвэрлэл явуулж буй 6 жилийн хугацаанд нийт 381 мянган унц алт борлуулан дараах мөнгөн урсгалтай ажиллахаар төлөвлөжээ. Унц алтны үнийг 1,400 ам.доллараар борлуулахаар төлөвлөсөн. Алтны үнэ өсөхөд компанийн эдийн засгийн үзүүлэлт өсөх боломжтой.

График 9. Төслийн мөнгөн урсгал



### Эдийн засгийн тооцооллын гол үзүүлэлтүүд

Нийт төслийн хугацаанд компани 257.1 сая ам.долларын үйл ажиллагааны орлого, 193.4 сая ам.долларын татварын өмнөх мөнгөн урсгалтай ажиллахаар төлөвлөсөн. Мөн эдгээр тооцоонд Алтан Нар орд, Хар Морь, Алтан Сум хэтийн төлөв бүхий талбайн нөөцийг оруулснаар компанийн эдийн засгийн үзүүлэлтүүд нэмэгдэх боломжтой.

Хүснэгт 20. Баян Хөндий төслийн эдийн засгийн тооцооллын голлох үзүүлэлтүүд

Санхүүгийн үзүүлэлтүүд	Нэгж	Дүн
Үйлдвэрлэсэн алт	Унц	381,668.0
Борлуулах алт (99.85%)	Унц	381,096.0
Орлого	сая US\$	533.5
Бүтээгдэхүүн борлуулах зардал	сая US\$	(1.1)
<b>Нийт төслийн орлого</b>	<b>сая US\$</b>	<b>532.5</b>
Үйл ажиллагааны зардал	сая US\$	(242.0)
Роялти	сая US\$	(32.0)
Хөрөнгийн татвар	сая US\$	(1.4)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>сая US\$</b>	<b>257.1</b>
Анхны хөрөнгө оруулалт	сая US\$	(59.2)
Тогтвортой хөрөнгө оруулалт	сая US\$	(3.7)
Байгаль орчин болон уурхайн хаалт	сая US\$	(2.9)
Үлдэгдэл өртөг	сая US\$	2.0
<b>Татварын өмнө мөнгөн урсгал</b>	<b>сая US\$</b>	<b>193.4</b>
Орлогын татвар	сая US\$	(55.8)
<b>Татварын дараах мөнгөн урсгал</b>	<b>сая US\$</b>	<b>137.6</b>

Төсөл нь анхны хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх хугацаа татварын өмнөх мөнгөн урсгалын хувьд 1.6 жил, татварын дараах мөнгөн урсгалын хувьд 1.9 жил байна.

Б.Сергеев





**Алтны үнээс хамаарах хэлбэлзэл**

Баян Хөндий төслийн эдийн засгийн тооцоололд алтны суурь үнийг 1,400 ам.доллар/унц байхаар тооцоолсон ба алтны үнийн хэлбэлзлээс хамааран төслийн дотоод өгөөжийн хувь, цэвэр мөнгөн урсгал дараах байдлаар хэлбэлзэж байна. 1,400 ам.доллараар тооцоолсон татварын дараах мөнгөн урсгалын IRR: 42.4%, NPV@5%: 100 сая ам доллар байгаа бол унц алтны үнэ 1,800 ам.доллар болж өсөхөд IRR: 77.1%, NPV@5%: 216 сая ам.доллар болж өсөх тооцоолол хийгдсэн.

Хүснэгт 21. Алтны үнээс хамаарсан NPV, IRR мэдрэмжийн шинжилгээ

**Татварын өмнөх мөнгөн урсгалын хувьд**

	Татварын өмнөх IRR	NPV (5%) сая.дол	NPV (7.5%) сая.дол	NPV (10%) сая.дол
1200\$	36.94%	87	73	61
<b>1400\$</b>	<b>55.06%</b>	<b>145</b>	<b>126</b>	<b>109</b>
1600\$	71.78%	203	178	156
1800\$	87.69%	260	230	204
2000\$	102.94%	318	282	251

**Татварын дараах мөнгөн урсгал**

	Татварын дараах IRR	NPV (5%) сая.дол	NPV (7.5%) сая.дол	NPV (10%) сая.дол
1200\$	22.34%	43	33	25
<b>1400\$</b>	<b>42.41%</b>	<b>100</b>	<b>86</b>	<b>73</b>
1600\$	60.39%	158	138	120
1800\$	77.11%	216	190	168
2000\$	92.97%	274	242	215

Алтны үнэ 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар 1,761.2 ам.дол/унц байна.

График 10. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл





График 11. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл



\* IRR болон NPV тооцоолол нь сарын мөнгөн урсгалд үндэслэсэн тооцоолол болно.

Бсирмаа



2021.06.27



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

### 2.4.3. Төслийг тэлэх боломжууд

#### Нөөцийг нэмэгдүүлэх боломж- Алтан Нар орд

Алтан Нар ордын нөөцийг тооцоолохдоо нийт тодорхойлсон 18 хэтийн төлөв бүхий талбайн 2 талбайн өрөмдлөгийн үр дүнгүүдэд тулгуурлан тодорхойлсон бөгөөд ирээдүйд өрөмдлөгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр нөөцийг тэлэх боломжтой.

Алтан Нар ордод олборлолтыг эхлүүлснээр компанийн борлуулалт, эдийн засгийн үзүүлэлтүүд нэмэгдэх боломжтой.

*Дэлгэрэнгүй мэдээллийг 1.5.5-д буй Алтан Нар ордын мэдээллээс харна уу.*

#### Хэтийн төлөв бүхий талбай– Хар Морь болон бусад

Хар Морь, Алтан Сум талбай нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлаж буй бөгөөд нөөцийн тооцооллыг гүйцэтгэн холбогдох зөвшөөрлийг авч, тайланг гүйцэтгэсний үндсэн дээр Баян Хөндий төслийн дэд бүтцийг ашиглан олборлолтыг эхлүүлэх боломжтой эсэхийг судлаж байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг 1.5.6-д буй хэтийн төлөв бүхий талбайн мэдээллээс харна уу.*

### 2.4.4. Хайгуулын төлөвлөгөө

Компанийн өнөөгийн илрүүлээд буй гурван ордын газрын гадаргад ойр байрлал болон бусад хайгуулын талбайнуудад хийсэн гадаргын судалгааны үр дүн зэрэг нь энэхүү шинэ дүүргийн ирээдүйн геологийн боломж, хэтийн төлөвийг тодорхойлж байна.

Компани нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийн талбайн эрдэсжсэн бүсэд хайгуулын боломжийг эрэлхийлэн ажиллаж байна. Ойрын хугацаанд төлөвлөсөн хайгуулын хөтөлбөрийн дагуу Компанийн 5 тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн хэтийн төлөв бүхий хайгуулын талбайг илрүүлэн өрөмдлөгийн ажлыг эхлүүлэх, сонгон шалгаруулалтын хүрээнд нэмэлт талбайн тусгай зөвшөөрлийг Засгийн Газраас авах зэрэг ажлыг төлөвлөсөн.

Хөндий болон Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлүүд, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнууд геологийн зураглал, геохими, геофизикийн судалгаанууд болон суваг малталт ба өрөмдлөгийн ажлууд хийгдэнэ.

Хар Морь талбай болон Улаан тусгай зөвшөөрлийн хэтийн төлөв бүхий талбайд геофизикийн нэмэлт судалгааг хийж байна. Геофизикийн судалгааг гүйцэтгэсний дараа 2021 оны 3-4-р улиралд Улаан тусгай зөвшөөрлийн талбайд 4,500 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр, Хар Морь талбайд 4,300 метр, нийт 8,800 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэхээр төлөвлөсөн.

### 2.4.5. Үнэлгээ өсөх боломж


#### Уул уурхайн мөчлөг

Уул уурхайн мөчлөг нь хайгуул, бүтээн байгуулалт, үйлдвэрлэл болон уурхайн хаалт гэсэн дөрвөн үе шатанд хамаардаг. Дэлхийн алтны консул (World Gold Council) -ийн судалгаагаар хайгуулын үйл явц дунджаар 1-10 жил, бүтээн байгуулалт болон хөгжүүлэлт 1-5 жил, олборлолт уурхайгаас хамааран 30 хүртэл жил, уурхайн хаалт 1-5 жил үргэлжилдэг.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Бсерисе*






Баян Хөндий төслийн хувьд 2015 онд нээн илрүүлэн, бүтээн байгуулалтын үе шат руу хөгжүүлэх явцад уул уурхайн төслүүдэд тулгардаг эрсдэлүүдийг бууруулан, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэн ажилласан.

Компани нь хайгуулын эрсдэл, техникийн эрсдлүүдийг бууруулан, нарийвчилсан ТЭЗҮ-ийн тайланг танилцуулсан бөгөөд төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлснээр санхүүжилтийн эрсдлийг бууруулж, олборлолтыг эхлүүлэх боломжтой. Уул уурхайн компани нь хайгуулын үе шатаас олборлолт руу шилжихэд дахин үнэлгээ хийгдэн, үнэ цэн өсөх өндөр боломжтой.

Доорх хүснэгтээр олборлолтыг эхлүүлсэн компаниудын дахин үнэлгээг харуулав.



Яарамко 2016 онд олборлолт эхэлсэн



АЦО 2020 онд олборлолт эхэлсэн



Олборлолтын 2020 онд эцэст эхэлсэн

2.3X дахин үнэлгээ

3.0X дахин үнэлгээ

3.1X дахин үнэлгээ

Баян Хөндий төслийн хувьд бүтээн байгуулалт дуусан, олборлолт эхлэхэд Компанийн хувьцааны ханшид дахин үнэлгээ хийгдэх боломжтой бөгөөд Баян Хөндий төслөөс гадна Хөндий Алтны Дүүргийн хэтийн төлөв бүхий талбай дахь хайгуулыг үргэлжлүүлэн, нөөцийг тэлж, хувьцаа эзэмшигчдийн өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

20210827

Бсериа





### 2.4.6. Зах зээлийн судалгаа

#### Олон улсын алтны зах зээлийн төлөв байдал

#### Дэлхийн алтны зах зээлийн нийт эрэлт

Дэлхийн алтны эрэлт нь 4 гол хүчин зүйлээс хамааралтай. Үүнд: Төв банкуудын алтны нөөцийг нэмэгдүүлэх худалдан авалт, эрсдлийн удирдлагад зориулсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, үнэт эдлэл, үйлдвэрлэлийн хэрэглээ багтана.

2011-2019 оны хооронд дэлхийн алтны зах зээлийн эрэлт харьцангуй тогтвортой түвшинд хэлбэлзэж байсан хэдий ч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр өмнөх оны үзүүлэлтээс 13 хувиар буурч 3,803.1 тоннд болсон нь 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн доод цэгт хүрсэн үзүүлэлт болсон. Энэхүү бууралтад Ковид-19 цар тахлаас сэргийлэх үүднээс хэрэгжүүлсэн улс орнуудын хязгаарлалтын арга хэмжээ болон алтны үнийн өсөлт дэлхийн томоохон үнэт эдлэл худалдан авагч улс орнуудад сөргөөр нөлөөлж үнэт эдлэлийн салбар дахь алтны эрэлт өнгөрсөн оны мөн үеэс 34 хувиар огцом буурч 1,400 тоннд хүрсэн үзүүлэлт голчлон нөлөөлсөн.

Цаашид дэлхийн алтны зах зээлийн эрэлт World Gold Council-н 2021 оны 01 сард хийсэн судалгаагаар 2021-2022 онд жилд дунджаар 4.2 хувиар өсч 2022 онд 3,892 тоннд хүрэх төлөвтэй байна. Энэхүү судалгаагаар үнэт эдлэлийн салбар дахь алтны эрэлт 2022 онд 2,008 тоннд хүрч, жилд дунджаар 13 хувиар өсөх хүлээлттэй байна.

График 12. Дэлхийн алтны зах зээлийн эрэлт



Эрх сурвалж: Gold supply and demand statistics, www.gold.org

#### Төв банкуудын худалдан авалт


Дэлхийн улсуудын Төв банкууд өөрсдийн нөөцийн тодорхой хэсгийг алт хэлбэрээр бүрдүүлдэг ба энэ нь алтны зах зээл дэх эрэлтийн багагүй хувийг эзэлдэг.

Хамгийн их алтны нөөцтэй төв банкуудын алтны хэмжээ болон тухайн улсынхаа нийт нөөцөд эзлэх хувь 2021 оны 04 дүгээр сарын байдлаар дараах харьцаатай байна.

Басрия



20210827



Хүснэгт 22. Төв банкны алтны нөөцөөрөө тэргүүлэгч орнууд

Улс	Алтны нөөц /тн/	Нийт нөөцөд эзлэх хувь	Улс	Алтны нөөц /тн/	Нийт нөөцөд эзлэх хувь
АНУ	8,134	79	Недерланд	613	71
Герман	3,364	76	Хятад	1,948	3
Итали	2,452	71	Швейцарь	1,040	7
Франц	2,436	66	Япон	765	3
Орос	2,300	23	Энэтхэг	658	8

Эх сурвалж: <https://www.usfunds.com/investor-library/frank-talk-a-ceo-blog-by-frank-holmes/top-10-countries-with-largest-gold-reserves/#.YKcYQKqzblU>

**Дэлхийн төв банкуудын алтны нөөц**

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнуудын эдийн засаг тодорхойгүй нөхцөл байдалд шилжиж улсуудын төв банкууд алтны нөөцөө багасгаж, эдийн засгийн өсөлтөө дэмжихийн тулд хөрвөх чадвараа нэмэгдүүлснээс шалтгаалан дэлхийн алтны зах зээл дээрх төв банкуудын алтны нийт нөөцийн хэмжээ 273 тоннд хүрч өмнөх жилийн мөн үеэс 58 хувиар огцом буурсан.

График 13. Дэлхийн алтны зах зээл дээрх төв банкны нөөцийн хэмжээ (тонн)



Эх сурвалж: <https://www.usfunds.com/investor-library/frank-talk-a-ceo-blog-by-frank-holmes/top-10-countries-with-largest-gold-reserves/#.YKcYQKqzblU>

Олон улсын валютын сангийн 2021 оны нэгдүгээр улирлын байдлаарх дэлхийн эдийн засгийн судалгаагаар дэлхий даяар Ковид-19 вирусийн эсрэг вакцинжуулалт эхэлсэнтэй холбоотойгоор улс орнуудын эдийн засаг тогтворжиж байгаа тул томоохон улсуудын төв банкууд алтны нөөцөө нэмэгдүүлэх хандлагатай байна.

**Хөрөнгө оруулалт**

Хөрөнгө оруулалтын салбар дахь алтны эрэлт дэлхийн алтны зах зээлийн нийт эрэлтийн томоохон хувийг бүрдүүлдэг. Хөрөнгө оруулагчид ETF сангаар дамжуулан, мөн алтан зоос, гулдмай байдлаар худалдан авч нийт алтны зах зээлийн эрэлтэд нөлөөлдөг. ETF-н хөрөнгө оруулалтын хэмжээ дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, улс орнуудын бодлогын хүү буурах тохиолдлуудад нэмэгдэх хандлага ажиглагддаг.


20210827

*Б.Сүрэн*



2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улс орнуудын эдийн засгийн өсөлт удааширч, дэлхийн томоохон улсууд бодлогын хүүгээ бууруулсан нь хөрөнгө оруулагчдын найдвартай хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох алтанд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж хөрөнгө оруулалтын салбар дахь алтны эрэлт түүхэн дээд цэг буюу 1,773.8 тоннд хүрч өмнөх жилийн мөн үеэс 40 хувиар огцом өссөн.

График 14. Хөрөнгө оруулалтын чиглэлийн алтын эрэлт




Эх сурвалж: Gold supply and demand statistics, www.gold.org

Хөрөнгө оруулалтын салбар дахь алтны эрэлтийн төлөв байдал нь цар тахлын нөхцөл байдлаас хамаарах хэдий ч олон улсын валютын сангийн судалгаагаар Ковид-19 вирусийн вакцин гарсан нь дэлхийн эдийн засаг сэргэх хүчин зүйл болж, хөрөнгө оруулалтын чиглэл дэх алтны эрэлт буурах магадлалтай.

### Дэлхийн алтны зах зээлийн нийт нийлүүлэлт

Дэлхийн алтны зах зээлийн нийт нийлүүлэлтийн 70 орчим хувийг алтны уурхайн олборлолт дангаараа бүрдүүлдэг. 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр уурхайн олборлолт тасалдсаны улмаас дэлхийн нийт алтны зах зээлийн нийлүүлэлт 4,620 тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар буурсан нь 2013 оноос хойших хамгийн их хувиар буурсан үзүүлэлт болов.

График 15. Дэлхийн алтны зах зээлийн нийлүүлэлт



Эх сурвалж: Gold supply and demand statistics, www.gold.org

Олон улсын мэргэжлийн байгууллагуудаас ойрын жилүүдэд алтны зах зээлийн нийлүүлэлтийн хэмжээ өснө гэсэн таамаглалыг дэвшүүлээд байна. Тухайлбал,

- World Gold Council-н судалгаагаар 2021-2022 онд дэлхийн алтны зах зээлийн нийлүүлэлт жилд дунджаар 3.5 хувь өсч 2022 онд 5,087 тоннд хүрэх төлөвтэй байна.
- Олон улсын судалгааны байгууллага болох Fitch Solutions компанийн дэлхийн алтны зах зээлийн төлөв байдлын судалгаагаар дэлхийн алтны уурхайн олборлолтын хэмжээ 2029 онд 133 сая унцид хүрч, жилийн 2.5 хувийн өсөлттэй байх төлөвтэй байна.


**Алтны үнийн түүхэн трэнд**

2000 оны 1 сард нэг унц алтны үнэ \$284 байсан бол 2021 оны 04 сард \$1,762-т хүрч жилийн дундаж 8.93%-ийн өсөлт үзүүлсэн. Өнгөрсөн 20 жилийн алтны үнийн өсөлтийг 5 жилийн интервалаар авч үзвэл 2001-2005 онд 13.95%, 2006-2010 онд 20.39%, 2011-2015 онд (4.66%), 2016-2020 онд 11.08%-ийн жилийн дундаж өсөлттэй байна.

Алтны ханш 2008 оны дэлхийн эдийн засгийн их хямралын дараа АНУ эдийн засгийн тэлэх бодлого баримталж, америк долларын нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр 2011 онд түүхэн дээд ханш болох \$1,920 хүрч байв. 2012 оноос хойш дэлхийн эдийн засаг аажмаар тогтворжиж 2015 онд алтны ханш \$1,046-т хүрсэн хэдий ч 2016 онд АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд Доналд Трамп ялснаар АНУ БНХАУ-тай худалдааны дайн зарлаж, мөн АНУ бодлогын хүүгээ шат дараатайгаар нэмсэн нь алтны ханшийг дахин өсөхөд гол нөлөөг үзүүлсэн.

2020 онд дэлхий даяар Коронавирусийн тархалт эрчимжиж дэлхийн эдийн засаг тодорхойгүй нөхцөл байдалд шилжиж, хөгжингүй орнуудад эдийн засгийн тэлэх бодлого үргэлжилсэн нь аюулгүй хөрөнгө оруулалт болох алтны үнэ өсөхөд нөлөөлж түүхэн дээд цэг болох \$2,067 -д хүрэхэд нөлөөлсөн.

График 16. 2000-2020 оны алтны үнийн түүхэн үзүүлэлт (ам.доллар/унц)




2021.08.27

**Алтны үнийн таамаглал**

Дараах олон улсын байгууллагуудын таамаглалаар нэг унц алтны үнэ урт хугацаанд 1,350-8,732 ам.долларын хооронд байх хүлээлттэй байна. Баян Хөндий төслийн ТЭЗҮ-д нэг унц алтны үнийг 1,400 ам.доллараар борлуулахаар төлөвлөсөн нь олон улсын шинжээчдийн төлөвлөсөн үзүүлэлтээс харьцангуй бага буюу консерватив таамаглал юм.

График 17. Алтны үнийн төсөөлөл (ам.доллар/унц)



**Алтны томоохон нийлүүлэгч улсуудын үйлдвэрлэл ба цар тахлын нөлөө**

График 18. 2019 оны байдлаар алтны нийлүүлэлтээр тэргүүлэгч орнууд (тонн)





График 19. Ковид-19 цар тахлын үеийн алтны үйлдвэрлэлийн нөлөө




2020 оны байдлаар дэлхийд алтны нийлүүлэлтээр тэргүүлэгч орнуудад БНХАУ, ОХУ, Австрали, АНУ, Канад, Перу, Гана, Өмнөд Африк, Мексик, Бразил зэрэг улсууд орсон ба эдгээр улс нь нийт олборлосон алтны нийлүүлэлтийн 44 хувийг эзэлж байна.

Ковид-19 цар тахал дэлхийн томоохон алт олборлогч улсууд болох БНХАУ, ОХУ болон Австрали улсуудын алтны нийт олборлолтын хэмжээнд хүчтэй нөлөө үзүүлээгүй боловч дэлхийн хамгийн том алтны уурхайн компани болох Ньюмонтын үйлдвэрлэл тасалдснаар Мексик, Аргентин, Канад гэх мэт улсуудын алт олборлолтын хэмжээ багасахад хүчтэй нөлөөлсөн.

20210827

График 20. Алтны нийлүүлэлтээр тэргүүлэгч улсуудын ирээдүйн олборлолтын төсөөлөл



Fitch Solutions судалгааны байгууллагын дэлхийн алтны зах зээлийн төлөв байдлын төсөөллөөр одоогийн хамгийн том алт олборлогч улс БНХАУ-ын алт олборлолт 2020-2029 онуудад жилд дунджаар 0.2 хувийн өсөлттэй байх хүлээлттэй байна. Энэ нь ОХУ-ын ирэх жилүүдийн алт олборлолтын өсөлтөөс харьцангуй бага үзүүлэлт бөгөөд уг судалгаагаар ОХУ-ын алт олборлолт 2029 он гэхэд 15.5 сая унц болж, жилд дунджаар 3.7 хувиар өсөх төлөвтэй байна. Хэрэв ОХУ энэхүү таамаглалаар өсч чадвал 2029 он гэхэд БНХАУ-ыг гүйцэн хамгийн том алт олборлогч улс болж, дэлхийн нийт алтны гарцын 11.6 хувийг дангаараа бүрдүүлэхээр байна.

Эх сурвалж: <https://www.mining.com/global-gold-production-to-grow-2-5-by-2029-report/>  
<https://www.statista.com/statistics/264628/world-mine-production-of-gold/>

**Монгол Улсын макро эдийн засгийн орчин**

**ДНБ ба эдийн засгийн нөхцөл байдал**

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2011-2019 оны хооронд 13.17 их наяд төгрөгөөс 37.28 их наяд төгрөгт хүрч 3.5 дахин өссөн байна. 2011-2014 оны хооронд хамгийн өндөр буюу 68.7 хувийн өсөлттэй байсан нь Монгол Улсад 2011 оноос эхлэн уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэн, дотоодын арилжааны банкууд болон Засгийн газар олон улсын санхүүгийн зах зээлд бонд гарган эх үүсвэр бүрдүүлж төсвийн бодлого хэт тэлсэнтэй холбоотой. 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 1 их наядаар буурч 5.3 хувиар агшсан байна.

График 21. Дотоодын нийт бүтээгдэхүүн /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МАН-ийн тусгай  
 "Б. Ариун" /Signature/

Б.Серина

2021.08.21



2021 онд Монголын эдийн засгийг Дэлхийн банкнаас 4.3 хувиар, Economic Intelligence Unit 5.4 хувиар өснө хэмээн таамаглаж байгаа ба энэхүү өсөлтөд уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын өсөлт голчлон нөлөөлөх төлөвтэй байна.


**Уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх хувь**

Уул уурхайн салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн болон улсын төсвийн 20 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг эдийн засгийн чухал ач холбогдолтой салбар юм. 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр уул уурхайн салбар 5.2 хувиар агшсан нь эдийн засаг 1.1 хувиар агшихад шууд нөлөөг үзүүлсэн.

График 23. Дотоодын нийт бүтээгдэхүүн, уул уурхайн салбарын эзлэх хувь /их наяд төгрөг/



График 22. Уул уурхайн салбарын орлогын төсөвт эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголбанкны судалгаагаар 2021 онд дэлхийн эдийн засаг сэргэж, Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнэ, хэмжээ өснө гэсэн хүлээлттэй байна.

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Монгол Улсын улс төрийн тогтворгүй байдал, татварын таатай бус орчин болон төгрөгийн ханшийн уналт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулах гол шалтгаан болдог.

2019 оны байдлаар нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75 орчим хувийг уул уурхайн салбар эзэлж байна. Уул уурхайн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөх нь Монгол Улсад хайгуул, ашиглалтын шатанд явж буй томоохон төслүүдийг амжилттай урагшлуулж эдийн засагт хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой.

График 24. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал /тэрбум. Ам.дол/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Бүсрүүл


2021.09.03



### Монголбанкны гадаад валютын нөөц

Гадаад валютын нөөц нь тухайн улсын мөнгөн тэмдэгтийн тэнцвэртэй байдлыг хангадаг. Сүүлийн 3 жилд гадаад валютын нөөц тогтвортой хэмжээнд байгаа нь Монгол Улсын мөнгөний бодлого, валютын зохицуулалттай холбоотой. 2020 онд Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монголбанкнаас валютын нөөцийн тогтвортой, хүрэлцээтэй байдлыг хангах зорилгоор үнэт металын худалдан авалтыг нэмэх арга хэмжээ авсны үр дүнд гадаад валютын нөөц 4.7 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд цэгт хүрсэн.

График 25- Гадаад валютын нөөц, /сая, ам.дол/



### Монгол улсны алтны салбарын өнөөгийн байдал

#### Алтны нөөц

2020 оны байдлаар Монгол Улсын 0.23 сая га талбайд 11 үндсэн орд, 24 шороон ордын 83.7 тонн алтны нөөц бүртгэгдэж өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 16.3 тонноор буюу 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23. Монгол Улсын алтны нөөц

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Үндсэн орд (мян.тн/кг)	307,073	41,109	30,107	95,376	28,044	33,819	3,211	18,697	63,903	80,870
Шороон орд/кг/	4,008	7,659	4,736	4,866	6,130	5,955	3,015	4,600	3,621	2,920
Нийт	311,081	48,768	34,843	100,242	34,174	39,774	6,226	23,297	67,524	83,790

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам


#### Алт олборлолт болон экспорт

Монгол Улсын уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох алт олборлолт 2020 онд 15.8 тоннд хүрсэн нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны 11 дүгээр сард Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ нэмэгдэж 5 хувь болсон хэдий ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр алтны үнэ өссөн нь Монгол Улсын алтны экспортыг огцом өсгөхөд голчлон нөлөөлсөн. 2020 онд Монгол Улсын алтны экспортын хэмжээ түүхэн дээд цэгт хүрч 30.5 тонн алт экспортолж, 1.7 тэрбум ам.долларын орлого олсон нь улсын экспортын орлогыг хэвээр хадгалахад эерэг нөлөө үзүүлэв.

20210827

График 26. Алтны олборлолт болон экспорт, /тонн/




Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

### Алт тушаалт

Монголбанк иргэд, аж ахуй нэгжүүд, мөн иргэдээс алт худалдан авах эрх олгосон арилжааны банкуудаас алт худалдан авах үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулдаг. Монголбанк нь Монгол Улсын валютын тогтвортой байдлыг хангах хүрээнд 2014-2019 онуудад АМНАТ-ын төлбөрийг 2.5 хувийн болгосон нь алт тушаалтыг нэмэгдүүлсэн. 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 465 тоот Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор АМНАТ-г 2.5-5 хувь болгож өсгөсөн хэдий ч 2020 онд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монголбанк үнэт металын худалдан авалтыг нэмэгдүүлснээр алтны тушаалтын хэмжээ 23.6 тонн болж өссөн.

Монголбанк 2016-2020 онд 100 орчим тонн үнэт метал худалдан авч улсын гадаад валютын нөөцийг 3.7 тэрбум ам.доллараар нэмэгдүүлжээ.

График 27. Монгол банкинд тушаасан алтны хэмжээ, /тонн/



Эх сурвалж: Монгол банк

### Алтны олборлолт, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй хөтөлбөр

#### Алт-1 хөтөлбөр

Монгол Улс 1992-2000 онд "Алт-1" хөтөлбөрийг хэрэгжүүлэн хөрөнгө оруулалт татаж чадсаны үр дүнд алтны жилийн олборлолтыг 0.7-11.0 тоннд хүргэж, шороон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад түшиглэн ашиглалтад оруулан, ихээхэн хэмжээний татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь тус салбарыг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж холбогдох байгууллагаас дүгнэсэн.

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Б.Серина

20210827



Алт-2 хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газар 2017 онд “Монгол Улсын алт үйлдвэрлэлийн салбарын дунд болон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, хууль эрх зүй, татварын орчинг тогтвортой байлгах, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, үндсэн болон алт агуулсан бусад металлын ордуудыг ашиглах замаар алтны үйлдвэрлэлийг тогтвортойгоор нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй бөгөөд тогтвортой хөгжлийг дэмжсэн алт олборлох, боловсруулах тэргүүний техник технологи, менежмент нэвтрүүлэх, алт үйлдвэрлэлийн салбараас эдийн засагт оруулах үр өгөөжийг дээшлүүлэх” зорилготойгоор 2017-2020 оны хооронд 2 үе шаттайгаар Алт-2 хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн.

Алт-2 хөтөлбөрийн хүрээнд таван зорилт дэвшүүлсэн. Үүнд:

1. Хууль, эрх зүй, татварын орчинг тогтвортой байлгах
2. Геологийн нөөцийг нэмэгдүүлэх, судалгааг сайжруулах
3. Олборлолтыг өсгөх, жилд 2-3 тонноор тогтмол өсгөж, Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг 25 тонн хүргэх
4. Технологийн дэвшлийг ашиглан хариуцлагын тогтолцоог чангатгах
5. Бичил уурхайн асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулж, шийдэх

Дээрх зорилтуудын хүрээнд Монголбанкны зүгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон банкуудтай хамтран алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлтэй зээлийн санхүүжилт дотоодын алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд олгосон. Уг хөтөлбөрийн санхүүжилтээр зээл авсан аж ахуйн нэгжүүд 2017 онд нийт 159 кг, 2018 онд 630 кг алт тушаасан байна.

2.5. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Компани Баян Хөндийн ил уурхайн бүтээн байгуулалт болон Хөндий Алтны Дүүргийн хайгуул судалгааны зорилтыг хэрэгжүүлэхээр Төслийн Санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Төслийн санхүүжилт нь компанийн энгийн хувьцаагаар, зээлээр, болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ. Аливаа нөхцөлд төслийн санхүүжилтийн зээлийн гэрээнээс өмнө компани шаардлагатай хувьцааны санхүүжилтийг татан төвлөрүүлдэг олон улсын төслийн санхүүжилтийн зарчмын хүрээнд энэхүү нэмж гаргаж буй хувьцаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийн тодорхой хэсгийг Баян Хөндий төслийн үйл ажиллагаанд зарцуулна.

Компани нь энэхүү үнэт цаасны танилцуулгын хүрээнд нийт 5 сая ам.долларын татан төвлөрүүлэх ба татан төвлөрүүлэх хөрөнгийн 50% буюу 2.5 сая ам.долларыг уурхайн бүтээн байгуулалт, барилгын бэлтгэл ажил, 40% буюу 2.0 сая ам.долларыг хайгуул, судалгааны ажил болон 10% буюу 0.5 сая ам.долларыг захиргаа, удирдлагын зардалд зарцуулахаар төлөвлөсөн.

Төслийн талбайн бэлтгэл ажил

Бүтээн байгуулалтын талбайн бэлтгэл ажил болон ажилчдын байрлах орон сууц, оффис, харуул хамгаалалт, агуулахын байр.

2,500 мянган ам.доллар /хүртэл/

Хайгуул, судалгаа

Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлүүдийн талбайд эрдэсжилт ба нөөцийг тэлэх

2,000 мянган ам.доллар (хүртэл/)

Б.Сүрэн



40210827



ЭРДЭНЭ РЕСУРС ДЭВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |



Захиргаа, ерөнхий удирдлага  
Төслийн удирдлага, инженерчлэл, ерөнхий  
удирдлагын зардал.

**500** мянган  
ам.доллар  
/хүртэл/

**НИЙТ**

**5,000** мянган  
ам.доллар

Үнэт цаас гаргагч нь бусад үндсэн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтыг төвлөрүүлэх зорилгоор Төслийн Санхүүжилтийн Зөвлөх HCF, Төслийн хуулийн зөвлөх McInnes Cooper LLP компаниудтай хамтран ажиллаж байна.

Компани 2020 оны 11 сарын 4-нд Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай ("EDC" эсхүл "Export Development Canada") Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалт, хөгжүүлэлтийг гүйцэтгэх \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичигт ("Mandate letter") гарын үсэг зурсан.

Энэхүү санхүүжилт нь техник, хууль эрхзүй, нийгэм болон байгаль орчны нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэх, зээлийн тохиромжтой нөхцөлүүдийн гүйцэтгэл, зээлийн эцсийн баталгаа болон холбогдох бичиг баримтуудыг гүйцэтгэн баталгаажна. Нарийвчилсан судалгаа нь төлөвлөгөөний дагуу хийгдэж, 2021 оны сүүлийн хагаст эцэслэгдэх төлөвтэй байна.

20210827

*Б.Сергеев*



**2.6. Санхүүгийн төсөөлөл**

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэл эхлүүлээгүй, хайгуулын ажиллагааг голчлон гүйцэтгэж байгаа тул энэхүү үнэт цаасны танилцуулгын хүрээнд компанийн нийт үйл ажиллагааг хамарсан санхүүгийн тайлангийн таамаглал, мөнгөн гүйлгээний төсөөлөл хийгдээгүй болно.

Энэхүү танилцуулгад зөвхөн Баян Хөндий төслийн мөнгөн урсгалын тооцооллыг тусгаж байгаа бөгөөд дараах мөнгөн урсгалын төсөөлөл нь Баян Хөндий төслийн олборлолт, үйлдвэрлэл, зардлын төсөөлөлд үндэслэн хийгдсэн. Үүнд компанийн бусад төслийн (Алтан Нар, Хар Морь, Зуун Мод гэх мэт) орлого ашгийн үзүүлэлт болон хайгуулын ажлыг санхүүжүүлэх зардал, тооцоолол багтаагүй.

Хүснэгт 24. Баян Хөндий төслийн мөнгөн урсгалын таамаглал

Хугацаа	Бүтээн байгуулалтын өмнөх нэгж		Бүтээн байгуулалт		Ашиглалтын жил								Уурхайн хаалт	
	0	1	2	3	4	5	6	7	8					
<b>Орлого</b>	000\$	-	80,280	108,621	91,091	79,680	110,587	63,284	-	-	-	-	-	-
Нийт борлуулалт үйл ажиллагааны зардал	000\$	-	(161)	(215)	(181)	(159)	(218)	(128)	-	-	-	-	-	-
<b>Үйл ажиллагааны зардал</b>														
Уурхайн үйл ажиллагааны зардал	000\$	(4,304)	(28,407)	(27,800)	(27,554)	(21,973)	(12,072)	(11,145)	-	-	-	-	-	-
Металл боловсруулалтын зардал	000\$	(701)	(13,425)	(16,561)	(16,535)	(16,438)	(16,396)	(15,900)	-	-	-	-	-	-
Бусад үйл ажиллагааны зардал	000\$	(670)	(1,848)	(2,195)	(2,140)	(2,072)	(2,119)	(1,712)	-	-	-	-	-	-
<b>Нийт уурхайн талбар дээр гарах үйл ажиллагааны зардал</b>	000\$	(5,674)	(43,680)	(46,557)	(46,229)	(40,483)	(30,587)	(28,757)	-	-	-	-	-	-
Уурхайн талбараас гадна гарах бусад зардал	000\$	(182)	(182)	(182)	(182)	(182)	(182)	(182)	(15)	-	-	-	-	-
Роялти	000\$	-	(4,815)	(6,515)	(5,464)	(4,779)	(6,633)	(3,796)	-	-	-	-	-	-
<b>EBITDA</b>	000\$	(5,856)	31,442	55,152	39,036	34,077	72,967	30,421	(15)	-	-	-	-	-
<b>Төслийн капиталын зардал</b>														
Бүтээн байгуулалтын шууд бус зардал	000\$	(2,793)	(9289)	(968)	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бүтээн байгуулалтын шууд зардал	000\$	(4,484)	(35,569)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үйлдвэрлэлийн өмнөх боловсруулах үйлдвэрийн материалын зардал	000\$	-	(551)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Болзоогүй зардал	000\$	(430)	(3,984)	(366)	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөдөлгөөнт тоног төхөөрөмж	000\$	(300)	(466)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Урсгал хөрөнгө оруулалт	000\$	-	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)	(542)
Үндэстэй өртөг	000\$	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	2,000
Байгаль орчин болон уурхайн хаалт	000\$	-	(22)	(22)	(22)	(19)	(67)	(67)	(635)	(67)	(635)	(635)	(2,061)	(2,061)
<b>Капитал хувирах зардал</b>	000\$	(7,707)	(49,692)	(2,364)	(564)	(961)	(609)	(609)	(1,177)	(61)	(61)	(61)	(61)	(61)
<b>Татварын өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	000\$	(7,798)	29,078	54,588	38,075	33,468	72,358	29,244	(76)	-	-	-	-	-
Татвар	000\$	-	(4,732)	(12,352)	(8,375)	(7,255)	(16,857)	(6,266)	-	-	-	-	-	-
<b>Татварын дараах цэвэр мөнгөн гүйлгээ</b>	000\$	(7,798)	24,345	42,236	29,700	26,213	55,501	22,978	(76)	-	-	-	-	-

*Берни*

1115205447 ш 2052402

2021.08.27

2021.09.22  
БЭРТЭД

0000110  
2021-09-03

- Компани нэг унц алтыг 1,400 унц/ам.доллараар борлуулахаар таамаглан нийт төслийн хугацаанд компани 533.5 сая ам.долларын борлуулалтын орлоготой, 257.1 сая долларын үйл ажиллагааны орлоготой ажиллахаар төлөвлөсөн.
- Уурхайн үйл ажиллагааны хугацаанд алт үйлдвэрлэхтэй холбоотой 279 сая ам.долларын зардал гарахаар буюу нэг унц алтыг 733 ам.долларын зардлаар үйлдвэрлэхээр төлөвлөсөн.
- Нийт нэгжийн өртөг (AISC) нь US\$733/унц байгаа нь Баян Хөндий орд нь дэлхийн хэмжээний ил уурхайнуудтай харьцуулахад бага өртөгтэй ордуудын нэгт тооцогдож байна. S&P Global-ын судалгаагаар 2020 онд дундаж AISC /All in Sustaining Cost/ нь 975 ам.доллар/ унц байна.
- Хүдрийн биет алтны агуулга өндөр, боловсруулах процесс хялбар, газрын дөт гүнд байх зэргийг харгалзан ил уурхайн олборлолтыг өртөг багатай, үр ашгийг өндөр байлгахар төлөвлөн ТЭЗҮ-ийг гүйцэтгэсэн нь нэгжийн өртөг бага байхад нөлөөлсөн.
- Нийт төслийн хугацаанд 193.4 сая ам.долларын татварын өмнөх мөнгөн урсгал, 137.6 сая ам.долларын татварын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар төлөвлөсөн. Энэ нь компанийн 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар компанийн зах зээлийн үнэлгээтэй харьцуулахад 1.6 дахин өндөр байна.
- Төсөл анхны хөрөнгө оруулалтыг татварын өмнөх мөнгөн урсгалаар 1.63 жилд, татварын дараах мөнгөн урсгалаар 1.92 жилд нөхөхөөр байна.
- Төслийн дотоод өгөөжийн хувь татварын өмнөх мөнгөн урсгалын хувьд 55.06%, татварын дараах мөнгөн урсгалын хувьд 42.53% байна.


### Алтны үнийн өсөлт

Баян Хөндийн ТЭЗҮ-д нь нэг унц алтны үнийг 1,400 ам.доллараар төсөөлсөн. 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар нэг унц алтны үнэ 1,761.2 ам.доллар байна. Алтны үнэ 1,800 ам доллар байхад төслийн татварын дараах үнэ цэн (NPV5%) 216 сая ам.доллар байгаа одоогийн зах зээлийн үнэлгээнээс 2.55 дахин өндөр байна.

График 28. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл



График 29. Алтны үнээс хамаарсан хэлбэлзэл



\* IRR болон NPV тооцоолол нь сарын мөнгөн урсгалд үндэслэсэн тооцоолол болно.

20210827

**2.7. Үнэт цаасны арилжаа**

Үнэт цаасыг бүртгэх зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөл гарсны дараа хувьцааг нийтэд санал болгоно. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам” болон Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу явагдана.

Анхдагч зах зээлд санал болгох хуваарийг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь МХБ, СЗХ-той зөвшилцөн тогтоож нийтэд танилцуулж ажиллана.

Схем 7. Анхдагч зах зээлд санал болгох явц



**Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд захиалга өгөх заавар**

Схем 8. Анхдагч зах зээлд захиалга өгөх

 <p><b>ДАНС НЭЭЛГЭХ</b> МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.</p>	 <p><b>ЗАХИАЛГА ӨГӨХ</b> Сонгон үйлчлүүлж буй ҮЦК-даа хувьцаа худалдан авах захиалга өгөх, гэрээ байгуулах.</p>	 <p><b>МӨНГӨӨ ДАНСАНД БАЙРШУУЛАХ</b></p>
---	--	--

Гүйлгээний заавар	
Хүлээн авагч банк:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /95 кодтой банк/ _____ (ҮЦК-ийн код) _____ (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)
Хүлээн авах данс:	_____ (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)
Хүлээн авагч:	Харилцагчийн нэр
Дүн:	Үнэ*тоо+шимтгэл
Утга:	РД, утасны дугаар, Эрдэнэ Ресурс хувьцааны мөнгө

*Бсерия*

115-ийн гишүүн  
Андеррайтер  
Брокер, Андеррайтер  
"ЭНДЭС" УИХБ  
115-ийн гишүүн  
115-ийн гишүүн  
115-ийн гишүүн

2021.08.27



## 2.8. Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон этгээдүүд

### 2.8.1. Андеррайтер

Компанийн нэр:	“Би Ди Сек ҮЦК” ХК
Улсын бүртгэлийн дугаар:	9010001030
Регистрийн дугаар:	2052482
Үйл ажиллагааны чиглэл:	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1, “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн төв байр.
Утас:	976-11-313108, 976-11-323411

### “БиДиСек ҮЦК” ХК-ийн танилцуулга

БиДиСЕК ҮЦК ХК нь Монгол Улсад өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн харилцаа бий болсон цагаас үүсэн байгуулагдаж өнөөг хүртэл 30 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй, салбартаа тэргүүлэгч үнэт цаасны компани юм. Компани нь 2006 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийснээр нийтэд үнэт цаасаа нээлттэй санал болгосон хамгийн анхны үнэт цаасны компани болсон.

БиДиСЕК ҮЦК ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон Андеррайтер, Брокер Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2017 онд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах тусгай зөвшөөрөл авснаар үнэт цаасны зах зээлийн цогц үйлчилгээг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

Одоогийн байдлаар компани нь Улаанбаатар хот болон 8 аймагт хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг түгээх зөвшөөрөлтэй ба дотоод, гадаадын нийт 310 орчим мянган харилцагчдад үйлчилдэг Монгол улсын хамгийн өргөн брокерийн сүлжээг бий болгоод байна. 2011-2020 онуудад МХБ-ийн үнэт цаасны арилжааны нийт гүйлгээний 8-91%-ийг гүйцэтгэснээс 2012 онд хамгийн өндөр буюу үнэт цаасны гүйлгээний 91%-ийг гүйцэтгэсэн.


Мөн Монголын хөрөнгийн биржид шинээр хувьцаа гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажиллагааны 23.4%-д, нэмэлт хувьцаа гаргах ажиллагааны 90.9%-д, нээлттэй компанийн бондын 94.2%-д нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажилласан туршлагатай.

### Тусгай зөвшөөрөл

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн 2005 онд хуучнаар Үнэт цаасны Хороо-ны шийдвэрээр 32 тоот андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 06 сарын 12 өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил, 2011 оны 06 сарын 12-ны өдрийн 170 тоот тогтоолоор 3 жилийн хугацаагаар тус тус сунгасан.

2013 оны 05 сарын 24-ний өдөр “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж

Берма



20210827



андеррайтерийн тусгай зөвшөөрөл хугацаагүй олгогддог болсон ба тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн авсан.

Андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт №18,19-өөс үзнэ үү.

2021 оны 03 сарын 15-ны өдөр байгуулсан “Андеррайтерийн гэрээ”-ний дагуу үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь дараах эрх, үүрэгтэй байна.

**Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг.**

- Үнэт цаас гаргагч нь нэмж гаргасан хувьцааг МХБ, СЗХ-д бүртгүүлэх, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлэх үйл ажиллагааг Андеррайтераар гүйцэтгүүлнэ.
- Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, санхүүгийн нөхцөл байдал, бусадтай байгуулсан гэрээ хэлцэл болон бусад бодит байдлын талаар Андеррайтерт үнэн зөв мэдээлэх үүрэг хүлээнэ.
- Үнэт цаас гаргагч нь бэлтгэн өгч буй мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба мэдээллийн үнэн бодит байдалтай нийцээгүйгээс үүдсэн аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч хариуцна.
- Давхар бүртгэлтэй /Cross listing/ холбоотой хууль, журамд заасан шаардлагыг хангах, арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Андеррайтераас Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- Бусад

**Андеррайтерийн эрх, үүрэг**

- Андеррайтер нь үнэт цаас нэмж гаргах ажиллагааг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- Андеррайтер нь гэрээнд заасан үйл ажиллагаатай холбогдуулан Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгч, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, холбогдох журам, заавар боловсруулах, шийдвэр гаргахад хамтран ажиллана.
- Компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбогдон гаргах шаардлагатай тогтоол, шийдвэрийн төсөл, бусад холбогдох бичиг баримтын загварыг бэлтгэн өгөх үүрэгтэй.
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийг хөрөнгийн зах зээлтэй холбоотой аливаа мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч ажиллана.
- Андеррайтераар дамжуулан хувьцааны анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой ажиллагааг гүйцэтгэх
- Бусад

Үнэт цаас гаргагчийн андеррайтерийн байгууллагатай хийсэн гэрээний хуулбарыг хавсралт №20-оос, Андеррайтерийн дүгнэлтийг хавсралт №21-ээс үзнэ үү.

20210827

Бэлрүүл







ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН | TSX:ERD | MSE:ERDN |

тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэгтэй.

**Тусгай зөвшөөрөл**

Хүснэгт 25. Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл

Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл			
Нэр	Гэрчилгээ олгосон огноо	Гэрчилгээний дугаар	Эрхлэх үйл ажиллагаа
Сноу Хилл Консалтанси ХХН	2021.01.27	24	Зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх

Хүснэгт 26. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн хуульчдийн гэрчилгээ

Холбогдох хуульчдын тусгай зөвшөөрөл		
Овог нэр	Шүүхэд төлөөлөх гэрчилгээний дугаар	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний дугаар
Батаагийн Нямцэрэн	2070	17013
Сэрсийгийн Баясгалан	1083	20180511
Мөнхбаатарын Хулан	3016	38

Хуулийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт №22, 23-аас үзнэ үү.

2021.09.22

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Б.Серина





### 2.8.3. Хуулийн дүгнэлт

Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН нь Эрдэнэ Ресурсийн МХБ дээр нэмж хувьцаа гарган нийтэд санал болгох ажиллагаанд хуулийн зөвлөхөөр ажилласан.

Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН нь дараах хууль зүйн дүгнэлтийг гаргасан байна:

1. Эрдэнэ Ресурс болон түүний Монгол Улсад бүртгэлтэй компаниуд нь харьяалсан улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, хууль ёсоор бүртгэгдсэн байна.
2. Эрдэнэ Ресурс болон түүний Монгол компаниудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх нь хүчин төгөлдөр байна.
3. Эрдэнэ Ресурс болон түүний Монгол дахь компаниудын сүүлийн нэг (1) жилийн дотор хийсэн томоохон хэлцлүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.
4. Эрдэнэ Ресурс болон түүний Монгол компаниудын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр ЭРД болон Монгол компаниудын үйл ажиллагаанд бодитоор нөлөөлж болохуйц нөхцөл үүсээгүй байна.
5. Эрдэнэ Ресурс болон түүний Монгол компаниудын үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр, ямар нэг үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн нөхцөл үүсээгүй байна.
6. МХБ-д нэмж хувьцаа гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөл, мэдэгдлийг зохих ёсоор гаргасан байна.
7. Эрдэнэ Ресурс-ээс МХБ-д нэмж гаргаж буй үнэт цаасны өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна.

Хуулийн дүгнэлтийг Хавсралт №25-өөс үзнэ үү

2021.09.27

Баярмса





2.8.4. Хараат бус техникийн зөвлөх компани

Компанийн нэр: Roma Group Limited

Бүртгэлийн дугаар: F18341

Бизнес үнэлгээ  
ESG&Засаглалын тайлан

Үйл ажиллагааны чиглэл: Эрсдэлийн зөвлөх үйлчилгээ  
Санхүүгийн үйлчилгээ  
Байгалийн нөөцийн зөвлөх үйлчилгээ

Хаяг: 22/F, Хятад Улсын гадаадын барилга, 139 Hennesy Road, Wan Chai, Хонг Конг

Утас: +852 2529 6878

Roma Group Limited-н танилцуулга

Рома Групп Лимитед нь ХонгКонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани юм. Компани нь хөрөнгө, бизнесийн үнэлгээ зэрэг бүх төрлийн үнэлгээ, байгалийн нөөцийн зөвлөх үйлчилгээ, ESG (байгаль орчин, нийгэм, засаглал) тайлан гаргах, мөн үнэт цаасны арилжаа, хөрөнгө удирдлага зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг.

Үйлчилгээ:

- Хайгуулын төлөвлөгөө, талбай дээрх зөвлөгөө, хяналт
- Техникийн шинжилгээ, судалгаа
- Үйлдвэрлэлийн нөөц, геологийн нөөцийн тооцоолол
- JORC/NI43-101/ PRMS тайлагнал
- Геостатистикийн судалгаа
- Анхдагч үнэлгээ, Техник эдийн засгийн үнэлгээ
- IPO комплайнс судалгаанууд
- Санхүүгийн үнэлгээ болон шинжилгээ
- Хувьцааны чанарын болон тоон судалгаа
- Биологийн хөрөнгийн үнэлгээ
- Бизнесийн болон биет бус хөрөнгийн үнэлгээ
- Зээлийн болон эрсдлийн үнэлгээ
- Санхүүгийн хэрэгслийн үнэлгээ
- Байгалийн нөөцийн тооцоолол
- Худалдан авах үнийн хуваарилалт
- Маркетингийн стратеги
- Судлаачид & үл хөдлөх хөрөнгийн зөвлөх
- Урлагийн бүтээлийн үнэлгээ хийх

Хараат бус техникийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчидгээг дэлгэрэнгүйг Хавсралт №24-аас үзнэ үү.

2021.09.08

Б.Сергеев





## ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА

Компанийн бизнесийн шинж чанар, хөгжлийн өнөөгийн төвшнөөс хамаараад тус Компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх нь эрсдэлтэй байх магадлалтай. Компанийн үнэт цаасыг худалдан авахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

### 3.1. Эрсдэлийн хүчин зүйлс

#### 3.1.1. Эрдсийн хайгуул, ашиглалтын салбарын эрсдэл

Компанийн эрдсийн шинж чанар нь хайгуулын үр дүнгээс ихээхэн хамаарна. Хайгуулын салбар нь зардал өндөртэйгөөс гадна туршлага, мэдлэг болон судалгаа тооцооноос үл хамаарах эрсдэл үүсэх магадлалтай салбар юм. Олборлолтын үе шатнаас илүүтэйгээр хайгуулын үе шатанд энэхүү эрсдэл өндөр байдаг.

Эрдсийн нөөц, ордуудыг олж илрүүлэх үйл явц нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг бөгөөд үүний нэг нь хайгуулын ажилд оролцож буй мэргэжилтнүүдийн техникийн ур чадвар юм. Түүнчлэн, нэгэнт илрүүлсэн эрдсийн ордын ашиглалтын хугацаа нь тухайн ордын хэмжээ, агуулга, дэд бүтцэд ойр байдал, металлын үнэ, төр засгийн зохицуулалт, ялангуяа роялтигийн зохицуулалт, зөвшөөрөгдөх үйлдвэрлэл, эрдэс баялгийн импорт, экспорт, байгаль орчны хамгаалалтын зохицуулалт зэрэг голлох хүчин зүйлүүдээс хамаарна. Мөн уул уурхайн үйл ажиллагааны төрлөөс шалтгаалаад хүдрийн биетийг илрүүлсэн өрөмдлөгийн эхний үе шатнаас олборлолт эхлүүлэх хүртэл урт хугацаа ордог. Дээр дурдсан ихэнх хүчин зүйл нь Компанийн хяналтаас давсан хүчин зүйлс юм.

#### 3.1.2. Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл

Компанийн эзэмшиж буй хайгуулын төслүүдийн хайгуул, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь компанийн хамтын хөрөнгө оруулалт, өрийн санхүүжилт болон үнэт цаасны санхүүжилт татах чадвараас шалтгаална. Хайгуулын компаниуд хэрэгцээтэй байгаа санхүүжилтээ шаардлагатай хугацаанд босгох баталгаа байхгүй.


Үнэт болон суурь металлын зах зээл хэлбэлзэл өндөртэй байдаг тул өрийн санхүүжилт, аль эсвэл хөрөнгийн санхүүжилтийг компанид таатай нөхцөлөөр олох нь зарим тохиолдолд хүндрэлтэй. Мөн компанийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, улс төрийн байдлаас шалтгаалан өрийн санхүүжилт авах нь бэрхшээлтэй тул Компани үйл ажиллагаа, хайгуулын төлөвлөгөөг хойшлуулах, тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл буцаан хураалгах зэрэг эрсдэлүүд гарах магадлалтай.

#### 3.1.3. Монгол Улсын хууль, эрх зүйн орчны эрсдэл

Монгол Улс 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан тогтолцоонд шилжсэн. Энэхүү шилжилтийн хүрээнд ихээхэн ахиц дэвшил гарсан хэдий ч хууль, эрх зүйн орчин болон хуулийн үйлчлэлийн хүрээнд эрсдэл байсаар байна. Хууль тогтоомж, дүрэм журмууд батлагдан гарч буй боловч хэрэгжилт дээр хязгаарлалт байсаар байна. Түүнээс гадна төр, төрийн албаны хүнд суртал, авлигын асуудал ихээр байгаа нь хууль эрх зүй, түүний хэрэгжилтэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөөр байна. Уг нөхцөл байдал нь удаанаар боловч аажмаар өөрчлөгдөж байгаа нь эерэг үр дүн юм.

2021.09.27

Балрмал





Канад, Монгол Улсын хооронд 2016 оны 9 дүгээр сарын 8-нд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх Канадын хөрөнгө оруулагчдад илүү ил тод, тодорхой зохицуулалтыг бий болгох Канад-Монголын Гадаадын Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Гэрээг (ГХОДГ) байгуулсан. Канадын Олон улсын худалдааны сайд Франсуа-Филиппе Шампане 2017 оны 03 дугаар сарын 7-нд Гэрээ хүчин төгөлдөр болсныг албан ёсоор мэдэгдсэн.

Монгол Улсад уул уурхайн хайгуул, ашиглалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад засгийн газар болон улс төр, тэдгээрийн хяналтаас үүдэлтэй нөлөөллүүд бий болдог нь эрсдэл юм. Монгол улс болон Канад улсын хууль эрх зүйн ялгаатай байдлаас үүдэн хувьцаа худалдан авах, үнийн санал гаргах буюу компани нэгдэх, нийлэх, худалдан авах хэлцэл гарсан үед Канад улсын хууль тогтоомжийн дагуу зарласан хувьцааны 90% буюу түүнээс дээш хувийг худалдан авах бол худалдан авч буй этгээд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдахыг албадах эрхтэй. Компани нэгдэх, нийлэх, худалдан авах зарим томоохон хэлцлийг санал хураасан хувьцааны гуравны хоёрын баталснаар байгуулж болдог ба хэрвээ харилцан хамааралтай этгээдийн хэлцэл бол жижиг хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авна.

### 3.1.4. Тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрлийн эрсдэл

Компанийн хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх нь хүчин төгөлдөр байгаа боловч энэхүү эрх нь цуцлагдах, өөрчлөгдөхгүй гэсэн баталгаа байхгүй. Мөн гуравдагч талын маргаан, шаардлагаар компанийн эрхүүдэд эрсдэл үүсэх магадлалтай. Компани хайгуулын тусгай зөвшөөрлөө тухай бүрд сунгуулж, жилийн төлбөрийг төлдөг. Сунгуулах үйл явц нь хэдийгээр өндөр эрсдэлтэй биш боловч зарим тохиолдолд шинэ нөхцөл, болзлууд нэмэгдэх эрсдэл гарч болзошгүй.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны зорилго, зорилт ч мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшихтэй холбоотой зардлаас болж хойшилж болно. Мөн Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр байнга нэмэгдсээр ирсэн нь нэг төрлийн эрсдэл болж байна. Компани ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сунгуулах, төлбөр төлөх хугацаа, хайгуулын үр дүн болон холбогдох судалгаанд тулгуурлан зарим хайгуулын тусгай зөвшөөрлөө цуцлах зэрэг асуудалд тогтмол үнэлэлт дүгнэлт хийх шаардлагатай.

### 3.1.5. Дэд бүтэцтэй холбоотой эрсдэл

Компанийн Монгол дахь хайгуулын талбай нь цахилгаан, ус, байр, хүнс, тээвэр зэрэг үндсэн дэд бүтэцгүй, алслагдмал байршилд байрладаг. Компани ашиглалтын үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө шаардлагатай хүний нөөц бүрдүүлж, хайгуулын дэд бүтэц буюу байгууламжуудыг байгуулах шаардлагатай болно. Дотооддоо бэлтгэгдсэн боловсон хүчин дутмаг тул Компани гадны мэргэжилтнүүдийг Монголд авчирч ажиллуулах шаардлага гардаг. Компанийн Монгол дахь хайгуулын талбай байрлаж буй алслагдмал газруудад үйл ажиллагаа явуулахад шаардагдах байгууламжийг бий болгох, бүрдүүлэх шаардлагатай. Тохирох зохицуулалтыг хийж чадаагүйгээс Компанийн хайгуулын хөтөлбөрийн гүйцэтгэл саатаж, Компани тавьсан зорилгодоо хүрэхэд саад учрах эрсдэлтэй. Компанийн Монгол дахь ашигт малтмалын талбайнууд нь алслагдмал оршдогоос олборлолт эхлэхээс өмнө цахилгаан, ус, үйлдвэр, тээврийн дэд бүтцийн эх үүсвэрийг барьж байгуулах шаардлагатай болж байгаа нь Компанийн олборлох үйл ажиллагаанд ч нөлөөлөх магадлалтай. Ийм эх

Багсма



20210827



үүсвэр байхгүй байгаа нь олборлолтын боломжит байдалд сөргөөр нөлөөлөх төдийгүй Компанийн хувьд шаардлагатай санхүүжилтийг зохицуулах, хүрэлцэхүйц хангамж, төвийн болон орон нутгийн засаг захиргаанаас шаардлагатай зөвшөөрлүүдийг авах хэрэгцээ үүсэх бөгөөд эдгээрийн алинд нь ч баталгаа гаргах боломжгүй юм.

### 3.1.6. Үл даатгагдах эрсдэлүүд

Компани нь даатгалын хураамжийн зардал, эсвэл дотооддоо тогтоосон хязгаараас давсан хэмжээ болон өөр бусад шалтгааны улмаас даатгуулах боломжгүй, мөн даатгуулахгүй байхаар шийдвэрлэснээс аливаа гэнэтийн осол, аюулд өртөх эрсдэл үүсэх боломжтой. Даатгуулаагүйн улмаас үүсэх хариуцлага нь Компанийн санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болно.

### 3.1.7. Ашиг сонирхлын зөрчил


Компанийн тодорхой захирлууд болон албан тушаалтнууд нь ашигт малтмалын өөр бусад компанийн захирал, албан тушаалтан байх эсвэл тодорхой тооны хувьцаа эзэмшигч байх боломжтой бөгөөд Компанийн гэрээ хэлэлцээр хийсэн, хамтран ажилладаг бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй. Мөн бусад компаниуд ашигт малтмалын орд эзэмших эрхийг олж авахын төлөө Компанитай өрсөлдөх эрсдэл гарч болзошгүй. Аливаа ашиг сонирхлын зөрчил бий болсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилтэй байгаа захирал болон албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөө Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд мэдүүлэх шаардлагатай. Ашиг сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн болон дарга нь тухайн шийдвэрийн талаар аливаа санал өгөх эрхгүй байна. Зохих тохиолдолд Компани хэд хэдэн захирал, удирдлагатай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг хараат бус захирлуудаас бүрдсэн тусгай хороогоор хянан шийдвэрлүүлнэ.

### 3.1.8. Валютын эрсдэл

Компанийн санхүүжилтийн дийлэнх нь Канад доллараар хийгддэг боловч үйл ажиллагааны зардал болон бусад зардлууд Монгол төгрөг болон ам.доллараар хийгддэг. Гадаад валютын ханшийн хэлбэлзэл нь Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Түүнээс гадна Компани нь Монголын Хөрөнгийн Бирж болон Торонтогийн Хөрөнгийн Биржид давхар бүртгэгдэж байгаатай холбогдуулан валютын эрсдэл гарах магадлалтай. Үүнд Монгол төгрөг чангарах үед Канад доллараар үнэлэгдсэн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Компанийн үнэт цаасны үнэ буурах, эсрэгээр өсөх зэрэг эрсдэлүүд үүсэх магадлалтай.

### 3.1.9. Металын үнийн хэлбэлзэл, түүнээс үүсэх эрсдэл

Уул уурхайн салбар нь хүчтэй өрсөлдөөнтэй салбар тул ашигт малтмалын өндөр нөөц илрүүлсэн ч түүнийг борлуулах ашигтай зах зээл байна гэх баталгаа байхгүй. Компанийн ашигт малтмалыг ашигтай байдлаар олборлох боломжтой болсон үед металын үнэ өндөр байна гэх баталгаагүй. Энэхүү хүчин зүйлс нь нээж олборлосон аливаа ашигт малтмалын арилжаалагдах байдалд нөлөөлж болзошгүй юм. Металын үнэ олон улсын эдийн засаг, улс төрийн хандлага, инфляцын түвшин, дэлхийн болон бүсийн хэмжээний эрэлт хэрэгцээ, валютын ханшийн хэлбэлзэл, хүүгийн хувь хэмжээ, дэлхийн болон бус нутгийн хэрэглээний хэв маяг, олборлолт, үйлдвэрлэлийн дэвшилтэт аргаас шалтгаалсан эрсдэлтэй үйл



Б.Серма



ажиллагаа, нэмэгдсэн үйлдвэрлэл зэрэг олон хүчин зүйлээс хамаарч огцом хэлбэлзэн, өөрчлөгдөж байдаг.

### 3.1.10. Байгаль орчны болон зохицуулалтын шаардлагууд

Үйл ажиллагаа явуулж буй улс орны байгаль орчны зохицуулалт Компанийн үйл ажиллагаанд үйлчилнэ. Байгаль орчны хууль тогтоомж нь хатуу стандарт, шаардлага тавьж, хууль сахин биелүүлээгүй тохиолдолд өндөр хэмжээний торгууль, төлбөр ногдуулдгаас гадна санал болгож буй төслүүдэд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн захирал, албан тушаалтан, ажилтнуудын хариуцлагыг өндөрсгөсөн заалтууд бий болж байна. Цаашид байгаль орчны хууль тогтоомжид орох аливаа нэмэлт, өөрчлөлт нь Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн баталгаа байхгүй.

Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Энэхүү зөвшөөрлүүдийг аваагүйгээс Компани төлөвлөсөн хайгуул, судалгаа, ашиглалтын үйл ажиллагааг хойшлуулах эсвэл хязгаарлах эрсдэл гардаг. Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг зохицуулах одоогийн хууль тогтоомжуудад орох нэмэлт, өөрчлөлт, зохицуулалт, зөвшөөрлүүд, тэдгээрийн хэрэгжилт нь Компанийн материаллаг байдалд нөлөөлж, хөрөнгийн зардлыг нэмэгдүүлж, улмаар олборлолтын шинэ төсөл эхлүүлэх ажлыг хойшлуулж, саатуулж болзошгүй.


### 3.1.11. Боловсон хүчний эрсдэл

Чадварлаг боловсон хүчин авч ажиллуулах нь Компанийн амжилтад нэн чухал үүрэгтэй. Уул уурхайн төслийн эзэмшил, хайгуул, олборлолтын чиглэлээр туршлагатай боловсон хүчний тоо хязгаарлагдмал, өрсөлдөөн их байдаг. Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр санхүү, захиргаа, олборлолт, маркетинг, олон нийттэй харилцах гол мэргэжилтнүүд, ажилтнууд нэмж авч ажиллуулах шаардлагатай болно. Хэдийгээр Компани чадварлаг, туршлагатай боловсон хүчнийг татаж, авч чадна гэдэгтээ итгэлтэй байгаа ч үүнд баталгаа гаргах боломжгүй юм.

### 3.1.12. Улс төрийн эрсдэл

Монгол Улсын уул уурхайн салбар болон хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүйн нөхцөл байдал, улс төрийн тогтворгүй орчноос үүдэн Компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх магадлалтай. Хууль эрх зүйн өөрчлөлтүүд нь Компанийн хяналтаас гадуурх хүчин зүйл юм. Засгийн газрын тогтоол, дүрэм журмууд, үүнд уул уурхайн салбартай холбоотой үнийн зохицуулалт, экспортын зохицуулалт, орлогын албан татвар, өмч эзэмших эрхийг цуцлах, ажлын байр, газрын ашиглалт, усны ашиглалт, байгаль орчинтой холбоотой зохицуулалт болон уурхайн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд нь Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой. Одоогоор хууль эрх зүйн орчин нь байнгын өөрчлөлт дунд, хэрэгжилт болон үйлчлэх чадвар хязгаарлалттай байна. Компанийн үйл ажиллагаа нь дээрх нөхцөл байдлаас гадна эдийн засаг болон улс төрийн тогтворгүй байдал, бусад улсын хориг арга хэмжээ, терроризм, цэргийн хүч, бослого болон өндөр инфляц, валютын ханшийн өндөр өөрчлөлт зэргээс шалтгаалан эрсдэл хүлээх магадлалтай.

*Бүрмэ*





### 3.1.13. Уламжлалт эрсдэлүүд

Уул уурхайн үйл ажиллагааны хайгуул, олборлолтын шатанд аюулгүй байдлын эрсдэл тулгарах магадлалтай. Үүнд үйлдвэр, тоног төхөөрөмж, байгаль орчинд аюул учирч, улмаар хайгуул, олборлолтын гарц, үр дүнд нөлөөлж болзошгүй геологийн өвөрмөц тогтоц, чулуун нуранги, үер болон бусад осол, нөхцөл байдлууд багтана. Хэдийгээр эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авдаг ч энэ нь Компанийн үйл ажиллагаа, материаллаг байдалд нөлөөлж болохуйц эрсдэл юм.

### 3.1.14. Өрсөлдөөн

Уул уурхайн орд, нөөц эзэмших гэсэн өрсөлдөөн өсөн нэмэгдэж байна. Хүчин чадал сайтай, санхүүгийн болон техникийн нөөц боломж бүхий том хэмжээний, тогтворжсон компаниудтай өрсөлдөх магадлалтай бөгөөд үүний дүнд Компани өөрт хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлөөр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах, эрх эзэмших боломжгүй болох эрсдэлтэй. Үүнтэй адилаар Компани нэмэлт хайгуулын талбайд тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг авч чадна гэсэн баталгаа байхгүй.

### 3.1.15. Эзэмшлийн хувь буурах

Үнэт цаасны танилцуулгын хүрээнд гаргаж буй Энгийн хувьцааны нэгжийн үнэ нь Энгийн хувьцааны дансны үнээс өндөр тогтоогдоно.

### 3.1.16. Ковид-19-ийн нөлөөлөл

Энэхүү танилцуулга гарах өдөр дэлхийн эдийн засаг, олон улсын таваарын зах зээл, засгийн газар, эрүүл мэндийн байгууллагууд болон иргэн хувь хүн бүр Ковид-19 цар тахлын нөлөөлөл, тархалтыг бууруулахаар ажиллаж байна. Ковид-19 нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хувьд учирч болзошгүй эрсдэлд багтаж байгаа бөгөөд энэхүү танилцуулгыг танилцуулах үед эрсдэлийн нөлөөллийг бүрэн хэмжээнд тооцоолох боломжгүй байна. Ковид-19-ийн болзошгүй нөлөөлөлд: дэгдэлт тархсан бүс нутаг дахь ажилтан, албан хаагчдын ажил үйлчилгээнд хөл хорионы улмаас удаашрал, тасалдал үүсэх; тээвэр томиллолтод хязгаарлалт үүсэх; хөл хорио, вирусээс үүсэлтэй бусад эрсдэл багтаж байна. Танилцуулга гарах үеийн байдлаар компанид үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байгаа боловч ирээдүйд учирч болох нөлөөлөл, эрсдэлийг компани анхааралтай ажиглаж байна.

### 2.8.5. Бүтээн байгуулалттай холбоотой эрсдэл

Бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг багтаав. Үүнд: бүтээн байгуулалтад шаардлагатай материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, машин механизмтай холбоотой хомсдол, тээвэр, худалдан авалтын үнэ, өртөгт өөрчлөлт орох зэрэг эрсдэл учрах боломжтой. Дээр дурдсан эрсдэл нь компанийн үйл ажиллагаа, бизнес хөгжил, бүтээн байгуулалтад нөлөө үзүүлэх магадлалтай. Компанийн төсөл хөгжүүлэлт, ирээдүйн мөнгөн гүйлгээ, алт олборлолт зэрэг нь ашиглалтыг эхлүүлэх бүтээн байгуулалтын үеийн материал, тоног төхөөрөмжийн зах зээлийн үнэ, бэлэн байдал зэргээс хамаарна. Зарим барилга, бүтээн байгуулалтын орцын материалын өртөгт мэдэгдэхүйц, тогтвортой өсөлт гарсан тохиолдолд Компанийн тодорхой эсвэл материаллаг нөлөөлөл үзүүлэн, тооцоолоогүй зардал нэмэгдэх боломжтой.

*Б.Сермаа*



20210827



### 3. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Компани нь эрсдэлийн бодлогын дагуу эрсдэлийн удирдлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр зорьдог. Энэ нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд хэрэгждэг. Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй байлгах хүрээнд дотоод хяналт, бодлого болон журмуудыг тухай бүрд хянан хэрэгжүүлдэг.

2017 онд Компани нь санхүүгийн тайлагналын дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хянах хүрээнд олон улсын нягтлан бодох бүртгэлийн компаниар (Коллинс Барроу, Collins Barrow) дэлгэрэнгүй дүгнэлт гаргуулсан. Энэхүү дүгнэлтийн хүрээнд Компанийн санхүүгийн тайлагналын дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагад аливаа асуудал болон материаллаг алдагдал байхгүй хэмээн дүгнэсэн.

20210827

Бүрэлдэ

